



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



U
N
D
P

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ "МОНГОЛ УЛСАД
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ
ДЭМЖИХ НЬ" ТӨСӨЛ

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2024 он



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization



ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2024 он

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ГАРЫН АВЛАГА

Энэхүү “Төсвийн зарлагын шинжилгээний арга зүйн гарын авлага”-г Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭГДЭЛ **978-9919-9177-4-6**

Гарын авлагын агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү гарын авлагад ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт ЕХ, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ННА- 65
ДАА- 327

АГУУЛГА

ОРШИЛ	6
ЗОРИЛГО	8
ҮНДЭСЛЭЛ	8
ҮНДСЭН ХЭРЭГЛЭГЧИД	8

1. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН

ТУРШЛАГА	9
1.1. Төсвийн зарлагын шинжилгээний үндсэн ойлголт, хэрэгжүүлэгч байгууллагууд	9
1.1.1 Төсвийн зарлагын шинжилгээний төрөл, анхаарах гол асуудлууд, зарчим	9
1.1.2. Төсвийн зарлагын чиглэлээр институтүүдийн гүйцэтгэх үүрэг, харьцуулсан судалгаа	14
1.2.Төсвийн зарлагын шинжилгээний үндсэн онол, арга зүй	20
1.2.1.Үр дүнтэй байдлын шинжилгээ	20
1.2.2.Хуваарилалтын үр ашгийн шинжилгээ	21
1.2.3.Техникийн үр ашгийн шинжилгээ	25
1.2.4.Функциональ уялдаа холбооны шинжилгээ	27
1.3.Төсвийн зарлагын үр дүнд нөлөөлөх институтийн дүн шинжилгээ	28
1.4.Төсвийн зарлагын шинжилгээний олон улсын онцлох туршлагауд	32
1.5.Төсвийн зарлагын шинжилгээ хийх үе шатууд /ХАА-н салбарын хувьд/	35
1.5.1.Бэлтгэх үе шат	35
А.Зорилт, хамрах хүрээг тодорхойлох нь	36
Б.Төсвийн зарлагын шинжилгээнд хэрэглэгдэх дата, өгөгдлийг сонгох нь	37
1.5.2 Дүн шинжилгээ хийх үе шат	39
А.Салбарын зорилт, стратеги	39
Б.Хуваарилалтын үр ашгийн тооцоолол	40
В.Техникийн үр ашгийн тооцоолол	43
Техникийн үр ашгийн талаарх ойлголт	43
Г.Үр нөлөөний тооцоолол	47
Д.Орчны /Свот/ шинжилгээ	48
Е.Хяналт шинжилгээ, үнэлгээ	51
1.5.3.Түгээх үе шат	54

2.ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ, МОНГОЛ УЛСЫН ХУВЬД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

2.1.Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээний онцлог	56
2.2.Монгол Улсын төсөв, ХХААХҮ-ийн салбарын чиг хандлага	57
2.3. Төсвийн зарлагын шинжилгээнд хамаарлын тооцооллыг ашиглах нь	58

3. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙГ НЭГТГЭХ НЬ

Хавсралт 1. Хүснэгт 11-14	65
Хавсралт 2.Бодлогын баримт бичгийн төслийн өртгийг тооцоолох нь	72
НОМ ЗҮЙ	74

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
ОУВС	Олон улсын валютын сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЗШ	Төсвийн зарлагын шинжилгээ
ТЗМС	Төсвийн зарлагын мөшгөх судалгаа
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХАБТХ	Хүнсний хангамж, аюулгүй байдлын тусгай хөтөлбөр
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Төсвийн зарлагын шинжилгээний үр дүнтэй байдал: ЭЗХАХБ-ын гишүүнчлэлтэй улс орнуудад хийсэн судалгаа	6
Зураг 2: Үр ашиг, үр дүнтэй байдлын уялдаа холбоо	13
Зураг 3: Төсвийн зарлагын шинжилгээнд хэрэглэгдэх дата, өгөгдөл, мэдээлэл	38
Зураг 4: Хөдөө аж ахуйн салбарын орц, гарц, үр дүнгийн уялдаа холбоо	45
Зураг 5: Төсвийн зарлагын шинжилгээний тайланг зорилтот бүлгүүдэд хүргэх нь	55
Зураг 6: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага ба хөдөлмөрийн бүтээмжийн хамаарал	58


ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Үр дүнтэй байдлын шинжилгээ	20
Хүснэгт 2: Хуваарилалтын үр ашгийн шинжилгээ	21
Хүснэгт 3: Техникийн үр ашгийн шинжилгээ	25
Хүснэгт 4: Функциональ уялдаа холбооны шинжилгээ	27
Хүснэгт 5: Сайн засаглалыг оношлох асуултууд	28
Хүснэгт 6: Гондурас Улсын стратегийн баримт бичигт хийгдсэн төсвийн хуваарилалтын харьцуулалт, 2004	43
Хүснэгт 7: Ливан Улсын хөдөө аж ахуйн салбарын орчны/свот шинжилгээ	49
Хүснэгт 8: Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үндсэн мэдээлэл	60
Хүснэгт 9: Төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт, бодлогын бичиг баримт, Төсвийн тухай хуультай уялдах уялдаа	61
Хүснэгт 10: Төсөл, арга хэмжээний хэрэгжилт	61
Хүснэгт 11: Парламентын төсвийн шинжилгээний нэгжийн үүрэг /эх сурвалж/	65
Хүснэгт 12: ОУВС-аас санал болгож буй төсвийн зарлагын шинжилгээ хийх арга, аргачлал	66
Хүснэгт 13: ТЗШ-ний өгөгдөлд тавигдах шаардлага, шинжилгээний төрлүүд, зөвлөмж, эх сурвалж	71

1. ОРШИЛ

Төсвийн зарлагын шинжилгээ нь төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зарлагын үр ашиг, чанарыг дээшлүүлэх чухал хэрэгсэл юм. Төсвийн зарлагын шинжилгээний зорилго нь төсвийн зарлагын гүйцэтгэл, үр дүн, үр ашигт байдлыг үнэлсний үндсэн дээр төсвийн шинэ орон зай буюу¹ хэмнэлтийн хувилбаруудыг бий болгох, боломжит нөөцүүдийн үр нөлөөг өсгөхөд оршино.² Төсвийн зарлагын шинжилгээ нь улсын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцооны үндсэн нэг хэсэг бөгөөд өндөр хөгжилтэй орнуудад ихээхэн хэрэглэгдэх болсон. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) гишүүнчлэлтэй улс орнуудын 75-аас дээш хувь нь төсвийн зарлагын шинжилгээг жил бүр, тогтмол хийдэг.³ Хөгжиж буй орнуудын хувьд төсвийн зарлагын шинжилгээний үр ашиг, чанарыг сайжруулахын тулд төсвийн зарлагын шинжилгээг хийж ирсэн байна. (Жишээлбэл, Өмнөд Африк, Украин Улс).

Зураг 1. Төсвийн зарлагын шинжилгээний үр дүнтэй байдал: ЭЗХАХБ-ын гишүүнчлэлтэй улс орнуудад хийсэн судалгаа



Эх сурвалж. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (2019)

¹ <https://www.worldbank.org/en/country/egypt/publication/egypt-public-expenditure-review-for-human-development-sectors>

² <https://www.gov.br/casacivil/pt-br/assuntos/governanca/regulacao/eventos/2018/seminario-internacional-governanca-avaliacao-de-politicas-publicas-e-impacto-regulatorio/apresentacoes/painel-3/rafael-munoz-expenditure-reviews-may-2018-1.pdf>

³ ЭЗХАХБ. 2019. ЭЗХАХБ-ын гишүүнчлэлтэй улс орнуудын төсвийн зарлагын шинжилгээ

Төсвийн зарлагын шинжилгээний зорилго, төсвийн зарлагын шинжилгээнд баримталж буй арга, зарчим нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Зарим улс орнууд хөтөлбөр, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, төсвийн зарлагыг Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, нийт зарлагын түвшнийг хянах зэргээр төсвийн зарлагын шинжилгээг хийж ирсэн. Төсвийн зарлагын шинжилгээнд хяналт тавьж хэрэгжүүлсэн ЭЗХАХБ-ын орнуудын 80 орчим хувь нь төсвийн зарлагаа бууруулах зорилгоор, 90 орчим хувь нь төсвийн зарцуулалтыг дахин эрэмбэлэх зорилгоор төсвийн зарлагын шинжилгээг хийдэг гэж тус тус мэдээлсэн байна.

Нидерланд Улсын хувьд жил бүр гурваас долоон удаа төсвийн зарлагын шинжилгээ хийдэг бөгөөд төсвийн зарлагын нэгдсэн дүн шинжилгээг 1981, 2009 онуудад хийж байсан. Тухайлбал, Засгийн газраас 2009 онд төсвийн зарлагын шинжилгээ хийх шаардлагатай бодлогын тэргүүлэх 20 чиглэлийг тодорхойлж, 4 жилийн хугацаанд уг чиглэлийн хүрээнд төсвийн зарлагыг 20 хувиар бууруулах боломжит хувилбарыг боловсруулахаар холбогдох ажлын хэсэг ажиллаж байжээ. Үүний үр дүнд боловсруулсан хувилбарыг 2010 оны сонгуулийн үеэр намууд мөрийн хөтөлбөртөө тусгасан байна. Нидерланд Улсын төсвийн зарлагын шинжилгээний тогтолцооны гол шинж чанар нь төсвийн зарлагын шинжилгээ хийж буй ажлын хэсгийн хараат бус байдал юм. Төсвийн зарлагын шинжилгээний тайлан нь бие даасан, нарийвчилсан дүн шинжилгээнд суурилсан, улс төрийн нөлөөгүй байх бөгөөд санал, зөвлөмж нь одоогийн засгийн газрын хэрэгжүүлж буй бодлоготой зөрчилдсөн байр суурийг илэрхийлж болдог байна.⁴

Энэхүү гарын авлагын хүрээнд төсвийн зарлагын шинжилгээний онол, арга зүй, олон улсын туршлага, төсвийн зарлагын чиглэлээр институтүүдийн гүйцэтгэх үүргийн талаар танилцуулж, хэмнэлт, үр ашиг, үр нөлөө гэсэн гурван зарчимд үндэслэн Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэр (ХХААХҮ)-ийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ хийх арга аргачлал болон төсвийн зарлагын үр нөлөөнд шууд нөлөөлж байдаг төсвийн зарлагын институтийн чадавх, зохицуулалтыг үнэлэх шалгах хуудас, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Төсвийн зарлагын шинжилгээг хийснээр Засгийн газрын урт, дунд, богино хугацааны зорилт, бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, уялдаа холбоог нь хангахад дэмжлэг болж, төсвийн хуваарилалтыг сайжруулах, зарцуулалтын үр ашиг, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

⁴ ОУВС. 2022. Төсвийн зарлагын шинжилгээг хэрхэн хийх вэ?

ЗОРИЛГО

Төсвийн зарлагын шинжилгээний арга зүйн гарын авлага нь дараах үндсэн 2 зорилготой. Үүнд:

1. Нотолгоо, мэдээлэлд үндэслэн төсвийн зарлагын шийдвэр гаргахад төсвийн зарлагын шинжилгээг хийх арга зүй, мэдээллээр хангах;
2. Салбарын жишээн дээр үндэслэн төсвийн зарлагын шинжилгээг хийхэд хяналтын хуудасны дагуу зааварчилгаа өгөх болно.

Уг арга зүйн гарын авлагын зорилго нь улсын төсвийн зарлагын хэмнэлт, үр ашиг, үр дүнтэй байдлыг үнэлэхэд чиглэгдсэн нэгдсэн зааварчилгаа өгөхөд оршино.

ҮНДЭСЛЭЛ

Дараах хэрэгцээ, шаардлагуудад үндэслэн төсвийн зарлагын шинжилгээний арга зүйн гарын авлага боловсрууллаа. Үүнд:

- Төсвийн зарлагын шинжилгээ хийх заавар, журам, удирдамж хязгаарлагдмал байдаг. Төсвийн зарлагын шинжилгээний талаарх онол, арга зүй, олон улсын туршлагын талаарх цэгцтэй ойлголт, мэдээллийг өгөх;
- Төсвийн зарлагын шинжилгээ хийдэг холбогдох мэргэжилтнүүдийн мэдлэг, арга, туршлагыг баяжуулах, бататгахад дэмжлэг болох;
- Төсвийн зарлагын шинжилгээг бэлтгэхээс түгээх хүртэлх үе шатуудаар удирдан чиглүүлэх;
- Салбарын төсвийн зарлагын шинжилгээний чанарыг сайжруулах;
- Нөөц ашиглалтын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн зарлагын шинжилгээ хийж буй мэргэжилтнүүдийг арга зүйн удирдамжаар хангах.

Дүн шинжилгээ хийхэд шаардлагатай төсвийн зарлагын өгөгдөл, мэдээлэл хязгаарлагдмал, оролцогч талуудын оролцоо дутмаг зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан төсвийн зарлагын чиглэлээр өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилт үзүүлэх үр нөлөө жигд бус байсаар байна.

ҮНДСЭН ХЭРЭГЛЭГЧИД

- Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн зарлагын удирдлагыг хэрэгжүүлэгч төрийн албан хаагчид;
- Төсвийн зарлагын шинжилгээг хийхэд дэмжлэг үзүүлэх хандивлагч болон иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийт;
- Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, хувийн хэвшлийн шинжээчид.

1. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

1.1. Төсвийн зарлагын шинжилгээний үндсэн ойлголт, хэрэгжүүлэгч байгууллагууд

Олон улсын санхүүгийн хямралын дараа, ЭЗХАХБ-ын улс орнуудад төсвийн зарцуулалтын шинжилгээний хэрэглээ мэдэгдэхүйц өссөн. 2020 оны байдлаар ЭЗХАХБ-ын 37 орноос 31 орон (84%) зарцуулалтын шинжилгээг хийж байгаа гэж тайлагнасан байна⁵. Төсвийн зарцуулалтын шинжилгээ (Spending review) гэдэг нь төсвийн суурь зарлагыг системтэйгээр нарийвчлан шинжлэх замаар төсвийн хэмнэлтийн боломжит хувилбаруудыг тодорхойлох, үр дүнг үнэлэх үйл явц юм⁶.

Зарцуулалтын шинжилгээ нь дараах зорилготой. Үүнд:

- Засгийн газарт төсвийн зарлагын нийт хэмжээг удирдахад туслах
- Засгийн газрын тэргүүлэх чиглэлд төсвийн зардлыг дахин хуваарилах
- Бодлогын болон хөтөлбөрийн үр дүнг сайжруулах

Төсвийн зарцуулалтын шинжилгээ нь ерөнхийдөө агуулгын хувьд төсвийн зарлагын шинжилгээтэй (Public expenditure review) төстэй. Төсвийн зарлагын шинжилгээ нь төсвийн бүхий л процессыг хамардаг учраас төсвийн зарцуулалтын шинжилгээнээс илүү өргөн цар хүрээтэй юм. Төсвийн зарлагын шинжилгээ нь төрөөс хэрэгжүүлж буй төсвийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр ашиг, үр дүнтэй байдлыг судалж, шинжлэх үйл явц бөгөөд үр дүнд суурилсан төсвийн циклийн салшгүй нэг хэсэг болдог. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 75-аас дээш хувь нь төсвийн зарлагын шинжилгээг жил бүр, тогтмол хийдэг⁷.

1.1.1 Төсвийн зарлагын шинжилгээний төрөл, анхаарах гол асуудлууд, зарчим

Иж бүрэн шинжилгээ: Тухайн салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлд хийсэн нарийвчилсан шинжилгээг хэлнэ. Төсвийн зарлагын шинжилгээг төсвийн зарлагын гүйцэтгэл, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үнэлгээ зэрэгт үндэслэн хийдэг.⁷

Сэдэвчилсэн шинжилгээ: Дэд салбар, хөтөлбөр, тодорхой нэг асуудлын хүрээнд нарийвчилсан шинжилгээ хийнэ.

Эдгээр шинжилгээнээс алийг нь хийх эсэхийг сонгохдоо хэрэгцээ, шаардлага, тухайн үеийн нөхцөл байдал, шинжилгээ хийх боломжит нөөц зэргийг харгалзана. Уг шинжилгээний эцсийн зорилго нь зарлагын гүйцэтгэлийн үр дүн, чанарыг сайжруулах, улмаар төсвийн зарлагын хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг дээшлүүлэхэд оршино.

⁵ Spending Review Survey. OECD, 2020

⁶ Spending reviews: Some insights from practitioners, Discussion Paper No. 135, European Commission, Brussels, 2020

⁷ Fiscal-sustainability of health systems spending reviews note, OECD <https://www.oecd.org/gov/budgeting/Fiscal-sustainability-of-health-systems-spending-reviews-note.pdf>

Төсвийн зарлагын шинжилгээнд анхаарах асуудлууд

Төсвийн зарлагын шинжилгээнд дараах асуултуудын хариултад байнга анхаарлаа хандуулж байх нь⁸ чухал гэж үздэг. Үүнд:

1. Салбарын төсвийн зарлагын санхүүжүүлэх эх үүсвэрийг хэрхэн, хаанаас бүрдүүлж байна вэ?
2. Засгийн газраас хэдий хэмжээний төсөв хуваарилагдаж төсвийн хөрөнгийг юунд зарцуулсан бэ?
3. Төрийн санхүүгийн удирдлага нь санхүүгийн үр дүнтэй байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж чадаж байна уу?
4. Төрөөс баримталж буй бодлого стратегийг хэрэгжүүлэхэд одоогийн санхүүжилт нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх, дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд санхүүгийн тогтвортой эх үүсвэр байгаа эсэх?
5. Төсөв, хөрөнгийн нөөцийг үр ашигтай, үр дүнтэй байдлаар зарцуулж байна уу?
6. Төсвийн зардал нь тэгш байдлыг дэмжиж байна уу?

АСУУЛТЫН ТАЙЛБАР:

Асуулт 1-2: Төсөв, санхүүгийн тогтолцоо нь улс орны тухайн салбарт төрөөс хийж буй хөрөнгө оруулалтын үндэс суурь юм. Эдгээр асуултууд нь ТЕЗ-ийн төсвийн зардал хэрхэн санхүүждэг, хэн хэрхэн шийдвэр гаргаж, юунд зарцуулдаг зэрэг асуултуудаас бүрдэнэ.

Асуулт 3: ТЕЗ-ийн санхүүгийн хариуцлагатай байдал нь төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоонд чухал ач холбогдолтой төдийгүй Засгийн газрын бодлогын зорилтыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгосон эсэхийг үнэлнэ.

Асуулт 4: ТЕЗ-ийн санхүүжилтийн хүрэлцээ нь төрөөс баримталж буй бодлого, стандартыг харгалзан “Санхүүжилт ямар хэмжээнд байвал хэрэгцээг хангаж чадах вэ?” гэсэн асуултад хариулт өгнө. Тухайн салбарын санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах үүднээс улс орны макро эдийн засгийн нөхцөл байдал, хэтийн төлөв, салбарын бодлого, хүн ам зүйг харгалзан тухайн салбарт зарцуулахаар төлөвлөж буй зардлын хэмжээг урт хугацаанд үнэлж тогтооно.

Асуулт 5: ТЕЗ-ийн санхүүжилтийн үр ашиг, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд тухайн улс орны хөгжлийн тодорхой үе шатыг харгалзан гарц, үр дүнгээр хэмжигдэх, хамгийн их өгөөжтэй үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

Асуулт 6: Тухайн салбарын зарлага, санхүүжилтийн нэг зорилго нь үр шим хүртэгсдэд төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх явдал юм.

Төсвийн зарлагын шинжилгээний зарчим

Төсвийн жилийн туршид зарцуулах зардлыг хэмнэлт, үр ашиг, үр дүнтэй байх зарчимд үндэслэн стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлж, хуваарилдаг.

Төсвийн зарлагын шинжилгээг хийхдээ дараах 3 зарчимд үндэслэнэ. Үүнд:

1. Хэмнэлтийн зарчим

Зардлыг хамгийн бага байлгах, ингэхдээ хамгийн боломжит үнэ, зохистой чанар, шаардлагатай тоо хэмжээгээр тогтоосон хугацаанд бэлэн байлгахад чиглэгдэнэ. Хэмнэлт, үр ашиг, үр нөлөөний тодорхойлолтод гарцыг авч үзэх бөгөөд “Нөөцийг хэр сайн ашиглаж байна вэ?” гэсэн асуултад хариулна.⁹

Хэрэгжилтэд зарцуулж буй нөөцийн өртөг хэр буурч байгаагаар авч үзнэ. Нөөцийн бэлэн байдал нь тодорхой хугацаанд шаардагдах тоо хэмжээгээр байхаас гадна үнийн хувьд хамгийн тохиромжтой байх хэрэгтэйг илэрхийлдэг.

2. Үр ашигтай байх зарчим

Боломжит нөөцөөс хамгийн их үр ашиг хүртэхийг хэлнэ. Энэ нь чанар, тоо хэмжээ, хугацааны хувьд ашиглаж буй нөөц, хүрсэн үр дүнгийн хоорондох харилцан хамаарлаас шалтгаална. Үр ашигтай байх нь нөөцийг хамгийн дээд хэмжээнд хангалттай ашиглаж чадсан эсэх, аль эсхүл бага нөөцөөр төлөвлөсөн үр дүнд хүрч чадсан эсэх дээр төвлөрнө. Үр ашигтай байх зорилгоор орц болон гарцын хоорондын уялдаа холбоог дараах асуултуудад үндэслэн үнэлдэг. Үүнд:

- Бид орцоосоо тоо хэмжээ болон чанарын хувьд хамгийн их гарцыг авч байгаа юу?
- Бага орцоор адилхан гарц авч болох байсан уу?
- Бодлогыг хэрэгжүүлэхэд зориулсан нөөцийг шууд үр дүн болгон хувиргаж буй үйл явц ямар байна вэ? (тоо хэмжээ, чанар, хугацааны хувьд ашигласан нөөц болон бий болгосон гарцын харьцаа)
- Нөөцийг хэр зохистой ашиглаж байна вэ?

Үр ашигтай байх нь Засгийн газар, иргэний нийгэм, үр шим хүртэгчид зэрэг бүхий л оролцогч талуудын хувьд чухал ач холбогдолтой тул хязгаарлагдмал нөөцийг зохистой ашиглаж чадсанаар Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд үр дүнд хүрч ажиллах нөхцөл бүрдэнэ. Үр ашигтай байх зарчмын хувьд төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрүүд, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны талаарх шийдвэрүүдтэй холбоотой мөнгөний үнэ цэний талаар илүү нарийвчлан хянаж үзэх шаардлагатай. Түүнчлэн бодлогыг хэрхэн боловсруулсан, төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулж, уг үйл явцад хэн хяналт тавьж байгаа болон хяналт тавихтай холбоотой шийдвэр гаргахад хэний саналыг харгалзан үзэх зэргийг тодорхойлох нь чухал юм.

Үр ашгийг хэмжихэд уламжлалт эдийн засгийн аргачлал буюу зардал, үр ашгийн шинжилгээ, өгөөжийн түвшин, жишиг харьцуулалт зэрэг арга хэрэгслийг ашиглах нь үнэлгээний зорилго, хөндлөнгийн оролцоо, зорилтот бүлэг, төлөвлөсөн үр дүн, боломжит өгөгдөл, нөөц зэрэг хүчин зүйлсээс хамаарна.

Үр ашгийг хэмжихэд тулгарч болзошгүй дараах хүндрэлүүд байдаг. Үүнд:

⁹ Олон улсын аудитын дээд байгууллага. Олон улсын аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300

Үр ашиг, түүнийг хэмжих арга хэрэгслүүдийн талаарх ялгаатай ойлголтууд

Үр ашиг, хэмнэлт нь өргөн цар хүрээтэй ойлголтууд бөгөөд шинжилгээний явцад аль арга, хэрэгслийг ашиглах нь илүү тохиромжтой эсэхийг тухайн шинжилгээний цар хүрээнээс хамааруулан шийдвэрлэх нь зүйтэй.

Өгөгдөл ба хэмжигдэхүүн

Үр ашиг, үр дүн, зардалтай холбоотой мэдээлэл олоход хүндрэлтэй байж болзошгүй юм. Жишээлбэл, нөлөөллийн үнэлгээ нь хөндлөнгийн оролцоо/тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх/ үр дүнд гарсан тоон өөрчлөлтийн тооцоог гаргахад чиглэгдэнэ.

Цаг хугацаа

Нөөцийг ашиглах болон тухайн үр дүнд хүрэхэд шинжилгээг (эдийн засгийн үнэлгээ, үр ашгийн үнэлгээ) хийх хугацааг тодорхойлох хэрэгтэй. Зардал нь олон жилийн туршид хуримтлагдаж болох бөгөөд хөтөлбөрийн эсвэл үнэлгээний явцад бодит үр ашгийг хэмжих нь тухайн төсвийн хуваарилалтын хүлээгдэж буй үр дүнг бүрэн тусгахгүй байх эрсдэлтэй.

3. Үр нөлөөтэй байх зарчим

Дэвшүүлсэн зорилтыг биелүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрэхтэй холбоотой зарчим болно. Бодлогын арга хэмжээ нь бодлогын зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж буй хэр хэмжээ (тогтоосон зорилгод нийцэж, зорьсон үр дүнд хүрэх)-г харуулна.

Үр нөлөөтэй байх зарчим нь Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого зорилгодоо хүрч чадаж байна уу?, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого нь ямар өөрчлөлтийг бий болгож байна вэ? гэсэн асуултуудад хариулт өгдөг.

Мөнгөний үнэ цэнэ ба нөлөөлөл: Тухайн бодлого нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг эсвэл сөрөг, зорилтот эсвэл зорилтот бусаар ямар үр нөлөөнд хувь нэмэр оруулсан бэ? Бодлогын үр дүнгийн ерөнхий нөлөөл ямар байсан бэ?

Нөлөөлөл: Бодлого нь эмзэг нөхцөлд байгаа болон эмзэг бүлэгт хамаарах хүн аманд (нас, орлого, жендер, яс үндэс гэх мэтээр нь ялгаж болно) зорилтот эсвэл зорилтот бус, эерэг эсвэл сөрөг ямар байдлаар нөлөө үзүүлсэн бэ?

Үр нөлөөтэй байдал гэдэг нь үйлдвэрлэсэн гарцын хувьд бодлогын зорилгодоо хүрэх цар хүрээний талаарх ойлголт юм. Энэ нь нэг талаас зорилго, зорилт, гарц хоорондын уялдаа холбоо, нөгөө талаас схемд харуулсанчлан дэвшүүлсэн зорилтууд ямар түвшинд биелсэн болон зорилтоос салбарласан бодлого, арга хэмжээний гарц, үр дүнтэй хамаатай ойлголт.

Ямар түвшинд хөтөлбөр эсхүл бодлогуудын зорилтууд хэрэгжсэн байгааг гарц эсхүл үр дүнгийн харьцуулалтаар тодорхойлно.

Үр нөлөөтэй байдлыг олон аргаар хэмжиж болно. Хамгийн боловсронгуй арга зүй

нь бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнөх болон дараах нөхцөл байдлыг харьцуулах бөгөөд бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд шууд оролцдоггүй хяналтын бүлгийн онцлогийг үр нөлөөтэй байдалд нөлөөлөгч хүчин зүйл гэж авч үздэг.

Зарим үед бодлого, хөтөлбөр болон нөлөөлөл хоорондын шалтгааны уялдаа холбоог шинжлэхэд “ямар нөхцөлд, хэнд зориулж, ямар ажлыг” зэрэг асуултад хариулж чанарын судалгаа хийх нь илүү тохиромжтой. Түүнчлэн дүн шинжилгээний хүрээнд ашигласан арга зүйн давуу тал болон хязгаарлалтыг тодорхойлох нь чухал.

Зураг 2: Үр ашиг, үр дүнтэй байдлын уялдаа холбоо



Үр ашиг, үр дүнтэй байдлын уялдаа холбоог харуулав (Зураг 2). Энэ схемд орц гэж төрийн үйл ажиллагаанд (төрийн чиг үүрэг, бодлого, тогтолцоо, төлөвлөгөөний хэрэгжилт, хөтөлбөр, үйл ажиллагаа, зохион байгуулалт) хэрэглэсэн санхүүгийн, хүний болон материалын нөөцийг хэлнэ. Гарц нь төрийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, хөрөнгө, бараа болон үйлчилгээг хэлнэ. Харин үр дүн гэдэг нь гарцын хүрэх магадлалтай эсхүл хүрсэн үр нөлөө, өөрчлөлт юм. Эдгээр нь богино, дунд, урт хугацааны байж болно.¹⁰

Үр нөлөөтэй байдалд үнэлгээ хийхэд төлөвлөсөн үр дүндээ зохих түвшинд (үр дүн, зарим тохиолдолд үр нөлөө гэх) хүрсэн эсэхийг тогтооход чиглэнэ. Хэрэв үйл ажиллагааны тодорхойлсон зорилтууд эсвэл төлөвлөсөн үр дүн нь тодорхой бус эсвэл хөндлөнгийн оролцоог хангах явцад түүнийг шинэчилсэн бүтцийн өөрчлөлтийг тухай бүр тусгаагүй бол үйл ажиллагааны үр нөлөөг хэмжихэд хүндрэлтэй нөхцөл байдал үүснэ. Үр нөлөөг хэмжихэд интервенцийн үр дүнг шинжилж, нягтална.

¹⁰ Европын комисс, Эдийн засаг, санхүүгийн асуудал эрхэлсэн ерөнхий газар. 2014. Төсвийн зарлагын шинжилгээний төлөвлөлт, хэрэгжүүлэлт

Үр дүнтэй байдал нь хөндлөнгийн оролцооны зорилго, тухайлбал гарцын түвшинд үр дүнд хүрсэн эсэхийг авч үздэг. Үр дүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлах нь хөндлөнгийн оролцоо яагаад зорилгодоо хүрсэн эсвэл хүрээгүй эсэх, оролцогч талуудад цаашид сайжруулах, анхаарах шаардлагатай ямар асуудал байгааг тодорхойлоход илүү ач холбогдолтой. Хөндлөнгийн оролцоонд дотоод болон гадаад хүчин зүйлс нөлөөлнө. Эдгээр нь удирдлага, хүний нөөц, санхүүгийн хүчин зүйлс, хууль, эрх зүйн зохицуулалт, төлөвлөсөн түвшинд хүрээгүй хэрэгжилт зэрэгтэй холбоотой. Хэрэгжилтийн явцад үр дүнтэй байдалд нөлөөлөх хамгийн гол хүчин зүйлсийг авч үзэх нь зүйтэй. Мөн үр дүнтэй байдал нь янз бүрийн бүлгүүдийн хоорондын тэгш байдлыг тусгайлан авч үздэг. Шинжилгээний баг, үр шим хүртэгчдийн бүлгүүдэд хөндлөнгийн оролцоо хэр хүртээмжтэй байсан, ялгаварлан гадуурхахгүй байх, хариуцлагатай байх зэрэг үндсэн зарчмуудыг бүхий л үе шатуудад хэрхэн тусгасныг авч үзэх шаардлагатай.

Үр нөлөөтэй байдлыг хэмжихэд тулгарч болзошгүй хүндрэлүүд:

- **Мэдээллийн хязгаарлагдмал байдал**

Мэдээллийн хүртээмжтэй бус байдал нь тухайн зорилтод хүрсэн эсэхийг хэмжих, мөн учир шалтгааны хамаарлыг тодорхойлоход хүндрэл учруулдаг.

- **Тодорхой бус эсвэл хэмжихэд хүндрэлтэй зорилго/зорилтууд бүхий бодлогын баримт бичиг**

Дүн шинжилгээний эхний үе шатанд хөндлөнгийн оролцооны зорилтууд оновчтой эсэх, хөгжлийн олон улсын стандарттай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Зорилгодоо хүрсэн эсэхийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд нь SMART (тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, бодитой, цаг үеэ олсон) зэрэг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу баталгаажсан байх нь зүйтэй.

1.1.2. Төсвийн зарлагын чиглэлээр институтүүдийн гүйцэтгэх үүрэг, харьцуулсан судалгаа

1.А.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн үйл ажиллагаа хууль, эрх зүйн дараах зохицуулалтын хүрээнд явагдаж байна. Үүнд:

- Үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- УИХ-ын тухай хууль
- УИХ-ын чуулганы дэгийн тухай хууль
- Аудитын тухай хууль
- УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол улсын их хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө
- Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжууд

Тус хэлтэс дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

1. Улсын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт, шинжилгээ хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
2. Байнгын хороодод харьяалагдах тухайн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн зардлыг эдийн засгийн ангиллаар нь гаргаж, дэлгэрэнгүй судалгаа, тооцоо, танилцуулга бэлтгэн Байнгын хороо, гишүүдийг мэдээллээр хангах;
3. Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, гадаад худалдаа, мөнгөний бодлого, төсвийн зарлага, төсвийн хөрөнгө оруулалтын явцын талаар мэдээлэл бэлтгэх, Байнгын хороод, гишүүдийг мэдээллээр тогтмол хангах;
4. Улсын төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлтэй нийцсэн эсэх талаар санал, дүгнэлт гаргаж холбогдох Байнгын хороодод хүргүүлж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
5. Улсын төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл нь бодлого, төлөвлөлтийн бусад баримт бичигтэй нийцсэн эсэхэд төсвийн шинжилгээ хийж, дүгнэлт гарган Байнгын хороодод хүргүүлж мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай тооцоолол, судалгаагаар шуурхай хангах;
6. Улсын төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын санал авсан төсвийн санал нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлээгүй байх шаардлагыг хангасан эсэх болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх талаар дүн шинжилгээ хийж холбогдох байнгын хороонд хүргүүлэх;
7. Өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төсөлд хавсаргасан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хянах, үр нөлөөний үнэлгээ хийх, тухайн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт зардал шаардагдахаар бол энэ талаар санал, дүгнэлт гаргаж, холбогдох байнгын хороо, ажлын хэсэгт танилцуулах;
8. Хууль, тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх болох хэлэлцүүлгийн явцад “Хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо” өөрчлөгдөх нөхцөл байдал үүссэн бол энэ талаар санал, дүгнэлт гаргаж, холбогдох Байнгын хороо, ажлын хэсэгт танилцуулах;
9. Байнгын хорооноос төсөв, санхүү хөрөнгө оруулалтын асуудлаар хийх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хангахад мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;
10. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын бичиг

баримтуудын төсөл, батлагдсан бодлогын бичиг баримтуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төсвийн хяналтын сонсголыг Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтэстэй хамтран зохион байгуулах.

Дэлхийн улс орнуудад Парламентын төсвийн хяналт шинжилгээний албаны гүйцэтгэх үүрэг, хийж хэрэгжүүлдэг үйл ажиллагааны жагсаалтыг боловсруулж гаргахдаа нийт 20 гаруй орны туршлагыг судалсан бөгөөд ашигласан эх сурвалжийг хавсралтад харуулав.

1.б.Парламентын төсвийн хяналт шинжилгээний албаны гүйцэтгэх үүрэг, хийж хэрэгжүүлдэг үйл ажиллагаа/Олон улсад/

Парламентын засаглалтай улс орнуудын парламентын төсвийн хяналт шинжилгээний нэгж дараах үндсэн үйл ажиллагаануудыг эрхлэн явуулдаг болох нь судалгаанаас харагдсан. Үүнд:

- Шинжилгээ хийх;
- Мэдээллийн бааз бүрдүүлэх, олон нийттэй харилцах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Хяналт тавих;
- Хууль, тогтоомж, бодлогын өртөг тооцоололт, хөтөлбөрийн зардал, үр ашгийн шинжилгээ хийх;
- Үйлчилгээ үзүүлэх, судалгааны ажлаар үйл ажиллагааны үр дүнг дэмжих.

Эдгээрээс төсвийн зарлагын шинжилгээтэй хэсгийг нь сонгож харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Засгийн газрын жилийн төсөв, эдийн засгийн суурь нөхцлүүдийн төсөөлөлд дүн шинжилгээ хийх, ирээдүйг ялгаатайгаар таамаглах, сар, улирлын эдийн засаг, төсвийн мэдээг нийтлэх;
- Төсвийн хэтийн төлөв, нэмэлт зардал, татвар, эдийн засгийн гүйцэтгэлийг тогтмол шинжлэх;
- Үндэсний эдийн засгийн хөгжлийн бодлогын санал, хувилбарт шинжилгээ хийх;
- Макро эдийн засгийн зорилтуудын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, тэргүүлэх хэрэгцээ, хөгжлийн чиглэлд үндэсний нөөцийг оновчтой ашиглаж байгаа эсэхийг үнэлэх;
- Засгийн газрын хөтөлбөрүүдийн дунд, урт хугацааны үр нөлөөг үнэлэх;
- Засгийн газрын хөтөлбөрүүдэд зарцуулж буй олон жилийн зардлын хувь хэмжээ, онцлогийг тодорхойлж яамны бодлогод шинжилгээ хийх, үндэсний хэмжээний зорилго, зорилтуудыг хангахад нөөцийг хуваарилж чадаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх боломжийг парламентын гишүүдэд олгох, үндэсний давуу талуудыг тусгасан төсвийн хүрээг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх;
- Зардал бууруулах саналыг гаргах;
- Хууль, тогтоомжийн эдийн засгийн үр нөлөөг тооцож, хэрэгцээтэй мэдээллээр хангах;
- Дунд хугацааны төсвийн хүрээ, дунд болон урт хугацааны төсвийн төсөөллийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, урт хугацааны тогтвортой байдал, нэг

үеэс нөгөөд чиглэсэн нөөцийн шилжилт, хүн амын насжилтаас шалтгаалсан урт хугацааны төсвийн чиг хандлагын шинжилгээ хийх;

- Засгийн газрын төсвийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын төслийн зураглал, төсвийн дүн шинжилгээг хийж, УИХ-д улирал тутам гүйцэтгэлийн тайлан гаргаж, төсөв, эдийн засгийн мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэж, төсвийн тухай хууль тогтоомж, хяналтын талаар УИХ, байнгын хороодод зөвлөгөө өгөх;
- Төсвийн харилцааг зохицуулах дүрмийн биелэлт, төсвийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвтэй холбоотойгоор чуулганаар хэлэлцэж баталсан асуудал, тайланг нэгтгэн гаргах, төсвийн бодлогын мэдэгдэлд тусгагдсан төсвийн хариуцлагын зарчим, санхүүгийн зорилтууд, УИХ-д өргөн мэдүүлсэн эдийн засаг, санхүүгийн үр нөлөө бүхий хуулийн төслийн талаар УИХ-ын холбогдох хороодод мэдээлэх;
- Бодлого, хөтөлбөрийн саналууд, улс төрийн томоохон намуудын сонгуулийн үйл ажиллагааны зардал тооцох, сонгуулийн амлалтын санхүүгийн үр нөлөөг үнэлэх, төсөвт чухал нөлөө үзүүлэх хуулийн төсөл болон засгийн газрын саналын санхүүгийн зардлыг тооцож, УИХ-аас нотлох баримтад суурилсан, иргэдэд чиглэсэн оновчтой бодлого гаргахад нь дэмжлэг үзүүлэх;
- Зардал тооцох арга зүйг боловсруулах;
- УИХ-ын гишүүдийн өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн зардлын тооцоо, хуулийн төсөл, бодлогын саналын өртөг, үр ашгийн дүн шинжилгээ хийхэд ашиглах мэдээллийн санг бүрдүүлэх;
- Төсөвт хамгийн их нөлөөлөл үзүүлэх боломжтой саналуудын зардлыг тооцох, эсвэл зөвхөн бүхэл бүтэн хороо эсвэл чухал бөгөөд дэд хороогоор батлагдсан саналуудын зардлыг тооцох;
- Парламентын мэдлэгийн суурийг дэлхийн түвшинд хүргэж бэхжүүлэх зорилгоор эдийн засгийн бодлогын сэдвүүд, салбарын хөгжил, олон улсын эдийн засгийн бодлогын хөгжил, худалдааны эдийн засгийн чиглэлээр тасралтгүй судалгааны санаачилга гаргах, тодорхой сэдвүүдээр аналитик судалгаа хийх;
- Шаардлагатай үед аль нэг санхүүгийн жилийн хувьд төсвийн чиглэлээр баримтлах ялгаатай дүрмүүдийг санал болгох;
- Засгийн газрын хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн хэмжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг судалж, үнэлэх;
- Төрийн санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, төрийн санхүүд нөлөөлөх саналуудын санхүүгийн агуулгыг тодорхойлох;
- Засгийн газрын санал болгож буй бодлого, худалдан авалт, хуулийн төслүүдтэй холбоотой эрсдэлийн талаар тайлан гаргах.

УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс нь зарлагын шинжилгээг салбарын түвшинд ихэнх тохиолдолд нарийвчлан хийдэггүй, харин нэгдсэн төсвийн зардлын болон тухайн салбарт хуваарилагдсан зардлын хууль, эрх зүйн орчны нийцлийг тодорхойлдог. Түүнчлэн төсвийн зардал, түүний эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хөгжлийн бодлогын бичиг баримтуудтай нийцэх нийцэл, эдгээр бичиг баримтуудын хэрэгжилтээр дамжуулан төсвийн үр нөлөө, ялангуяа макро эдийн засаг, санхүүгийн орчинд үзүүлэх нөлөөллийг тооцдог. Түүнчлэн хөгжлийн бодлогын төлөвлөлтийн бичиг баримтууд, тэдгээрт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бусад нэгжүүдтэй хамтран дэлгэрэнгүй шинжилдэг. Олон улсад ч ийм хандлагатай байдаг байна.

2.а.Монгол Улсын Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Монгол Улсын хувьд энэхүү байгууллага нь дараах үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон явуулж байна. Үүнд:

- Санхүү, төсвийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Санхүүгийн салбарын зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах; Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;
- Гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсронгуй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод хяналтын бодлого, удирдлагаар хангах;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах;
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын Танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх.

2.б.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /Олон улсад¹⁾/

Монгол Улсын төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн удирдлагын чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудынхтай ойролцоо байгаа юм. Ялангуяа төсвийн зарлагын шинжилгээний чиглэлээр төсвийн төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсвийн дунд, урт хугацааны төсөөлөл хийх зэрэг үйл ажиллагааг явуулж байгаа нь сонгож судалсан орнуудынхтай ижил байна. Монгол Улсын төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр төсвийн төсөл бэлтгэх удирдамжийг боловсруулж гаргадаг.

¹⁾ The Evolving Functions and Organization of Finance Ministries; by Richard Allen, Yasemin Hurcan, Peter Murphy, Maximilien Queyranne, and Sami Yläoutinen; IMF Working Paper WP/15/232; November 2015

Тус удирдамжид төсөв, санхүүгийн төлөвлөлтийн үзүүлэлтээс гадна төсвийн төсөл нь хөгжлийн бодлогын бичиг баримтуудад чиглэсэн эсэхийг харуулсан шалгах хуудсыг тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл төсөв, санхүүгийн төлөвлөлт нь үйл ажиллагааны төлөвлөлттэй нягт уялдсан байдлаар төсвийн төсөл боловсрогдох учиртай байдаг. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д *“төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;*” хэлнэ гэж заасан.

Төлөвлөлтийн нэгдмэл байдал, бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдааг хангахад төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагуудын чиг үүрэг тодорхой, үйл ажиллагааны уялдаа холбоо нягт, хяналт, шинжилгээний шалгуур үзүүлэлт, хариуцлага, урамшууллын тогтолцоо нь ойлгомжтой байх ёстой.

Зарим оронд тухайлбал Болив улсад хөгжлийн төлөвлөлт хариуцсан тусдаа яам¹² байдаг бол Замби улсад санхүү болон үндэсний хөгжлийн төлөвлөлт хариуцсан бие даасан төрийн захиргааны төв байгууллага¹³ байдаг байна.

Иймд Сангийн яам буюу төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын зарлагын шинжилгээг шууд хийж гүйцэтгэх үүрэг хүлээдэггүй, харин төсвийн эдийн засаг, санхүүгийн орчинд үзүүлэх нөлөөллийг түлхүү тооцож, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахыг зорьж ажилладаг.

3.а.Монгол Улсын бусад төрийн захиргааны төв байгууллага

Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын үүрэг, үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлж¹⁴ заасан байдаг. Энэ нэгж нь яамны үйл ажиллагааны 8 дугаар зорилтын хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн **салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөв боловсруулах**, хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн байдлыг тайлагнах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн **салбарын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх**, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, хөрөнгө оруулалт, зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийг захиран зарцуулах, тайлагнах, зохицуулалтыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх, гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг хангах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, салбарын харьяа байгууллагуудад санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа төсвийн

¹² <https://www.devex.com/organizations/ministry-of-development-planning-bolivia-123144>

¹³ https://www.mofnp.gov.zm/?page_id=2981

¹⁴ <https://www.mofa.gov.mn/structure>

төвлөрүүлэн болон шууд захирагчид, төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, улсын төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Үндэсний аудитын газар, нутгийн захиргааны байгууллага, гааль, татвар, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын байгууллага байна.

3.б.Бусад төрийн захиргааны төв байгууллага/Олон улсад^{15/}

Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас бусад төрийн захиргааны төв байгууллага зардлын хуваарилалтын хувилбаруудыг тодорхойлох, нөөцийг үр дүнтэй, үр ашигтайгаар удирдах, зардлыг хэмнэх зэргээр зардлыг удирддаг болохыг тодорхойлсон байгаа нь зардлын шинжилгээг хамгийн бүтээлчээр хийх үндсэн үүрэг бүхий төрийн институт нь салбарын яам болох нь тодорхой байна. Манай улсад ч энэ хандлага нь нийцэж байна.

1.2.Төсвийн зарлагын шинжилгээний үндсэн онол, арга зүй

Зардлын шинжилгээг үр дүнтэй байдлын шинжилгээ, хуваарилалтын үр ашгийн шинжилгээ, техникийн үр ашгийн шинжилгээ, чиг үүргийн уялдаатай байдлын шинжилгээ гэсэн 4 төрөлд хувааж авч үздэг¹⁶. Дурдсан шинжилгээнүүдийг авч үзвэл дараах байдалтай байна.

1.2.1.Үр дүнтэй байдлын шинжилгээ

Үр дүнтэй байдлын шинжилгээний хүрээнд хөтөлбөр, төсөл, бодлогын ач холбогдлыг авч үзэж, дэвшүүлсэн зорилтууддаа хүрсэн эсэхийг шинжилдэг. Энэ төрлийн шинжилгээг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар тайлбарлав.

Хүснэгт 1: Үр дүнтэй байдлын шинжилгээ

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
1	Гүйцэтгэлийн мэдээлэлд хийгдэх шинжилгээ	Энэ төрлийн шинжилгээ нь төсөл, хөтөлбөр юунд хүрэхийг зорьсон, амжилтыг хэрхэн хэмжсэн, заасан зорилгод хүрсэн эсэх, Засгийн газраас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрөөс үр дүн нь хэр зэрэг хамааралтай эсэхийг тус тус шинжлэхэд төвлөрдөг.	Хөтөлбөр, төсөл, бодлогын бичиг баримтууд, тухайлбал төлөвлөгөө, тайлан, салбарын стратеги, үр дүнгийн тоон болон чанарын мэдээлэл, өрхийн болон бусад судалгаа, үнэлгээний тайлан.

¹⁵ <https://www.slideshare.net/OECD-GOV/finance-function-in-line-ministries-jn-blndal-oecd>
¹⁶ <https://documents1.worldbank.org/curated/en/940921532366222268/pdf/128662-RE-VISED-WP-P161180-PUBLIC-NSPENDINGREVIEWMANUALJun.pdf>

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
2	Үр нөлөөний үнэлгээ	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн өөрчлөлтийг тодорхойлох гүйцэтгэлийн үнэлгээний нэгэн төрөл. Энэ нь төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байхад гарах байсан үр дүн, бодитойгоор гарсан үр дүн хоёрыг харьцуулдаг. Үр нөлөөний үнэлгээ нь төсөл, хөтөлбөрийн үр нөлөөг тодорхойлж, тэдгээрийг цаашид үргэлжлүүлэх эсэх шийдвэр гаргах суурь болдог.	

Эх сурвалж: Spending review manual, the world bank

1.2.2.Хуваарилалтын үр ашгийн шинжилгээ

Хуваарилалтын үр ашиг гэдэг нь засгийн газрын хөтөлбөр, арга хэмжээнд нөөцийг хуваарилахдаа нийгмийн хүртэх цэвэр үр өгөөжийг хамгийн их болгоход чиглүүлэхийг хэлнэ. Практикт засгийн газрын тэргүүлэх чиглэлийн дагуу зардал хуваарилж, хуваарилалтын үр ашгийг хангахыг эрмэлздэг.

Хүснэгт 2: Хуваарилалтын үр ашгийн шинжилгээ

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
1.	Хураангуй шинжилгээ /Profile analysis/	Энэ нь тухайн үеийн зардлын нэрлэсэн хэмжээ болон зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг тоогоор эсвэл ДНБ-д эзлэх хувиар илэрхийлэн харуулдаг. Хураангуй шинжилгээ нь төсвийн зарцуулалттай холбоотой олон чухал асуултад хариулт өгдөг. Тухайлбал “Тухайн жилд төсвийн нийт зардал хэд байсан бэ? Ямар байгууллага, юунд, ямар үйл ажиллагаанд хамгийн их мөнгө зарцуулсан бэ? Урсгал зардал нь хөрөнгө оруулалтын зардлын харьцаа ямар байсан бэ? Тухайн салбарт ямар хэмжээний зардлыг хуваарилсан бэ? Тухайн улс энэ салбарт бүс нутгийн орнуудтай харьцуулахад хэдий хэмжээний мөнгө зарцуулсан бэ? Эрүүл мэнд зэрэг тэргүүлэх салбаруудад ямар хэмжээний төсөв зарцуулсан бэ?	Дүрслэлийн статистик; Хөтөлбөр, төсөл, бодлогын бичиг баримтууд, тухайлбал төлөвлөгөө, тайлан, секторын стратеги; орц /жишээ нь бодит нөөцийн өртөг, үр дүнг бий болгоход чиглэсэн хүний нөөцийн хүчин чармайлт/, гарц, үр нөлөөний талаарх тоон болон чанарын мэдээлэл, мөнгөн болон мөнгөн бус үр ашгийн тооцоолол; хувийн секторын мэдээлэл; өрхийн болон

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
		Тэргүүлэх салбарын хөтөлбөрийн зардлын ямар байсан бэ?" зэрэг асуултад хариулт авч болно. Хураангуй шинжилгээг техникийн үр ашиг, үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийх хэрэгсэл болгон ашиглах боломжтой. Хураангуй шинжилгээнд ашиглах хүснэгтүүд нь зардлыг захиргааны буюу байгууллагын, чиг үүргийн, эдийн засгийн ангиллаар эсвэл эдгээр ангиллын хослолоор, мөн зардлын төрлүүд, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллийг харуулдаг.	бусад судалгаа; үнэлгээний тайлан; ижил төстэй бөгөөд хөгжингүй орнуудтай харьцуулсан мэдээлэл.
2.	Чиг хандлагын шинжилгээ/Trend analysis/	Зардлын өөрчлөлт, түүний тогтмол болон хувьсах хэсэг, өсөлтийн хувь, ДНБ-д эзлэх хэмжээ зэргийг хугацааны шугамаар ялган харуулдаг. Сүүлийн таван жилийн төсвийн зардлын өсөлт, бууралт юунаас шалтгаалсан байна вэ? Хөрөнгө оруулалт, цалин хөлсний зардлаас уу?, аль эсвэл нийгмийн шинж чанартай зардлуудыг санхүүжүүлэх урсгал шилжүүлгээс үү? Цалингийн хувьд аль салбар хамгийн их өсөлттэй байна вэ? Бүсийн хэмжээнд салбарын зарлага өсөх аль эсвэл буурах хандлагатай байна уу? Тухайн салбарын урсгал зардал ямар хандлагатай байна вэ? Чиг хандлагыг тодорхойлох стандарт хүснэгтүүд нь зардлыг захиргааны, чиг үүргийн, эдийн засгийн ангиллаар аль эсвэл тэдгээрийн хослолоор харуулдаг.	
3.	Төсвийн жишиг болохуйц хуваарилалттай харьцуулсан шинжилгээ /Comparing/benchmarking budget allocation/prioritization/	Цалингийн болон цалингийн бус зардлын нийт зарлагад эзлэх хувийг тухайн улсын болон бүс нутгийн хэмжээнд (хэрэв бүс нутгийн талаарх мэдээлэл байгаа бол), аль эсвэл бусад орнуудтай харьцуулж, хуваарилалтын үр ашигтай бус байдлыг тодорхойлдог. Өөр нэг арга бол төсвөөс гадуур буюу хувийн секторын	

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
		санхүүжүүлж, нийлүүлж буй төрөл бүрийн үйлчилгээний (тухайлбал тээвэр, хэвлэл, усан хангамж гэх мэт.) нэгжийн өртгийг харьцуулах явдал юм.	
4.	Зарлагын бүтцийн шинжилгээ/Budget composition analysis/	Зарлагын үр дүнд үндэслэн засгийн газрын тэргүүлэх чиглэлийг тогтооно. Шинжилгээ нь нийт улс орны хэмжээнд эсвэл бүс, орон нутгийн түвшинд төсвийн зардлын төрөл бүрийн ангиллын бүтцийг тодорхойлдог. Шинжилгээнд (а) функциональ чиглэлийн аль эсвэл тэргүүлэх салбарын (жишээ нь, ерөнхий удирдлагын, нийгмийн болон орон нутгийн /хотын захиргааны/ чиг үүргийн); (b) эдийн засгийн (жишээ нь, урсгал ба хөрөнгийн зардал, цалингийн ба цалингийн бус зардал, төрийн болон хувийн секторын оролцооны), (с) төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон шилжүүлэг эсвэл татаасны зардлуудыг авч үздэг. Сүүлийн 5-10 жилийн хугацаанд зардлын бүтэц хэрхэн өөрчлөгдсөнд дүн шинжилгээ хийдэг. Бусад улс орнуудтай шинжилгээний үр дүнг харьцуулж болно.	
5.	Ахиу өгөөжийг тооцох шинжилгээ / Estimating marginal returns/	Нөөцийг бусад салбарт дахин хуваарилснаар салбарын зорилтуудыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой юу? Улсын төсвийн зардлын ахиу үр өгөөжийг ихэвчлэн функциональ буюу чиг үүргийн чиглэлээр тооцдог. Ахиу өгөөжийн шинжилгээнд тодорхой хугацааны цуваа бүхий дата, мэдээлэл хэрэглэгдэх бөгөөд ихэвчлэн бие даасан судалгаа хэлбэрээр хийгддэг. Ийм судалгаанууд ихэвчлэн Засгийн газрын зардлын үйлдвэрлэл, орлогын тэгш	

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
		бус байдал, ядууралд үзүүлэх нөлөөллийг төрөл бүрийн сувгаар тооцоолох тэгшитгэлийн загварт үндэслэн хийгддэг. Дифференциал тэгшитгэлээр дамжуулан Засгийн газрын зардлуудын ахиу үр нөлөөг тооцдог.	
6.	Зардал-үр өгөөжийн шинжилгээ / Cost-benefit analysis (CBA)/	СВА аргаар хөтөлбөр/төслийн нийт зардлыг мөнгөн нэгжээр илэрхийлсэн үр өгөөжтэй нь харьцуулдаг. Энэ нь хөтөлбөртэй холбоотой цэвэр ашгийг тооцоолох боломжийг олгодог. Энэхүү техник нь тухайн хөтөлбөрийн оролцогчид, тухайлбал хувь хүмүүс, байгууллагуудын биет болон биет бус өгөөжийг мөнгөн дүнгээр илэрхийлдэг. Зардал-үр ашгийн шинжилгээний гол давуу тал нь стратегийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлсийг системтэй бөгөөд тодорхой авч үздэг явдал юм.	
7.	Зардал-үр дүнтэй байдлын шинжилгээ / Cost-effectiveness analysis (CEA)/	Засгийн газрын хөтөлбөр, үйл ажиллагааны үр өгөөжийг мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй тохиолдолд CEA-г CBA-ийн өөр хувилбар болгон ашигладаг. Энэ нь ижил төрлийн гарцыг өөр аргуудаар бий болгоход шаардлагатай зардлыг харьцуулдаг. CEA нь зорилтын янз бүрийн түвшинд хүрэх зардлыг харьцуулахад ашиглагддаг. Жишээлбэл, хүн амын тодорхой бүлгийн бичиг үсгийн тайлагдалтын түвшнийг нэмэгдүүлэх хамгийн зардал багатай арга юу байж болохыг тогтоож болно.	
8.	Зардал-ханамжийн шинжилгээ/ Cost-utility analysis (CUA)/	CUA нь ижил зорилгод хүрэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийн мөнгөн хөрөнгөөр илэрхийлэгдээгүй үнэ цэнэ буюу ханамжийг үнэлэх, харьцуулахад ашиглагддаг. CUA нь хувь хүмүүсийн сонголтод тулгуурлан ханамж аль эсвэл үнэ цэний ерөнхий хэмжүүрийг	

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
		тодорхойлдог. Тухайлбал хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл явах хугацааг харгалзаж, дундаж наслалтыг уртасгахын зэрэгцээ амьдралын чанарыг сайжруулах бодлогын зорилтыг дэвшүүлсэн байж болно. Холбогдох шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа эрүүл мэндийн нөхцөл байдлаас хамаарсан сэтгэл ханамжуудыг авч үзэж, харьцуулалт хийх боломжтой.	

Эх сурвалж: Spending review manual, the world bank

1.2.3.Техникийн үр ашгийн шинжилгээ

Техникийн үр ашиг нь хамгийн бага зардлаар хамгийн их гарц, үр дүнд хүрэхтэй холбоотой ойлголт юм. Зарцуулалтын шинжилгээ нь төсвийн зардлын техникийн үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой. Жишээлбэл, ижил гарц, үр дүнд хүрэхтэй холбоотой онолын хувьд хамгийн бага зарцуулагдах боломжит норматив зардлыг тухайн зардлын гүйцэтгэлтэй харьцуулах байдлаар үр ашгийг хэмжих боломжтой.

Хүснэгт 3: Техникийн үр ашгийн шинжилгээ

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
1.	Бүтээмжийн шинжилгээ /Frontier analysis/	Үр ашгийг үнэлэх хамгийн түгээмэл аргуудын нэг бол Мэдээлэлд суурилсан үр ашгийн шинжилгээ (DEA-Data Envelopment Analysis) юм. DEA шинжилгээгээр үйлдвэрлэлийн гарцыг орцтой харьцуулах замаар нэгжийн бүтээмжийг тооцдог. Нэгжийн гүйцэтгэлийн бүтээмжийг тооцохдоо нийт боловсруулсан мэдээллээс хамгийн өндөр гүйцэтгэл бүхий үзүүлэлттэй харьцуулах замаар үр ашгийг тооцно. Энэ аргачлал нь үр ашгийг тодорхойлохдоо үр ашгийн хязгаар болон хамгийн өндөр гүйцэтгэл бүхий орц-гарцын хослол хоорондын зөрүүгээр авч үздэг. Өөрөөр хэлбэл, өгөгдсөн орцын түвшинд үйлдвэрлэж болох хамгийн их гарц, үр дүнгээр үр ашгийг тодорхойлдог.	Батлагдсан төсөв, төсвийн зарлагын гүйцэтгэл болон гарц, үр дүнгийн мэдээлэл, салбарын стратеги, тайлан, хөтөлбөрийн төсөв, хууль эрх зүйн болон зохицуулалтын баримт бичиг, зарим тохиолдолд хамтын гэрээ хэлэлцээр, үндэсний болон олон улсын статистик мэдээ, судалгаа

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
2.	Төсвийн хэлбэлзлийн шинжилгээ/Budget deviation analysis/	Энэ нь төсвийн захирагч (хэрэгжүүлэгч) нэгжийн техникийн үр ашгийг тодорхойлоход ашигладаг өөр нэг арга юм. Төсвийг хэтрүүлсэн эсвэл дутуу зарцуулсан эсэх, харьяа төсвийн захирагч нар төсвөө төлөвлөсний дагуу зарцуулсан эсэх, төсвийн зардлын гүйцэтгэлийг төлөвлөсөн төсөвтэй зардлыг харьцуулж үзэхэд ямар нэг асуудал тулгарсан эсэх, зөрүүг хэрхэн тайлбарлах эсэх зэрэг асуултуудад хариулт өгдөг.	
3.	Бизнесийн процессын шинжилгээ /Business processes reviews/	Үүнд сонгогдсон бизнесийн процессийг тусдаа ажил, үйл ажиллагаа эсвэл үе шатаар ангилах замаар тэдгээрийн өртөг, нөөцийн хэрэглээ болон процессийг хялбаршуулах боломжит хувилбарт дүн шинжилгээ хийх зэргийг хамруулж авч үздэг. Өртөг, зардлын тооцоог цагийн бүртгэл (хэрэв байгаа бол) эсвэл нөөц ашиглалтын тусгайлсан судалгаанд үндэслэн хийнэ.	
4.	Мэдээллийн технологийн системийн хийдлийн шинжилгээ/IT systems gap analysis/	Өнөөгийн мэдээллийн технологийн системийн ашиглалтын шинжилгээг тухайн салбарын сайн туршлагатай харьцуулж, хийдэл буюу цоорхойг олж тогтоох, бизнесийн үйл явцыг автоматжуулах эсвэл бие даасан системүүдийг нэгтгэх замаар олж болох үр ашгийг тооцоолох боломжтой. Мэдээллийн технологид түшиглэсэн энэхүү шинжилгээг бизнесийн процессын шинжилгээтэй хамт ашиглагддаг бөгөөд ингэснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардлыг бууруулах ач холбогдолтой. Үүний зэрэгцээ, бизнесийн процессыг дахин загварчлах нь мэдээллийн технологийн системийг шинэчлэх аль эсвэл солих замаар техникийн өндөр үр ашигт хүрэх урьдчилсан нөхцөл болдог.	

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
5.	Албан хэргийн шинжилгээ/Desk reviews/	Зардлыг хэмнэх, бууруулах өөр нэг хүчин зүйл бол тухайн үйл ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалтыг хялбарчлах явдал юм.	

Эх сурвалж: Spending review manual, the world bank

1.2.4.Функциональ уялдаа холбооны шинжилгээ

Төрийн байгууллагуудын давхардсан эсвэл үр ашиггүй чиг үүргийг тодорхойлох замаар хэмнэлт гаргаж болно.

Хүснэгт 4: Функциональ уялдаа холбооны шинжилгээ

№	Шинжилгээний төрөл	Тайлбар	Ашиглагдах мэдээлэл, өгөгдөл
1.	Чиг үүргийн уялдаа холбоо/Functional coherence/	Тухайн салбарт хамаарах бүх байгууллагуудын бүрэн эрх, зорилго, зорилтыг хянан үзэхийн хамт хэвтээ хяналт, чиг үүргийн зураглал хийх замаар Функциональ дүн шинжилгээг эхэлж болно. Дараагийн алхам нь зардлыг хэрэгжүүлэх үүрэгтэй гол байгууллагуудыг тусгайлан авч үзэж, дотоод бүтэц нь үр ашигтай, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхэд тохирсон эсэхийг үнэлэх явдал юм. Тухайн улс эсвэл бусад улс орны ижил төстэй байгууллагын бүтэцтэй харьцуулах нь ач холбогдолтой. Шийдвэрийн мод нь аль функцүүдийг цөөрүүлэх аль эсвэл хасах боломжтой эсэх, мөн зөвлөх үйлчилгээ хийлгэх, задлах, оновчтой болгох, арилгах боломжтой давхардсан функц байгаа эсэхийг шинжлэхэд тустай.	Шинжилгээнд хамрагдсан байгууллагуудын бүрэн эрх, зохион байгуулалтыг тодорхойлсон хууль тогтоомжийн баримт бичиг, байгууллагын дотоод журам, зохион байгуулалтын схем, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, ажлын байрны онцлог, менежерүүдтэй хийсэн дэлгэрэнгүй ярилцлага

Эх сурвалж: Spending review manual, the world bank

1.3.Төсвийн зарлагын үр дүнд нөлөөлөх институтийн дүн шинжилгээ

Төсвийн зарлагын үр дүнд нөлөөлөх институтийн дүн шинжилгээг хийх арга аргачлалыг боловсруулах хүрээнд Төрийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн институтээс /Chartered Institute of Public Finance and Accountancy/ хийсэн “Төрийн байгууллагын сайн засаглал-Олон улсад” нэртэй судалгааны ажлыг¹⁷ иш үндэслэл болгов. Төрийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн институт бол төрийн секторт ажилладаг, дэлхийн улс орнуудад тархан байршсан 14,000 гишүүнтэй, төрийн санхүүгийн салбарын мэргэжилтнүүдэд зориулж үйл ажиллагаа явуулдаг төрөлжсөн байгууллага юм.

Хүснэгт 5-д заасан асуултуудад хариулт авч, оноо өгөх замаар тухайн салбарын байгууллагын зарлагын шинжилгээнд нөлөөлөх институтийн чадавхыг үнэлэх боломжтой. Гарсан үнэлгээг төсвийн зарлагатай уялдуулж, хугацааны цувааны шинжилгээг хийж болно.

Хүснэгт 5: Сайн засаглалыг оношлох асуултууд

№	Үзүүлэлт	Асуултууд
1.	Ёс суртахууны үнэт зүйлийг тууштай мөрдөж, хууль дээдлэх ёсыг эрхэмлэн үнэнч шударга байх нь	• Ёс суртахууны стандарт муу байх эрсдэлийг үнэлсэн үү? • Удирдлагын багийн гишүүд болон бүх ажилтнууд дагаж мөрдөх ёстой зан үйлийн стандартыг тодорхойлсон ёс зүйн дүрмийг байгууллага баталсан уу? • Энэхүү дүрмийг ажилчдад өргөн хүрээнд, тогтмол хэлбэрээр хүргэж байна уу? • Бүх ажилтнууд ёс зүйн дүрмийг мэдэж байгаа, зөвшөөрч байгаа эсэхийг баталгаажуулдаг уу? • Шинэ ажилчдад байгууллагын ёс зүйн хэм хэмжээг тусгайд нь таниулдаг уу? • Удирдах албан хаагчид ёс зүйн дүрмийнхээ дагуу ажиллаж, байгууллагадаа зөв уур амьсгалыг бүрдүүлж байна уу? • Удирдлагын үүрэг гүйцэтгэж буй хүмүүсийн зан байдал нь байгууллагын зорилго, үнэт зүйлсийг гажуудуулж болзошгүй байдаг уу? Хэрэв тийм бол энэ асуудлыг хэрхэн шийдэж байна вэ? • Байгууллагад ёс зүйн дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг үнэлэх ямар механизм үйлчилдэг вэ? • Удирдлагын баг байгууллагын ёс зүйн үнэт зүйлсийн талаараа гуравдагч этгээдэд хамтран ажиллаж байхдаа тодорхой илэрхийлж, мэдэгдсэн үү? • Байгууллагын зүгээс удирдлагын багийн гишүүд болон ажилчдыг өрөөсгөл, нэг талыг баримтлах, ашиг сонирхлын зөрчлийн нөлөөнд автуулахгүй байх зохих механизмыг бий болгосон уу? • Удирдлагын баг, ажилтнуудын хурлаар ёс зүйн асуудлыг байнга хэлэлцдэг үү? • Гүйцэтгэх удирдлага (эсвэл түүнтэй адилтгах хүн) өөрийн байгууллагад ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар хувийн хариуцлага хүлээдэг үү? • Бүх ажилтнуудад хүлээн зөвшөөрөгдөх ба хүлээн зөвшөөрөгдөөгүй зан үйлийн жишээг хүргэх хэрэгтэй юу?

¹⁷ <https://www.ifac.org/knowledge-gateway/supporting-international-standards/publications/international-framework-good-governance-public-sector>

№	Үзүүлэлт	Асуултууд
		- Удирдах ажилтнууд бүх ажилчдад адил тэгш хандаж байгаа гэдгийг хэрхэн мэдэх вэ? - Байгууллага залилан, авлигын эсрэг бодлоготой юу? Энэ нь үр дүнтэй ажиллаж байна уу? Үүнд хэрхэн хяналт тавьж байгаа вэ? - Залилангийн эрсдэлүүдийг тооцож үзсэн үү? Тэднийг хэрхэн авч үздэг вэ? - Өмнө нь залилангийн гэмт хэрэг илэрсэн үү?, илэрсэн бол ямар нэгж, газарт? Эдгээр хэргүүдийг шийдвэрлэх, дахин гаргахгүйн тулд ямар ажил хийсэн бэ? - Бүх ажилчид зүй бус үйлдэл, залилан мэхлэлт, авлига авсан гэж сэжиглэж байгаа тохиолдолд юу хийхээ мэддэг үү?
2.	Нээлттэй байдал, оролцогч талуудын иж бүрэн оролцоог хангах нь	- Байгууллага бүх үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх амлалт авсан уу? Энэ нь ямар хэлбэртэй вэ? - Байгууллага нь оролцогч талуудаа хэн болохыг, тэдэнтэй хэрхэн харилцаж байгаагаа ойлгодог уу? - Байгууллага нь ямар байгууллагын оролцогч талуудтай сайн харилцаа тогтоох ёстой вэ? - Байгууллага нь хамгийн дээд түвшний институтийн гол оролцогч талуудтай үр дүнтэй харилцааг хөгжүүлэх чадвартай гэдгээ хэрхэн хангаж, баталгаажуулах вэ? - Байгууллага нь хамтран ажиллагч буюу оролцогч талуудтай ярилцлага хийдэг үү?, тэр дундаа хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажилладаг вэ? - Мэдээллийг нууцлах шийдвэр гаргахдаа ямар бодлого/шалгуурыг баримталдаг вэ? - Иргэд болон харилцагчдад хэрхэн зөвлөх нь зохистой талаар байгууллага ямар бодлого баримталдаг вэ? - Бодлого нь ямар төрлийн асуудлуудаар зөвлөгөө өгөх, хүлээн авсан мэдээллээ хэрхэн ашиглах талаар тодорхой тайлбарласан байдаг уу? - Байгууллага зохих зөвлөгөөг өгч чадсан гэдгээ хэрхэн мэддэг вэ? - Байгууллага өгсөн зөвлөгөө, зохион байгуулсан зөвлөлдөөний үр дүнгийн талаар оролцогчдод эргэж мэдэгддэг үү? - Байгууллага гаргасан шийдвэрийнхээ учир шалтгааныг түүнд өртөж болзошгүй талуудад хэр сайн тайлбарлаж өгдөг вэ? - Байгууллага одоогийн болон ирээдүйн хэрэглэгчдэдээ тэгш шударга хандаж байгаагаа хэрхэн нотлох вэ? - Байгууллага олон нийтийн ашиг сонирхол болон иргэдийн ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хэрхэн шинжилж дүгнэдэг вэ? - Хэрэглэгч болон харилцагч байгууллагууд тухайн байгууллагад ямар түвшинд итгэж байна вэ? Итгэлийг хэрхэн бэхжүүлэх вэ? - Байгууллагын хүрсэн үр дүнг оролцогч талуудын хүлээлттэй харьцуулж хэрхэн хэмждэг вэ?
3.	Эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр ашгийг харгалзан тогтвортой үр дүнг тодорхойлох нь	- Шийдвэр гаргах, төлөвлөхөд байгууллагын зорилго, алсын хараа нь хэр зэрэг чухал байр суурь эзэлдэг вэ? - Байгууллага юунд хүрэхийг хичээж байгаагаа тодорхой ойлгохын зэрэгцээ хэмжиж, үнэлж болохуйц үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон уу? - Байгууллагын юунд хүрэхээр төлөвлөж байгаа талаар

№	Үзүүлэлт	Асуултууд
		оролцогч талууд мэддэг үү? Байгууллага тэдний дэмжлэгт хэрхэн нааштай ханддаг вэ? Энэ нь гүйцэтгэлийг сайжруулах нөлөө үзүүлдэг үү? • Байгууллага капиталын хөрөнгө оруулалтыг урт хугацаагаар оновчтой төлөвлөсөн эсэх аль эсвэл хязгаарлагдмал нөөцийг (жишээ нь, газар, ус) нийгэм, эдийн засаг, байгаль орчны сайн сайхан байдлыг бий болгоход зарцуулсан эсэхийг хэрхэн нотлон баталгаажуулдаг вэ? • Байгууллагын хүргэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь эрхэм зорилгод тусгагдсан уу? Байгууллага гүйцэтгэлээ сайжруулахын тулд өмнөх туршлагаа ашиглаж, суралцах дадал хэвшил, соёлтой юу? • Байгууллага стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулахдаа тогтвортой байдлыг хангахад чиглэсэн олон нийтийн өргөн хүрээний зорилгыг хэр анхаарч үздэг вэ? Байгууллага ижил төстэй байгууллагуудын туршлагаас • суралцах, аль эсвэл илүү сайн туршлагыг бий болгохын тулд тэдэнтэй холбоо тогтоодог уу?
4.	Хүссэн үр дүнд хүрэхийн тулд бусдын оролцоог зохих түвшинд хангах нь	• Байгууллага стратеги төлөвлөлтийнхөө нэг хэсэг болгож, хөндлөнгийн оролцоог ямар түвшинд авч үздэг вэ? • Шийдвэр гаргагчдад өгсөн мэдээлэл нь мөнгөний үнэ цэнийг нэмэгдүүлэх шийдвэр гаргахад хэр тусалдаг вэ? • Шийдвэр гаргаж байгаа хүмүүс дэлгэрэнгүй мэдээллийг хэрэглэгчдээс тогтмол авдаг уу? • Шаардлагатай үед мэргэжлийн зөвлөгөө авдаг уу? • Байгууллага шийдвэр гаргахдаа "олуулаа бодох"-оос зайлсхийх арга техникийг ашигладаг уу? • Байгууллага шийдвэр гаргах үйл явцад уялдуулах хөшүүргийг ашигладаг уу? • Төлөвлөж шийдвэр гаргахдаа дээрх мэдээллүүдийг хэр үр дүнтэй ашигладаг вэ? • Бусад талуудын оролцоотойгоор тухайн асуудлыг шийдэх үед ирээдүйд тэдний оролцоо шаардлагагүй болдог уу? • Байгууллага "зөв" орцуудыг ашиглахаар төлөвлөсөнд гэдэгт хэр зэрэг анхаардаг вэ? • Байгууллага төсвөө олон нийтэд мэдээлж, бодлогын шийдвэр гаргах үндэслэлээ тайлбарладаг уу? • Байгууллага төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд хэр сайн ажилладаг вэ? • Энэ нь хэр үр дүнтэй болохыг байгууллага хэрхэн мэдэх вэ? • Байгууллага гүйцэтгэлийнхээ талаарх мэдээллийг оролцогч талуудаас эргэж авдаг уу?
5.	Байгууллагын, түүний дотор удирдлагын манлайлах чадвар, болон хувь хүмүүсийн чадавхыг хөгжүүлэх нь	• Байгууллага өөрийн төрөл бүрийн хөрөнгийн (санхүүгийн, үйлдвэрлэлийн, оюуны, хүний, нийгмийн болон харилцаа, байгалийн капитал гэх мэт) хүрэлцэхүйц байдлыг хэрхэн үнэлдэг вэ? • Байгууллагын үйл ажиллагаа, гарц, төлөвлөсөн үр дүнг хугацааны ямар давтамжтайгаар хянадаг вэ? • Удирдлагын багийн гишүүд үүргээ гүйцэтгэхэд ямар ур чадвар шаардагддаг вэ? • Удирдлагын багийн гишүүд ур чадвараа үр дүнтэй ашиглаж чадаж байна уу? • Тухайн байгууллагын удирдлагын багийн гишүүдийг бүрэн

№	Үзүүлэлт	Асуултууд
		ил тод байдлаар томилоход чиглэгдсэн ямар процессууд явагддаг вэ? • Тухайн байгууллага нэр дэвшүүлэх хороотой эсэх, байдаг бол энэ нь үр дүнтэй ажиллаж чадаж байна уу? • Удирдах байгууллагын нэг ч гишүүн өөрийн цалин хөлсийг тогтооход оролцохгүй байх журмыг баталж гаргасан уу? • Байгууллага шаардлагад нийцсэн ур чадвартай хүмүүсийг хэр сайн тодорхойлж чаддаг вэ? Ажилд авах хүчин чармайлт нь нийгмийн өргөн хүрээний хүмүүсийг хамруулж чадсан уу? • Тухайн байгууллага удирдлагын багийн гишүүд, ажилтнуудын ур чадвараа хөгжүүлж, зохих ёсоор мэдлэгээ сайжруулах боломжийг олгох чиглэлээр хэр үр дүнтэй ажилладаг вэ? • Удирдлагын багийн гишүүдийн бие даасан гүйцэтгэлийг хянах чиглэлээр байгууллага хэр үр дүнтэй ажилладаг вэ? • Байгууллага удирдлагын багийн үр нөлөөг үнэлдэг үү? • Удирдлагын баг үүргээ тогтмол үр дүнтэй гүйцэтгэж байгаа эсэхээ хянаж байдаг уу? • Удирдлагын багийн томилогдсон гишүүдийн бүрэн эрх хэрэгжих хугацаанд дээд хязгаар байдаг уу? • Удирдлагын багийн гишүүд гүйцэтгэх бус удирдлагыг томилох үүргийг хэний өмнө хүлээдэг вэ?, Томилгоо нь тогтсон хугацаатай байдаг уу?, Дахин томилох үйл явц нь албан ёсны томилгооны журмаар явагддаг уу? • Байгууллагад ажилтнуудын бие даасан гүйцэтгэлийг хянах зохицуулалт байгаа юу? Эдгээр зохицуулалт хэр үр дүнтэй вэ?
6.	Хүчирхэг дотоод хяналт, төрийн санхүүгийн удирдлагаар дамжуулан эрсдэл болон гүйцэтгэлийг удирдах нь	• Байгууллагын эрсдэлийн удирдлагыг бүх түвшинд зохих ёсоор нутагшуулсан эсэхийг хэрхэн баталгаажуулдаг вэ? • Удирдлагын багийн гишүүд болон бусад бүх газар нэгжүүдийн шийдвэр гаргагчид зорилт дэвшүүлэх болон байгууллагын зорилгод хүрэх ахиц дэвшил, гүйцэтгэлийг үнэлэхдээ эрсдэлийг зориуд авч үздэг үү? • Бүх шийдвэр гаргагчид өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн найдвартай, хүрэлцээтэй мэдээллийг цаг алдалгүй авдаг уу? • Байгууллага эрсдэлийн удирдлагын зохицуулалт үр дүнтэй байгаа эсэхийг хэрхэн үнэлдэг вэ? • Байгууллагын эрсдэлийн удирдлага хэр үр дүнтэй вэ? • Эрсдэлийн удирдлага, хяналтын хийдлийг засаж залруулах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг үү? • Байгууллагын төрийн санхүүгийн удирдлагын үйл ажиллагаа олон улсын стандартад суурилсан уу? • Санхүүгийн удирдлага нь үйлчилгээний чанарыг сайжруулах, өргөн цар хүрээтэй өөрчлөлтийг бий болгох, сайн удирдлагыг бэхжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлдэг үү? • Байгууллагын зорилгод хүрэхэд тулгарч болох гол эрсдэлүүдийг удирдах байгууллагад (мөн бусад дотоод болон гадаад оролцогч талуудад) иж бүрэн мэдээлдэг үү? Ядаж жилд нэг удаа энэ талаар мэдээлдэг үү?
7.		• Тухайн байгууллага хэнд, юуны төлөө хариуцлага хүлээхээ мэддэг үү?

№	Үзүүлэлт	Асуултууд
	Хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхийн тулд ил тод байдал, тайлагналт, аудитын сайн туршлагыг хэрэгжүүлэх нь	- Байгууллагын хариуцлага хүлээхтэй холбоотой харилцаа хэр сайн ажилладаг вэ? - Байгууллага нь оролцогч талуудтайгаа хэр үр дүнтэй харилцдаг вэ? - Оролцогч талууд болон бусад сонирхогч талууд байгууллагын жилийн тайлан болон бусад гүйцэтгэлийн мэдээлэлтэй танилцах, мөн эдгээр асуудалтай холбоотойгоор байгууллагатай харилцахад хэр хялбар байдаг вэ? - Байгууллага оролцогч талуудтай харилцахдаа боломжтой сувгуудыг хэр сайн ашигладаг вэ? - Иргэд, хэрэглэгчид, ажилтнууд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх ямар боломжууд байдаг вэ? Тэдгээр нь үр дүнтэй хэрэгждэг үү? - Оролцогч талууд тайлангийн мэдээллийг ойлгох боломжийг тухайн байгууллага ямар түвшинд олгодог вэ? - Байгууллагын удирдлагын багийн гишүүдийн жилийн тайланд цалин хөлсний талаарх мэдээлэл нь байдаг уу? - Сонирхсон хүмүүс холбогдох мэдээллийг хялбархан олж чадах уу? Жишээлбэл, тухайн байгууллагын вэбсайт дээрх тодорхой мэдээллийг нэг товшилтоор хандаж авах боломжтой юу? - Төсвийн байгууллагын хүрээнд хэн, юуг хариуцаж ажиллах нь оролцогч талуудад тодорхой болсон байдаг уу? - Аудитын хороо хэр үр дүнтэй ажиллаж байна вэ?, Түүний бүрэн эрх, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар хангалттай тайлагнадаг уу? - Байгууллагын дотоод аудитын хэлтэс нь аудитын хороо эсвэл түүнтэй адилтгах дээд түвшний хяналтын байгууллагад үйл ажиллагааныхаа талаар тайлагнадаг уу?

Эх сурвалж: International Framework: Good Governance in the Public Sector, CIPFA

1.4.Төсвийн зарлагын шинжилгээний олон улсын онцлох туршлагууд

Төсвийн зарлагын шинжилгээний олон улсын туршлагыг тодорхойлохдоо Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагуудаас гаргасан “Зарлагын шинжилгээний шилдэг туршлага” судалгааны ажлыг¹⁸ иш үндэслэл болгосон. Тус судалгаанд дараах 7 асуудлыг авч үзсэн байна.

1. Боломжит зорилтуудыг боловсруулж, шинжилгээний хамрах хүрээг тодорхойлох

- Зарлагын шинжилгээний зорилтууд нь тодорхой байх бөгөөд албан ёсны ажлын даалгаварт тусгана. Зорилтууд нь оролцогч талуудын хамрах хүрээ, чиг үүрэгт нөлөөлдөг.
- Шинжилгээний хамрах хүрээг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Бүх хөтөлбөрүүд тодорхой чиглэлээр хэрэгжиж, өөрчлөгдөж болох тул хөтөлбөртэй холбоотой

¹⁸ <https://www.oecd.org/gov/budgeting/spending-reviews-towards-best-practices.pdf>

бүхий л зардлыг шинжлэх нь тохиромжтой. Зарцуулалтын шинжилгээг тодорхой давтамжтай хийх нь Засгийн газарт хөтөлбөрүүдээ дахин төлөвлөх боломжийг олгодог.

Гана Улсын жишээнээс үзэхэд хөдөө аж ахуйн төсвийн зарлага, институтийн шинжилгээ нь хөдөө аж ахуйн салбар дахь яам, газар, агентлагууд хэрхэн зохион байгуулагдаж байгаагаар харуулсан байдаг. Гана Улсын хувьд Хөдөө аж ахуйн яам нь хөдөө аж ахуйн салбарын тэргүүлэгч агентлаг ба Гана Улсын усалгааны хөгжлийн газар, Үр тариа буурцагт ургамлын хөгжил, Мал эмнэлгийн зөвлөл гэх зэрэг долоон газар, 3 дэд агентлагтай. Усалгааны хөгжлийн газар нь усны нөөцийн хөгжлийн салбар хоорондыг зохицуулдаг бөгөөд Гана Улсын усны нөөцийн комиссыг төлөөлөн ажилладаг. Хөдөө аж ахуйн салбарыг бүс нутгийн хэмжээнд Бүс хариуцсан газар, тариалангийн хөгжлийн хэлтэс, дүүргийн хэмжээнд тухайн дүүргийг хариуцсан хөдөө аж ахуйн хөгжлийн хэлтэс төлөөлдөг. Хөдөө аж ахуйн яам нь цогц төвлөрсөн бус системийг бий болгон ажиллах хэрэгтэй. Тиймээс төвлөрлийг сааруулах ерөнхий үйл явц нь төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах явдал юм. Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах үйл явц нь орон нутгийн төсөв, санхүүгийн бие даасан байдал, тэнд төсвийг захиран зарцуулах эрх мэдлийг олгосон байдлаар хэмжигддэг. Гана Улсын хувьд Хөдөө аж ахуйн яам нь салбарыг удирдах ерөнхий чиг үүрэгтэй байдаг тул институтийн зохицуулалт хийхэд ихээхэн хүндрэл учирдаг байна.

2. Шинжилгээний явцад улс төрийн болон төрийн албаны үүргийн ялгаатай байдлыг тодорхойлох

- Улс төрийн манлайлал: Улс төрийн манлайлал нь шинжилгээний зорилго, хамрах хүрээг тодорхойлох үед буюу шинжилгээний эхэнд болон зөвлөмж батлахтай холбоотой эцсийн шийдвэр гаргах үеүдэд онцгой чухал байдаг. Улс төрийн манлайлал нь зарцуулалтын шинжилгээний үр дүнд улс төрийн талаас идэвхжүүлэн нөлөөлөх хүчин зүйл болдог.
- Олон улсын туршлагаас үзэхэд ихэнх тохиолдолд төрийн албан хаагчид төсвийн зарлагын шинжилгээг хийж байна. Шинжилгээний хийсний үр дүнд боломжит бодлогын хувилбарыг боловсруулах болон шинжилгээнээс гарсан зөвлөмжийг холбогдох бодлогыг хэрэгжүүлэгч төрийн байгууллага, албан хаагчид хэрэгжүүлнэ. Иймд СЯ болон салбарын яамдын аль аль нь төсвийн зарлагын шинжилгээ хийх туршлагатай байх шаардлагатай.

3. Шинжилгээ хийх үйл явцад засаглалын зохион байгуулалт, удирдлагын чиг үүргийн зохицуулалтыг тодорхойлох

- Чиг үүрэг болон хариуцлагыг тодорхойлох Төсвийн зарцуулалтын шинжилгээг хийх бүх үе шатанд засаглалын бүтэц зохион байгуулалт болон чиг үүрэг тодорхой байх нь шинжилгээг амжилттай хийхэд чухал ач холбогдолтой (СЯ, салбар яамд, ЗГХЭГ г.м).

- **Удирдлагын нэгж:** Удирдлагын нэгжээс төсвийн зарцуулалтыг шинжлэх, хянан шалгах явцад хяналт тавих бөгөөд холбогдох сайд нарт дүгнэлт, зөвлөмж хүргүүлдэг. Зарцуулалтын хяналт, шинжилгээ хийх үйл явцад ажлын хэсэг байгуулан оролцуулж болно. Ажлын хэсэг нь зарцуулалтын хяналт, шинжилгээний сэдвүүдэд дүн шинжилгээ хийнэ. Ажлын хэсгүүд нь Сангийн яам болон холбогдох салбарын яамдын ажилтнуудаас бүрдэх бөгөөд мөн хөндлөнгийн зөвлөхүүд ч оролцож болно.

4. Төсвийн үйл явцтай уялдаа холбоотой байх

- Төсвийн үйл явцтай уялдуулах: Засгийн газрын төсвийг боловсруулах үйл явцтай төсвийн зарцуулалтын хяналт, шинжилгээг системтэйгээр нэгтгэх нь зүйтэй. Төсөв боловсруулах үйл явцад цаг тухайд нь үр нөлөөгөө үзүүлэхүйц түвшинд зарцуулалтын шинжилгээний хуваарийг хэрэгжүүлнэ.
- Дунд хугацааны төсвийн хүрээтэй уялдуулах: Зарцуулалтын шинжилгээний үр нөлөөг дунд хугацаанд сайжруулах боломжтой. Ихэнх тохиолдолд зарцуулалтын хяналт, шинжилгээнээс гарсан үр дүн, санал зөвлөмжийг дунд хугацаанд хэрэгжүүлэх боломжтой байдаг.
- Үнэлгээ болон гүйцэтгэлд суурилсан төсөвтэй уялдуулах: Төсөвт хийсэн үнэлгээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл нь үнэ цэнтэй орц байх бөгөөд төсвийн зарцуулалтын шинжилгээ хийхэд ашиглагдах ёстой.

5. Зөвлөмжийг хариуцлагатай, ил тод байдлаар хэрэгжүүлнэ.

- Зарцуулалтын шинжилгээний үр дүнд тодорхой зөвлөмжүүд гардаг. Зөвлөмжүүд нь төсвийн зарцуулалтыг шинжлэн хянах чухал элемент бөгөөд шинжилгээг дүгнэлттэй холбож өгдөг. Ажлын хэсгийн хүрээнд хийгдэж байгаа дүн шинжилгээ нь цаашид хэрэгжүүлбэл зохих боломжит бодлогын хувилбаруудыг багтаасан байдаг.
- Төсвийн зарцуулалтыг шинжлэн шалгах шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих нь нэн чухал. Төсвийн зарцуулалтын талаар гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох яамд Сангийн яамтай хамтран хэрэгжүүлэх үүрэгтэй. Төсвийн зарцуулалтын хяналт, шинжилгээнээс гарсан шийдвэрийн хэрэгжилтэд Сангийн яам хяналт тавьж, нэгтгэж гаргасан дүгнэлтийг хэрэгжүүлэх үүргийг салбарын яамдад хүлээлгэх нь зүйтэй.

6. Зардлын шинжилгээний тайлан болон хяналтын тогтолцооны ил тод байдлыг бүрэн хангах

- Зардлын шинжилгээний дүгнэлтийг олон нийтэд нээлттэй байлгах ёстой. Энэ нь зардлын шинжилгээний нэгдмэл байдал, хариуцлага, хяналт, төсвийн үр дүнтэй зарцуулалтад дэмжлэг үзүүлж, төсвийн шийдвэрийн ил тод байдлыг нэмэгдүүлдэг.
- Засаглалын зохицуулалт, удирдамжийн материалыг олон нийтэд нээлттэй байлгах ёстой. Зардлын шинжилгээ нь ач холбогдол бүхий зорилтууд болон шалгах зардлын чиглэлийг багтаасан байна. Энэ нь хяналт, шинжилгээний

ажлын даалгавар болон бусад холбогдох материалд мөн адил хамаарна.

7. Зардлын шинжилгээнд хамруулах агуулгын хүрээг давтамжтайгаар шинэчлэх

- Байнга өөрчлөгдөж байгаа орчны онцлогийг харгалзаж Зардлын шинжилгээнд хамруулах агуулгын хүрээг шинэчилж байх ёстой. Зардлын шинжилгээний хэрэглээ нэмэгдэж байгаа нь тухайн улсын нөхцөл байдалтай уялдаж зарцуулалтын шинжилгээ хувьсан өөрчлөгдөж байгааг харуулж байна.
- Агуулгын хамрах хүрээ нь орчны өөрчлөлтийг авч үзэхээс гадна одоогийн зарцуулалтын шинжилгээний хүрээнд ажиглагдсан давуу болон сул талуудыг тусгах ёстой. Үүний нэгэн адил зардлын шинжилгээ бүр ирээдүйд хийгдэх зарцуулалтын шинжилгээнд хэрэглэгдэхүйц туршлага, сургамжийг өгөх учиртай.

1.5.Төсвийн зарлагын шинжилгээ хийх үе шатууд /ХАА-н салбарын хувьд/

Төсвийн зарлагын шинжилгээ хийх олон улсын туршлагыг Хөдөө аж ахуйн салбарын хувьд авч үзье. Төсвийн зарлагын шинжилгээ нь бэлтгэх, дүн шинжилгээ хийх, түгээх гэсэн дараах 3 үе шатаас бүрдэнэ. Үүнд:

1.5.1.Бэлтгэх үе шат

- Засгийн газар болон холбогдох яамдтай харилцаа тогтоож, төсвийн зарлагын шинжилгээний зорилгыг тусгаж, холбогдох оролцогч талууд, Засгийн газрын түнш байгууллагуудыг тодорхой болгоно. ХАА салбарын хувьд Харилцагч байгууллагын хэрэгцээ шаардлага зорилго, мэдээллийн шаардлага зэргээс шалтгаалан санхүү, төлөвлөлт, хөдөө аж ахуй, орон нутгийн засаг захиргаа зэрэг байгууллагууд оролцоно. Шийдвэрлэх асуудлын хүрээнд төрийн захиргааны төв байгууллагаас тодорхой арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд төсвийн зарлагын шинжилгээнд зохих байдлаар оролцох нь зүйтэй. Жишээлбэл: Төсвийн хөрөнгийн зарцуулалт, төсвийн мөчлөг, төсөв хуваарилах, төсвийн сахилга бат, төсвийн ил тод, хариуцлагатай байдалтай холбоотой асуудлуудыг Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцдаг.
- Төсвийн төвлөрлийг сааруулах, төсвийн шилжүүлэгтэй холбоотой асуудлуудыг орон нутгийн засаг захиргаа, холбогдох яамд хариуцдаг.
- Төсвийн зарлагын хуваарилалттай холбоотой асуудлыг тухайн салбарын яам хариуцах бөгөөд Засгийн газрын холбогдох байгууллагуудын оролцоог хангах нь төсвийн зарлагын мэдээлэлд хандах, зөвлөмж гаргах, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Төсвийн зарлагын шинжилгээнд Засгийн газар болон оролцогч бусад төрийн байгууллагуудын хүлээх үүргийг тодорхой тусгах хэрэгтэй.
- Засгийн газар болон оролцогч байгууллагууд бэлтгэх үе шат буюу зарлагын эхэн болон төгсгөл үед харилцан адилгүй үүрэг гүйцэтгэдэг.Тухайлбал: Бэлтгэх үе шатанд Засгийн газар, холбогдох төрийн байгууллагыг оролцуулах нь төсвийн зарлагын мэдээллээр хангах суурийг тавьж өгнө. Бэлтгэл ажлын үед төрийн

байгууллагын удирдлагын түвшний албан тушаалтнуудыг оролцуулснаар зөвлөмжийн хэрэгжилтийн үйл явцыг хурдасгах боломжтой. Оролцогч талуудтай хамтран ажиллах нь шинжилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх хэдий ч тухайн төсвийн зарлагын шинжилгээг гүйцэтгэхтэй холбоотой зардал, цаг хугацааг мөн нэмэгдүүлэх талтай. Шинжилгээний баг эдгээрийг тухай бүр тооцоолон ажлаа төлөвлөх нь тохиромжтой.

А.ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Зорилт

Төсвийн зарлагын шинжилгээний зорилтууд нь Сангийн яам, салбарын яам зэрэг оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан шинжилгээний зориулалтыг тусгасан байна. Үүнд:

- Төсвийн зарлагын үр ашиг, тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулахад чиглэсэн нотолгоонд суурилсан зөвлөмжийг тодорхойлох, өнгөрсөн хугацааны төсвийн зарлагын нөлөөлөл, салбарын зорилттой уялдуулан хамгийн их нөлөө үзүүлж буй төсвийн зарлагын хуваарилалт, зарцуулалт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх;
- Мэдээллийн сан байгуулах, цаашид төсвийн зарлагын шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх зорилгоор оролцогч байгууллагуудтай хамтран ажиллах.

Хамрах хүрээ

Шинжилгээний цар хүрээ (сэдэвчилсэн болон байгууллагын хамрах хүрээ) болон судалгааны гүнзгийрлийн түвшин (төсвийн хөрөнгийн урсгал, түүний нөлөөллийг илүү нарийвчилсан байдлаар авч үзэх) зэргийг харгалзан, тогтооно.

1. Сэдэвчилсэн хамрах хүрээ: Ямар дэд салбаруудыг хамруулахыг шийдвэрлэнэ. Тухайлбал, хөдөө аж ахуйн салбарын зарлагын тойм шинжилгээг хийхдээ салбарын үзүүлэлтүүдийг эхлээд тодорхойлно. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Засгийн газрын чигүүргийн ангиллын хувьд Хөдөө аж ахуйн салбарыг газар тариалан, мал аж ахуй, загас ан агнуур, ойн аж ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах ус, газар гэх зэргээр ангилдаг. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтыг хэрэглэх нь олон улсын төсвийн зарцуулалтыг илүү нарийвчлалтайгаар харьцуулах боломжийг бүрдүүлнэ. Практик нөхцөл байдалд улс орнуудын яамнууд салбарын цар хүрээг тэрхүү салбарт үйлдвэрлэгдсэн нийт бүтээгдэхүүнийг ДНБ-тэй уялдуулан тодорхойлох нь элбэг.

2. Байгууллагын хамрах хүрээ: Шинжилгээнд ямар байгууллагуудыг хамруулахыг шийдвэрлэнэ. Түүнчлэн хандивлагч байгууллагаас санхүүжүүлсэн үйл ажиллагаа, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, тухайн салбарт үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд үзүүлсэн татварын хөнгөлөлт зэрэгт төсвөөс гадуурх зардлыг шинжилгээгээр ямар түвшинд авч үзэхийг тогтооно.

3. Гүнзгий судлагдах байдал: Төсвийн гүйцэтгэлд хэр зэрэг гүнзгий дүн шинжилгээ хийхийг тогтооно. Энэ нь төсөвт тусгасан, хуваарилсан болон бодит зарлагын зөрүү зэрэг гүйцэтгэлийн үнэлгээнээс эхлээд орон нутгийн засаг захиргаа бүрд төсвийн

хуваарилалтын түвшин, цаг хугацааны хувьд илүү цогц үнэлгээ хийх, эцсийн хэрэглэгчдэд хүрэх төсвийн хөрөнгийн урсгалыг хянах хүртэл үйл ажиллагааг хамааруулж болно.

4. Нөлөөллийн үнэлгээ: Нөлөөллийн үнэлгээний цар хүрээг тодорхойлох. Энэ нь суурь өгөгдлөөр тодорхойлогдох бөгөөд салбар бүрийн дэд хөтөлбөрүүдийн (жишээлбэл, хөдөө аж ахуйн салбарт авч үзвэл судалгаа, усалгаа, бордоо гэх зэрэг) нөлөөллийн шинжилгээг авч үздэг.

Сэдэв сонголтын хувьд

Тодорхой сэдвүүдийг оруулах эсвэл хасах нь 1) тухайн салбарын бодлогын тэргүүлэх чиглэл, 2) үйл ажиллагааны тодорхой шаардлага, 3) ажлыг гүйцэтгэх ажлын багт хуваарилагдсан төсөв, 4) цаг хугацаа, 5) мэдээллийн хүртээмжтэй байдал, дүн шинжилгээ, судалгаа зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Б.ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ДАТА, ӨГӨГДЛИЙГ СОНГОХ НЬ

Төсвийн зарлагын шинжилгээний хамрах хүрээнд авч үзсэн дэд салбаруудын тоо, тухайн чиг хандлагыг тодорхойлоход шаардагдах дата өгөгдөл, мэдээллийн боломжит байдал нь шинжилгээний үр дүнд нөлөөлдөг. Чанарын шаардлага хангасан дата өгөгдөл нь үнэн зөв, цаг тухайд нь шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой бөгөөд төсвийн зарлагын шинжилгээний чанарт хамгийн их нөлөө үзүүлж буй өгөгдлийн эх сурвалж, тогтвортой байдлыг тухайн цаг хугацааны хувьд тооцож үзэх хэрэгтэй. Дэлхийн банкнаас боловсруулсан Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлагын тайлан нь Төрийн санхүүгийн удирдлагын системд үнэлгээ өгсөн байдаг.

Төсвийн зарлагын шинжилгээнд төрөл бүрийн дата өгөгдөл, мэдээллийг ашигладаг. Санхүүгийн өгөгдөл, мэдээлэл нь Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн салбарын яамны төсвийн холбогдох газар, хэлтсээс гардаг. Хэрэв төсвийн зарлагын шинжилгээний хамрах хүрээ өргөн, бие даасан байгууллагуудыг ихээр хамруулсан бол тухайн байгууллагуудаас санхүүжилт, зарлагын мэдээллийг авах шаардлагатай болно. Төсвийн зарлагын шинжилгээнд дараах 6 төрлийн өгөгдлийг ашиглана (Зураг 3).

Зураг 3: Төсвийн зарлагын шинжилгээнд хэрэглэгдэх дата, өгөгдөл, мэдээлэл



Эх сурвалж. Дэлхийн банк

Төсвийн зарлагын шинжилгээний цар хүрээ, чанар, мэдээллийн хүртээмж, эх сурвалжийг (гарц, үр дүн, үр нөлөө) тодорхой болгож, тухайн шинжилгээний зорилго, цар хүрээг тодорхойлохын тулд зарим өгөгдлийг нягталж үзэх шаардлагатай.

Тухайлбал:

- Шинжилгээний ажлын төсөв, цаг хугацааг тооцоолох;
- Ажлын цар хүрээг хэмжсэнээр шаардагдах төсвийн бодит тооцоог гаргах;
- Мэдээлэл, өгөгдлийн хүртээмжтэй байдал, зардал багатай арга барилаар чанарын стандартыг хангах;
- Нийт зардлын 15-20 орчим хувь нь түгээх үе шаттай холбоотой. Хөдөө аж ахуйн салбарын зарлагын шинжилгээний зорилго нь төсвийн зарлагын төвлөрсөн байдал, чанар, цар хүрээг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх тул зарлагын шинжилгээний тайланг түгээх болон холбогдох арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, тухайлбал, сургалт семинар зохион байгуулах зэргээр зөвлөмжийн хэрэгжилтийг дэмжин ажиллах;
- Төсвийн зарлагын дүн шинжилгээ хийхэд шаардагдах хугацааг бодитойгоор тооцоолох; /Төсвийн зарлагын шинжилгээний тоймыг дуусгахад зарцуулж буй хугацаа нь шинжилгээний ажлын цар хүрээнээс хамаарна./
- Төсвийн зарлагын шинжилгээний үр дүнг төсвийн мөчлөгтэй уялдуулах. /Энэ нь Засгийн газар жилийн төлөвлөлт, төсөвлөлт, төсвийн мөчлөгийн явц дахь шийдвэрүүдэд зөвлөмжийг шууд тусгах боломжийг бүрдүүлнэ./

1.5.2 Дүн шинжилгээ хийх үе шат

Төсвийн зарлагын шинжилгээний зөвлөмжүүд нь төсвийн зарлагын бүрдэл, цар хүрээ, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн тул дүн шинжилгээ хийх хүрээ нь төсвийн зарлагын өнөөгийн байдлыг сайжруулах төсвийн мөчлөг юм. Төсвийн мөчлөгийн тогтолцоог ашиглах нь төсвийн үйл явцыг бэхжүүлэх, улмаар төсвийн зарцуулалтыг сайжруулахад чиглэсэн тодорхой зөвлөмжийг өгөхөд тусалдаг. Төсвийн ерөнхий мөчлөг нь 1)Салбарын зорилт, стратеги боловсруулах, 2)Төсвийн хуваарилалт, 3) Төсвийн гүйцэтгэл, 4)Хяналт, шинжилгээ үнэлгээ гэсэн дөрвөн үе шаттай.

1. **Салбарын зорилго, стратеги:** Салбарын стратеги нь үндэсний хөгжлийн илүү өргөн стратегитай холбоотой.
2. **Төсвийн хуваарилалт:** төсвийн нийт зардлын дээд хязгаарт нийцүүлэн салбарын зорилт, стратеги, Дундхугацааны зардлын төсөөллийг боловсруулна.
3. **Төсвийн гүйцэтгэл:** УИХ-аар батлуулж, төрийн байгууллагуудад хөрөнгө хуваарилж, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.
4. **Хяналт шинжилгээ, үнэлгээ:** Санхүүгийн тайланг санхүүжилт хүлээн авч байгаа төрийн байгууллагууд гаргаж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Салбарын зорилтуудын харилцан хамаарал, зураг төсөл, хэрэгжилтийн үр ашиг, нөөц ашиглалтын үр ашиг, тогтвортой байдлыг үнэлэх ба үүний үр дүнд ирээдүйн төсвийн төлөвлөлт тодорхой болно.

А.САЛБАРЫН ЗОРИЛТ, СТРАТЕГИ

Хөдөө аж ахуйн салбарын Төсвийн зарлагын шинжилгээ нь (i) одоо баримталж буй салбарын стратеги (өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуйн салбарын стратеги, орон нутгийн хөгжлийн стратеги, усны нөөцийн стратеги, загас агнуурын стратеги, ойн стратеги гэх мэт дэд салбар болон үндэсний хэмжээн дэх стратегиудаас бүрдэнэ.) болон (ii) хөдөө аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалтаас өгөөж хүртэхэд бодлогын орчин хэр таатай байгааг тодорхойлоход чиглэнэ. Түүнээс гадна дараах үнэлгээг хийнэ. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарын улс орны зорилтыг тодорхой тусгасан эсэхийг тодорхойлох;

Үүнд ихэвчлэн тодорхой салбарын өсөлтийн хувь, хүнсний аюулгүй байдлын зорилтууд, ажлын байр бий болгох эсвэл ядуурлыг бууруулахад оруулах хувь зэрэг орно. Эдгээр зорилтууд нь үндэсний болон салбарын стратегид тусгагдсан эсэхийг тогтооно.

- Салбарын зорилтод хүрэхийн тулд үндэсний болон салбарын стратеги хэр зэрэг нийцэж байгааг үнэлэх;
- Хөдөө аж ахуйн салбарын зорилтын хувьд ямар стратегиуд байгаа, тэдгээрийг төсвийн зарлагын төлөвлөгөөнд оруулах боломжтой эсэхийг тодорхойлно. Засгийн газар зорилгодоо хүрэхийн тулд ямар стратеги баримталж байгааг тодорхой болгох; Стратегийн хүрээнд Засгийн газрын тухайн салбарт гүйцэтгэх үүргийг тодорхойлж, төрийн оролцоог хангаж өгөх;

- Нийгмийн баялгийн тэгш хуваарилалтыг баталгаажуулж, ихэвчлэн ядууст чиглэсэн хөгжлийг бий болгохын тулд тэгш байдлыг сайжруулах;

Идэвхтэй зах зээл нь үйлдвэрлэлийг дэмжих хэдий ч тэгш хуваарилалтыг байнга хангаж чаддаггүй. Энэ нь орлогыг дахин хуваарилах олон хөтөлбөрийн үндэслэл болж өгдөг.

- Салбарын стратегийн цар хүрээ, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалттай холбоотой зохицуулалтыг тодорхойлох;

Үүнд хөдөө аж ахуйн яамнаас бусад бүрэлдэхүүн хэсгүүд (жишээлбэл, орон нутгийн зам, санхүү, боловсрол гэх зэрэг) багтсан эсэх, хэрэгжүүлэхэд төрийн ямар байгууллага оролцож байгааг тодорхой болгох;

- Сүүлийн жилүүдэд салбарын стратегийн хэрэгжилтийн баримтжуулсан гүйцэтгэлийг хянана. Хэрэгжилтэд ахиц гарсан эсэхийг үнэлнэ.
- Бодлогын орчин нь салбарын хөрөнгө оруулалтын өгөөж авчрахад хэр таатай байгааг үнэлдэг.

Б.ХУВААРИЛАЛТЫН ҮР АШГИЙН ТООЦООЛОЛ

Төсвийн зарлагын шинжилгээний гол бүрэлдэхүүн хэсэг нь төсвийн хуваарилалт ба гүйцэтгэл юм. Хуваарилалтын дүн шинжилгээ нь тухайн салбарын төсвийн зарлагын үр ашгийг сайжруулахад чиглэдэг. Хөдөө аж ахуйн зарлагын тойм (сэдэвчилсэн хамрах хүрээ) илүү өргөн хүрээтэй байх тусам түүний хуваарилалтын үр ашгийн дүн шинжилгээний цар хүрээ өргөн байна.

Төсвийн зарлагын санхүүжилтийн эх үүсвэр - Санхүүгийн эх үүсвэр орлого бүрдүүлэгч механизм, арга хэлбэр, үйл явцын талаар сайн ойлголтой байх нь хөдөө аж ахуйн төсвийн зарлагын дүн шинжилгээний нэгэн чухал хэсэг билээ. Дараах хяналтын хуудас болон холбогдох асуултууд нь төсвийн зарлагыг хэрхэн санхүүжүүлдэг, татварын бодлого, боломжит хувилбаруудын талаар ойлголтой болоход дөхөм болно.

- **Хөдөө аж ахуйн зарлагын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох.** Жишээлбэл, Санхүүжилтийн эх үүсвэр өнгөрсөн жилүүдэд хэрхэн өөрчлөгдсөн бэ? төвлөрсөн бус үйлчилгээг санхүүжүүлэхийн тулд Засгийн газар шаардлагатай нөөцийг бий болгох (ихэвчлэн хуульд заасан байдаг) хэр цар хүрээтэй вэ?
- **Үйлчилгээний хураамж хэр хэмжээгээр ашиглаж байгааг тодорхойлох.** Ургамлын эрүүл ахуйн баталгаажуулалт, хөдөө аж ахуйн судалгаа зэрэг үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, ой мод, ус, загасны аж ахуй зэрэг байгалийн нөөцийг ашиглах боломж бий юу? Эмзэг бүлгийнхэн үйлчилгээ авахад эдгээр төлбөр хэт өндөр байна уу? Аль салбарын төрийн байгууллагууд орлого бүрдүүлж байна вэ? Эдгээр орлогын хэр хэмжээ, чиг хандлага, харьцангуй ач холбогдол нь юу вэ? Эдгээр орлогыг тайлагнах, ашиглах, шилжүүлэх талаар Сангийн яам ямар дүрэм журмыг баримталдаг вэ? Дүрмийг

дагаж мөрддөг үү? Орлого бүрдүүлэх дүрэм журмыг төрийн сан болон тухайн салбарт үр ашигтайгаар сайжруулах ямар хувилбарууд байна вэ?

Салбарын зардлын түвшин, бүтэц, санхүүжилтийг тодорхойлсны дараа мэргэжилтнүүд хөдөө аж ахуйн салбарын санхүүжилтийн үр ашиг, өсөлтөд үнэлгээ хийж, нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар нарийвчлан судлах шаардлагатай. Хуваарилалтын үр ашгийн шинжилгээ нь төрийн санхүүжилт зөв зүйлд хуваарилагдан зарцуулагдаж байгаа эсэхийг үнэлнэ. Үүнд дараах төрлийн шинжилгээг ашиглаж болно: Хүчин зүйлсийн хамаарлын шинжилгээ, энгийн индуктив шинжилгээ, урсгал ба хөрөнгийн зардлын шинжилгээ, цалин ба цалингийн бус зардлын шинжилгээ, энгийн нийцлийн дүн шинжилгээ.

1. Хүчин зүйлсийн хамаарлын шинжилгээ

Статистикийн шинжилгээний гол бүрэлдэхүүн хэсэг нь хамаарлын судалгаа байдаг. Статистикийн хамаарлаар нэг шинж тэмдгийн өөрчлөлттэй уялдан нөгөө шинж тэмдгийн тархалтын тухай авч үздэг. Тухайлбал нэг шинж тэмдгийн өөрчлөгдөх тохиолдол нөгөө шинж тэмдэг дунджаар яаж өөрчлөгдөхийг илэрхийлэхэд чиглэгддэг. Ийм хэлбэрийн статистикийн хамаарлыг корреляцийн хамаарал гэж нэрлэдэг.¹⁹

2. Энгийн индуктив шинжилгээ

Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дата өгөгдлийг харьцуулсны үндсэн дээр нөөцийн хуваарилалтын үр ашигтай байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох. Тухайлбал, цалингийн бус шинж чанартай урсгал зардлын бүрэлдэхүүн хэсэгт ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг тусгаагүй бол дэд бүтцийг (усжилт г.м) сэргээн засварлах боломжгүй болно. Мөн хандивлагч байгууллагын санхүүжилтийн нэгдсэн зохицуулалт байхгүй бол нэгдсэн төлөвлөлт, зохицуулалт хийхэд хүндрэл учирч болзошгүй.²⁰

3. Урсгал ба хөрөнгийн зардал

Урсгал зардал гэдэг нь төсвийн санхүүжилтийн өдөр тутмын хэрэглээнд дахин ашиглагдахгүйгээр нэг удаа зарцуулагдах зардлыг хэлнэ. Төсвийн урсгал зардал нь төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөвт байгууллагууд төрийн үйлчилгээг хэвийн үзүүлэх, эдийн засгийн тодорхой салбарт төрөөс санхүүжилт олгох, татаас өгөх, санхүүгийн тусламж үзүүлэхэд гарах зардлын төрөл юм.

Хөрөнгийн зардал гэдэг нь үндсэн капитал ба нөөцийн өсөлтийг бий болгохтой холбогдон гарах төсвийн зардал болно. Хөрөнгийн зардал нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх шинж чанартай байна.

Хөгжиж буй 43 орны 20 жилийн дата өгөгдөлд суурилан хийсэн судалгаагаар зарлагын нийт түвшин тогтмол байна гэж үзвэл хөрөнгийн зардлаас урсгал зардал руу дахин хуваарилах нь урт хугацааны эдийн засгийн өсөлтийг

¹⁹ Бямбажавын Энх-Амгалан et al. 2013. Эконометрик

²⁰ Дэлхийн банк. 2011. Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээний арга хэрэгсэл

дэмжинэ гэж дүгнэсэн байна.²¹ Турк Улсад орон нутгийн төсвийн зардлын 24 хувь нь усжуулалтад зарцуулагддаг. Усалгааны хөрөнгө оруулалт дахь урсгал зардлын эзлэх хувь 44 хувь, харин урсгал зардалд эзлэх үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардлын хувь ердөө 2 хувь байгаа боловч усжуулалтай холбоотой үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардал нь шинэ хөрөнгө оруулалтаас илүү өндөр өгөөж авчирдаг гэдгийг судалгаагаар тогтоосон. Жишээлбэл, Энэтхэг Улсад усалгааны ашиглалт, засвар үйлчилгээний зардлын өгөөжийн хувь хэмжээ 29-40 хувь байдаг.²² Хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр ахиу өгөөж буурах нь бүтээмжгүй байдлыг бий болгодог. Энэ нь урсгал зардлыг нэмэгдүүлж буй цалингийн зардал дийлэнх хувийг эзэлж байгаатай холбоотой. Урсгал зардлын нөлөө (хөдөө аж ахуйн зардлын үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь) хөрөнгийн зардлаас хоёр дахин их (1998-1999 оны санхүүгийн жилээс 2000-2001 оны санхүүгийн жил хүртэл Энэтхэг Улсын бүх мужуудад урсгал зардлын хувьд дунджаар 5.6 хувь, хөрөнгө оруулалтын зардлын хувьд 2.2 хувь) байна. Энэтхэгийн Пунжаб мужид нийт зардлын 80 гаруй хувийг цалингийн зардал эзлэх ба үйл ажиллагааны зардалд төсөв бага хуваарилагддаг. Мөн усалгааны ашиглалт, засвар үйлчилгээний зардлын 87 орчим хувь (2001/02 онд) нь цалингийн зардалд зарцуулагдаж байгаа нь бодит ажлыг үнэлэхэд хүндрэл учруулдаг.²³

4.Цалингийн ба цалингийн бус зардал

Капитал үр ашигтай байх эсвэл урсгал зардал тэнцвэртэй байх нь улс орны онцлогоос шалтгаалан өөр байдаг хэдий ч урсгал зардлын бүтцэд цалингийн зардал дийлэнх байр суурийг эзэлдэг. Үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардал гэх мэт урсгал зардлын бусад бүрэлдэхүүн хэсгийг санхүүжүүлэх нь өндөр ашиг авчрах боломжтой.²⁴ Үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардалд зарцуулах зардлын түвшнийг урьдчилан тогтоосон хэм хэмжээ байхгүй. Жишээлбэл, цалин хөлсний зардал нийт урсгал зардлын 60 хувиас хэтэрсэн тохиолдолд хөдөө аж ахуйн салбарт үзүүлж буй үйлчилгээний үр нөлөө буурна гэж үздэг. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын нийт зарлагын бага хувийг үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардалд хуваарилахад хүргэдэг. Олон улсын жишиг үзүүлэлтээр цалин, үйл ажиллагааны зардлын харьцааг 60-40 (эсвэл 1.5:1) гэж үздэг бол 2002/03 оны Пакистан Улсын Баруун хойд хилийн мужид байрлах Хөдөө аж ахуй, мал аж ахуйн хэлтсээс цалин-цалингийн бус зардлын харьцаа хамгийн багадаа 3:1-ээс доошгүй, хамгийн ихдээ 32:1 хүртэл байна гэж үздэг байна.

5.Энгийн нийцлийн дүн шинжилгээ

Төсвийн хуваарилалт нь тухайн салбарын зорилт, стратегитай хэрхэн уялдаж байгааг тодорхойлоход энгийн нийцлийн дүн шинжилгээг хэрэглэнэ. Жишээлбэл, хэрэв Засгийн газрын зорилго нь өрхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах болон хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг дэмжихэд чиглэгдэж байгаа бол энгийн нийцлийн дүн шинжилгээг хийхдээ эмзэг бүлгийн өрхүүдэд хүнсний

²¹ Devarajan, S., V. Swaroop, and H. Zou. 1996. "Төсвийн зарлагын шинжилгээний бүрэлдэхүүн ба эдийн засгийн өсөлт"

²² Pradhan, S. 1996. "Төсвийн зарлагын шинжилгээг үнэлэх нь"

²³ Дэлхийн банк. 2003. "Энэтхэг Улсын Пунжаб мужийн хөдөө аж ахуйг сэргээх нь"

²⁴ Devarajan, S., V. Swaroop, and H. Zou. 1996. "Төсвийн зарлагын шинжилгээний бүрэлдэхүүн ба эдийн засгийн өсөлт"

²⁵ Anson, R., and E. Zegarra. 2008. Гондурас Улс: Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээний үнэлгээ ба стратеги.

хүртээмжтэй байдал, хүнсний аюулгүй байдал, нийгмийн хамгааллын сүлжээтэй холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлж буй яамд, институтүүдийн хамрах хүрээг хэмжүүр болгон авч үзэх нь зүйтэй.

Гондурас Улсын хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээний тоймд хөдөө аж ахуйн салбарын стратеги нь Хүнсний хангамж, аюулгүй байдлын тусгай хөтөлбөр (цаашид ХХАБТХ гэх)-тэй нийцэж байгаа эсэх, цаашлаад тухайн салбарт төсөвлөж буй төсвийн бодит хуваарилалттай нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн байна. Тухайлбал, 2004 онд салбарын яамдын зарлага нь ХХАБТХ-т тусгасан стратегийн дагуу нэгтгэгдсэн бөгөөд энэ нь төсвийн хуваарилалт, хөтөлбөр хоорондын уялдаа холбоог (хувиар) тооцоолох боломжийг бүрдүүлсэн. Доорх хүснэгтээс салбарын нийт зардлын ердөө 30 орчим хувь нь ХХАБТХ-ийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэж байгааг харж болно (Хүснэгт 6). Олон улс оронд энэхүү загварыг ашигладаг. Энэ жишээ нь төсвийн зарлагын хэд хэдэн шинжилгээнд ашиглагддаг энгийн нийцлийн шинжилгээг харуулж байна.

Хүснэгт 6: Гондурас Улсын стратегийн баримт бичигт хийгдсэн төсвийн хуваарилалтын харьцуулалт, 2004

ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУСГАЙ ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН СТРАТЕГИ	ДҮН (сая ам.дол)
Зах зээлийг хөгжүүлэх, худалдааны хэлэлцээрүүд	-
Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй	0.15
Технологийн инновац	3.00
Хөдөө аж ахуйн боловсрол	1.17
Хөдөө аж ахуйн/орон нутгийн санхүү	6.70
Орон нутгийн хөгжил болон усжуулалтын дэд бүтэц	5.30
Байгалийн баялгийн тогтвортой байдал	20.0
Газрын хүртээмж, шүүхийн аюулгүй байдал, нийгмийн тэгш байдал	6.75
Нийт	43.07
Төсвийн нийт зарлага	144
Стратегийг дэмжихэд төсвийн зардлын эзлэх хувь	30%

В.ТЕХНИКИЙН ҮР АШГИЙН ТООЦООЛОЛ

Техникийн үр ашгийн талаарх ойлголт

Хэрэв бодит гарсан зарлага нь төсөвлөсөн хэмжээнээс бага байсан бол зөрүүг хэрхэн зохицуулсан бэ? Төсөв батлагдсаны дараа төсвийн хуваарилалтад дахин зохицуулалт хийсэн үү? Орлогын хүрэлцээгүй байдлаас (мөнгөний урсгал) төсөвлөгдсөн төсвийн зарцуулалт хийгдээгүй тохиолдлууд бий юу? Эсвэл энэ нь ТЕЗ бага хэмжээний зарцуулалт хийсэнтэй холбоотой дараа дараагийн хуваарилалтууд хийгдэхгүй байх

шалтгаан болсон уу? Эдгээр асуултуудад хариулахад төсвийн зарцуулалт, тайлагнал, мөнгөний урсгал, төсвийн хэрэгжилтийн үйл явцыг ойлгох нь зүйтэй.

Тухайн төсвийн зарцуулалт нь төлөвлөсний дагуу хийгдээгүй тохиолдлууд байсан уу? Хэрэв тийм бол шалтгаан нь юу байсан бэ? Энэ нь мөнгөний урсгалтай холбоотой юу? Эсвэл санхүүжилтийн тогтолцоонд хойшлуулсан тохиолдлууд гарсантай холбоотой юу? Эдгээр хүчин зүйлүүд нь хөдөө аж ахуйн салбарт хамааралтай юу эсвэл бусад салбаруудад ч мөн түгээмэл ажиглагддаг уу?

Санхүүгийн удирдах болон хэрэгжүүлэгч агентлагуудын худалдан авалтын чанар нь техникийн үр ашигт хэрхэн нөлөөлж байна вэ? Энэ хүрээнд төсвийн зарлагын мөшгөх судалгаагаар эсвэл үндэсний болон бүс нутгийн хэмжээнд чадавхын судалгааны нэг хэсэг болгон үнэлгээ хийх нь зүйтэй.

Санхүүгийн тайланг ямар давтамжтай боловсруулдаг вэ? Мэдээллийн иж бүрэн байдал хангагдаж чадаж байна уу? Худалдан авалтын үйл явц ил тод хэрэгждэг үү? зэрэг эдгээр асуултад үндэслэн санхүүгийн удирдлага болон худалдан авалтын үйл явцыг үнэлэн, илүү сайжруулах арга замыг тодорхойлно.

Төсвийн зарлагын техникийн үр ашгийг үнэлэх нь

Төсвийн зарлагын мөшгөх судалгаа (ТЗМС)

Төсвийн зарлагын мөшгөх судалгаа нь төсвийн нэгдсэн урсгал буюу орлого, зарлагыг мөшгөх арга юм.

Уганда Улсын хөдөө аж ахуйн салбарын төсвийн тайланд²⁶ 2005 оны 06 сараас 2007 оны 08 сар хүртэлх хугацаанд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн техникийн үр ашгийг үнэлэх зорилгоор Төсвийн Зарлагын Мөшгөх Судалгаа (ТЗМС) хийсэн байна. Дөрвөн үндсэн алхмаас бүрдэх уг аргачлалын уялдаа холбоог доорх графикаас харна уу.

Зураг 4: Хөдөө аж ахуйн салбарын орц, гарц, үр дүнгийн уялдаа холбоо



Эх сурвалж. Дэлхийн банк

Алхам 1: Хөдөө аж ахуйн салбар дахь Төсвийн Зарлагын Мөшгөх Судалгаа (ТЗМС)-д үр дүнгийн уялдаа холбоог тодорхойлох

Өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуйн салбар дахь үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд нэмэлт зарлага гаргахгүйгээр бүтээгдэхүүн, гарцыг бий болгохын тулд орц, гарц, үр дүнгийн уялдаа холбоог тодорхойлох шаардлагатай. Зураг 5-д хөдөө аж ахуйн салбарт эдгээр нэр томьёог хэрхэн ашиглаж болох, хоорондын уялдаа холбоог харуулахыг зорив.

Үр дүн нь оролцогч талуудын хүрэхээр зорьж буй өөрчлөлт, орц нь түүнд хүрэх арга хэрэгсэл, гарц нь цаг хугацааны явцад бий болох чухал үзүүлэлтүүд юм. Орцыг ахиу бүтээгдэхүүн, гарц, үр дүнтэй шууд холбоход цаг хугацааны хувьд хоцрогдлоос үүдэлтэй хүндрэлүүд учирдаг. Жишээлбэл, борлуулагчтай гэрээ байгуулах, барилгын ажил хийх нь орцод тооцогдох бөгөөд худалдааны зах байгуулах нь гарц болно. Байгуулсан захад худалдаачид, газар тариалан эрхлэгчид худалдаа наймаа эрхэлснээр зах зээлд хэрхэн нөлөөлж байгаа нь үр дүн болох юм.

МАН эрхлэгчид малын вакцинжуулалтад (орц) хамрагдсанаар мал эрүүлжиж (гарц), илүү үр өгөөж (үр дүн) авчирна. Эдгээр үр дүнгийн уялдаа холбоо нь зорилтот болон зорилтот бус өрхүүдэд үзүүлж буй нөлөөллийг харьцуулж нөлөөллийн үнэлгээг

хийж нарийвчлан судлах шаардлагатай болдог бөгөөд тухайн үнэлгээ нь үр дүнд хүрэх, баримтжуулахтай холбоотой тодорхой цаг хугацааг шаарддаг.

Хөдөө аж ахуйн үндэсний зөвлөх үйлчилгээний байгууллагын хөтөлбөрт уг нарийвчилсан нөлөөллийн үнэлгээг хийсэн хэдий ч бусад нэмэлт хөтөлбөрүүдийн үнэлгээг хийхэд цаг хугацаа, нөөцийн хувьд боломжгүй байсан тул Төсвийн зарлагын мөшгөх судалгааны аргачлалыг ашигласан. Уг аргачлал нь төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх үйл явцад гарч буй үр ашиггүй байдлыг судлах юм. Төсвийн зарлагын мөшгөх судалгааны аргачлалыг ашиглан төслийн үр шимийг хүртэгсэд, төрийн үйлчилгээ үзүүлж буй албан хаагчид, орон нутгийн засаг захиргаа, хөдөө аж ахуйн салбарын ажилтнууд, төслийн удирдлагын нэгжийн ажилтнууд, улс төрчидтэй төрийн үйлчилгээний чанар болон төслийн гүйцэтгэлийн талаар бүлгийн хэлэлцүүлэг хийх замаар зохион байгуулж чанарын судалгаа хийж гүйцэтгэсэн. Тоон (Төсвийн зарлагын мөшгөх судалгаа) болон чанарын (бүлгийн ярилцлага) судалгааг хослуулан хэрэглэснээр төрийн үйлчилгээний чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, төслийн хэрэгжилтийн үйл явц дахь үйл ажиллагааны үр ашгийг үнэлэх боломж бүрдэнэ. Хөдөө аж ахуйн үндэсний зөвлөх үйлчилгээний хөтөлбөрийг үнэлэхэд сонгогдсон дүүргүүд дэх нөлөөллийн үнэлгээний тоон үр дүнг чанарын үнэлгээтэй хамт авч үзсэн.

Алхам 2: Техникийн үр ашигт дүн шинжилгээ хийхэд үйл ажиллагааны хүрээг бий болгох

Үйл ажиллагааны зорилгоор үргүй зардал, алдагдал, үр ашиггүй байдлын ялгаатай талыг ойлгох нь чухал. Үргүй зардал болон алдагдлыг үр ашиггүй байдлаас өөр аргаар тодорхойлдог. Тухайлбал, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, хууль бус үйлдлийн эсрэг хариуцлагыг сайжруулах замаар илүү өндөр урамшуулал олгох зэргээр тодорхойлох боломжтой. Харин төрийн үйлчилгээний үр ашиггүй байдал нь бодлого, технологи, удирдлагаас хамаарсан оновчтой бус шийдвэрүүдтэй холбоотой байдаг тул илрүүлэхэд хүндрэлтэй бөгөөд үнэлгээний явцад тухайн төрийн үйлчилгээний талаар илүү өргөн хүрээний мэдлэгтэй байхыг шаарддаг.

Цаг хугацааны явцад өөрчлөгдөж буй нөхцөл байдлаас шалтгаалан орцыг хослуулан хэрэглэх, эсвэл гарцын хэлбэрүүд өөрчлөгддөгөөс шийдвэр гаргах явцад үр ашиггүй байдал үүсдэг. Жишээлбэл, Засгийн газар хэдийгээр зөв зүйл хийж байгаа ч буруу механизм (хүргэж буй арга хэрэгсэл) ашигласнаар үр ашиггүй байдал үүсэж болзошгүй юм. Энэ нь тогтолцооны сул тал, чадавхгүй байдал, удирдлагын хариуцлагагүй байдал, муу төлөвлөлт, авлига зэрэг хүчин зүйлсээс хамаарч болно.

Үргүй зардлын жишээнд 1)ХХАХҮЯ болон Орон нутгийн засаг захиргаа, эсвэл бусад яам, агентлагууд хоорондох захиргааны чиг үүргийн давхардал; 2)Төслийн хэрэгжилтийн явцад гэрээний маргаан үүссэнтэй холбоотой хугацаа хойшилсноор зарлага хэтрэх; 3)Шаардлага хангаагүй үнэлгээ, ТЭЗҮ-ийн ажил хоцрогдсоноор зарлага хэтрэх; 4)Биет хөрөнгийн засвар үйлчилгээ муу байгаа нь усжуулалт, замын дэд бүтэц зэргийг дахин сэргээн засварлах зэрэг багтана.

Санхүүжилт нь төлөвлөгөөний дагуу тухайн орцонд зохих ёсоор зарцуулаагүй тохиолдолд алдагдал үүсдэг. Алдагдлыг илрүүлэх нэг арга нь санхүүгийн болон биет нөөцийн урсгалыг мөшгөх явдал юм. Энэ нь Засгийн газрын шатлал хоорондын санхүүжилтийн урсгалыг мөшгөх буюу Төсвийн Зарлагын Мөшгөх Судалгаанд

ашигладаг аргачлал юм. Жишээлбэл, зорилтот ашиг хүртэгсдэд тухайн худалдаж авсан малын үр өгөөжийг хүртэхгүй байх явдал юм. Төрийн үйлчилгээнд гарч буй энэхүү алдагдал нь тухайн үйлчилгээг хүргэх (гарц) явцад зардлыг нэмэгдүүлж (орц), улмаар үр ашгийг хэмжихэд хүндрэл учруулдаг. Энэхүү алдагдал нь бодлого, технологи, удирдлагатай холбоотой шийдвэр гаргалтын үр дагавар биш тул үйл ажиллагааны зорилгоор тухайн алдагдлыг тусад нь тодорхойлох нь зүйтэй.

Алхам 3: Үр ашгийн үзүүлэлтүүдийг сонгох

Үр ашгийг хэмжих чухал үзүүлэлт нь нэгжийн өртөг (нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардал) юм. Хэрэв бусад хүчин зүйлс тогтмол гэж үзвэл, нэгжийн өртгийг бууруулах нь үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлнэ. Тиймээс нэгж өртгийн түвшнийг тооцоолох нь чухал. Одоогийн нэгж өртгийн түвшин мөн тохиромжтой эсэхийг үнэлэх хэд хэдэн арга бий. Жишээлбэл, худалдаж авсан бүтээгдэхүүний нэгжийн өртгийг зах зээлийн үнэтэй харьцуулах, хот болон орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгжийн өртгийг хооронд нь харьцуулах.

Алхам 4: Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж, үр ашиггүй байдалд юу нөлөөлж байгаа талаар таамаглал дэвшүүлэх

Энэ нь нэгжийн өртгийг механикаар өсгөх болон бууруулж буй хүчин зүйлсийг тодорхойлох ба эдгээр хүчин зүйлсийн үндсэн шалтгааныг олж тогтоох, үүний эсрэг арга хэмжээг авах нь Орон нутгийн засаг захиргаа, ХХААХҮЯ болон Засгийн газрын түвшинд хэлэлцэх асуудал юм.

Г. ҮР НӨЛӨӨНИЙ ТООЦООЛОЛ

Хөтөлбөрийн зарлагын үр нөлөөг тооцоолох нь

Санхүүжүүлэн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд үр дүнд хүрэхэд зарлагын үр нөлөө ямар хэмжээнд байсан бэ? Бүх хөтөлбөрийн үр нөлөөг (эсвэл мөнгөн үнэ цэнийг) тооцоолох боломжгүй тул гол төсөл хөтөлбөрүүдийг сонгон үнэлснээр цаашид дүн шинжилгээг цогц байдлаар хийх эхний алхам болох юм. ХХААХҮЯ-аас үзүүлж буй ямар үйлчилгээ төрөөс илүү дэмжлэг, туслалцаа авдаг вэ? Төрийн үйлчилгээг хүргэхэд гарах нэгж зардлын хэмжээ хэд вэ? Эдгээр үйлчилгээний нэгж зардлыг бууруулах боломж бий юу? гэсэн асуултуудад хариулт өгөх нь үр нөлөөний тооцоолол хийхэд чухал.

ХАА-н салбарын гол шалгуур үзүүлэлтүүд

Үр нөлөөний тооцоолол хийхэд ХАА-н салбарын үр дүнгийн шалгуур үзүүлэлт чухал байдаг. НҮБ-ын Хүнс Хөдөө аж ахуйн байгууллага, Хөдөө орон нутгийн хөгжлийн хандивлагч платформ ба Дэлхийн банкнаас олон улсын хяналт шалгалт, үнэлгээний дата өгөгдлийн шалгуурт нийцэх үндэсний түвшинд хязгаарлагдмал нөөцөөр байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилгоор үр дүнд суурилсан 86 шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргаснаас 19 тэргүүлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлсон байна.²⁷

²⁷ Дэлхийн банк. 2011. Хөдөө аж ахуйн салбар дах төсвийн зарлагын шинжилгээг хэрхэн сайжруулах вэ?

1. ХАА-н салбарын төсвийн зарлага, ДНБ-д эзлэх хувь
2. ХАА-н урамшуулалд зарцуулсан хэмжээ, хөдөө аж ахуйн салбарын төсөвт эзлэх хувь
3. Хөдөө орон нутагт 5 хүртэлх насны хоол тэжээлийн дутагдалтай хүүхдүүдийн хувь
4. Хүнсний үйлдвэрлэлийн индекс
5. Хөдөө аж ахуйн нэмэгдсэн өртгийн жилийн өсөлт, хувь
6. Хөдөө орон нутаг дахь амьжиргааны түвшин доогуур хүн амын эзлэх хувь, нийт хүн амын амьжиргааны түвшин доогуур хүн амтай харьцуулсан хувь
7. Гол үр тарианы ургацын хувь хэмжээний өөрчлөлт
8. Мал аж ахуйн салбарын нэмэгдсэн өртгийн жилийн өсөлт, хувь
9. Загасны үйлдвэрлэлийг загасны нөөцийн хувиар тооцох
10. Ойн талбайн эзлэх хувь
11. Банк, санхүүгийн үйлчилгээг ашигладаг орон нутгийн хүн амын эзлэх хувь
12. ХАА-н салбарын судалгаанд оруулсан төсвийн хөрөнгө оруулалт, ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь
13. Усалгаатай газар, тариалангийн талбайн хувь
14. Хөдөө аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, эргэлтийн хөрөнгийн хувь хэмжээний өөрчлөлт
15. Нөхөрлөлийн болон үйлдвэрлэлийн байгууллага, нийгэм хоршоодын гишүүнчлэлтэй тариаланчдын хувь
16. Хөдөө аж ахуйд ашиглах усны таталт, нийт цэвэр усны таталтын хувь
17. Тусгай хамгаалалттай газрын талбайн өөрчлөлтийн хувь
18. Усны сав газрын хөрсний алдагдлын өөрчлөлтийн хувь
19. Хуулиар зөвшөөрөгдсөн газар эзэмших эрх бүхий газар нутгийн эзлэх хувь

Эх сурвалж: Хөдөө орон нутгийн хөгжлийн хандивлагч платформ (2008)

Төсвийн хуваарилалтыг төсвийн хязгаарт багтаан салбарын зорилго, стратегийн дагуу хийх бөгөөд дунд хугацааны төсвийн төсөөллийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ. Төсвийн санал хураалт УИХ-аар батлагдсаны дараа төрийн байгууллагуудад төсвийн хөрөнгийг хуваарилснаар хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлнэ. Төрийн байгууллагууд санхүүгийн тайланг Сангийн яаманд хүргүүлэх ба тухайн салбарын зорилтуудын хамаарал, зураг төсөл, хэрэгжилтийн үр ашиг, нөөц ашиглалтын үр ашиг, тогтвортой байдал зэргийг үнэлж хяналт, шинжилгээ үнэлгээг хийж гүйцэтгэх бөгөөд гарсан үр дүнд суурилан ирээдүйн төсвийн төлөвлөлт болон төсвийн үйл явцыг тодорхойлно. Төсвийн хуваарилалтын үйл явцад хуваарилалтын үр ашгийг, төсвийн гүйцэтгэлийн үйл явцад техникийн үр ашгийг үнэлнэ. Дэлгэрэнгүйг хавсралтын хүснэгт 13, 14-өөс тус тус харна уу.

Д. ОРЧНЫ /СВОТ/ ШИНЖИЛГЭЭ

Орчны /Свот/ шинжилгээний арга зүй

Төсвийн зарлагын шинжилгээ хийхэд салбарын зорилт, стратегид салбарын тойм шинжилгээ хийх шаардлагатай. Тиймээс тухайн салбарын тулгамдсан асуудал, цаашдын зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд салбарын орчны /свот/ шинжилгээг холбогдох судалгаа баримтад үндэслэн дараах ерөнхий арга зүйн хүрээнд хийж гүйцэтгэж болно.

Дотоод хүчин зүйл: хөрөнгө, материал, ажиллах хүчин, технологи, инновац, чадавх, менежмент зэрэг салбарын дотоод боломжийн эерэг, сөрөг талыг нягтлан үзэж, одоогийн түвшин, цаашдын хөгжлийн хандлагыг тодорхойлох.

Гадаад хүчин зүйл: байгаль орчин, институт (төрийн бодлого, олон улсын болон дотоодын хууль, журам, тогтсон заншил), дотоод, гадаад зах зээлийн төлөв байдал, өрсөлдөгч зэрэг салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад хүчин зүйлсийн таатай болон таагүй нөлөөг салбарын хэмжээнд тодорхойлох.

Салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх хамгийн чухал дотоод хүчин зүйлсийн давуу болон сул тал, гадаад хүчин зүйлсийн боломж ба аюулын жагсаалтыг Хүснэгт 7-ийн дагуу нэгтгэн гаргасан.

Ливан Улсын хөдөө аж ахуйн зарлагын тойм нь хөдөө аж ахуйн давуу болон сул тал, боломж, аюул занал зэрэгт дүн шинжилгээ хийн, түүнийг ашиглан Ливаны хөдөө аж ахуйн харьцуулсан давуу талыг тодорхойлсны үндсэн дээр төсвийн зарлагатай холбоотой зөвлөмжийг бэлтгэсэн. Орчны /свот/ шинжилгээ нь Ливан Улсын хөдөө аж ахуйн салбарын стратегийн зорилтууд нь (i) дотоодын зах зээлд эзлэх байр суурь, Арабын зах зээлд экспортын хэмжээг нэмэгдүүлэх (ii) Европ руу экспортлох хоёрдогч том боломжийг бий болгох (iii) Хүнсний чанар, аюулгүй байдалд илүү анхаарахад илүү чиглэсэн. Свот шинжилгээгээр Ливан Улс нь өндөр зэрэглэлийн шинэхэн жимс, хүнсний ногоо болон Агро аж ахуйн боловсруулалтын зах зээлд илүү тохиромжтой болохыг харуулна.

Хүснэгт 7: Ливан Улсын хөдөө аж ахуйн салбарын орчны/свот шинжилгээ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
• Жимс, хүнсний ногооны цэвэр импортлогч болох Персийн булан Европын зах зээлтэй илүү ойр. • “Ливан алим” зэргээр Персийн булангийн улс орнуудад эергээр танигдаж хүлээн зөвшөөрөгдсөн. • Газрын дундад тэнгисийн уур амьсгал нь удаан хугацаагаар ургац хураах, ургацын олон янзын байдлаар хангасан • Жимс, хүнсний ногоог ихэвчлэн гараар хурааж, бохирдолгүй газар цуглуулдаг. бөгөөд 100 хувь байгалийн жимс, хүнсний ногоогоор хийдэг Ливаны шүүсийг өндөр чанартай гэж үздэг. • Бусад хөгжиж буй орнуудтай	• Хүнсний чанар, аюулгүй байдлын стандарт дутмаг. • Ойрх Дорнод ба Хойд Африкийн улсуудтай харьцуулахад өндөр өртөг бүхий бүтэцтэй. • Институтийн хуваагдал нь хүндрэл учруулдаг. • Цаг тухайд нь хүргэлт хийх логистикийн хангамж муу. • Усны хомсдол нь үйлдвэрлэлийн хязгаарлалтыг үүсгэдэг бөгөөд усалгааны дэд бүтэц дэх хөрөнгө оруулалт хангалтгүй. • Маркетингийн дэд бүтэц сул. • Өндөр өрийн дарамттай. • Газар ашиглалтын төлөвлөлт дутмаг, газар тариалангийн хэсгийн гол

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
харьцуулахад хөдөө аж ахуйн орцыг ашиглахад бэлэн, хүртээмжтэй байдаг. - Хөрш зэргэлдээ орнуудаас (голчлон Сири, Египет Улс) хямд, улирлын чанартай хөдөө аж ахуйн ажиллах хүчин авах боломжтой. - Хүнсний лаазлах үйлдвэр сайтай ба Персийн булангийн улс орнууд, Европын холбоо, Хойд Америкт зах зээлийн хүрээ өргөн.	газрууд хот суурины газар болсон. - Газар эзэмшил нь маш их хуваагдалтай, хагас цагийн фермийн аж ахуй эрхлэлт давамгайлсан. - Хөдөө аж ахуйн салбар, орон нутгийн хөгжлийн байгууллагууд улс төржсөн тул хөдөө аж ахуйн хөтөлбөр, бодлого нь улс төрийн нөлөөлөл ихтэй.
БОЛОМЖ	АЮУЛ ЗАНАЛ
- Органик жимс, хүнсний ногоо нь ердийн бүтээгдэхүүнээс илүү өндөр урамшууллыг санал болгодог. - Дээд зэргийн бүтээгдэхүүн нь хямд үнэтэй бүтээгдэхүүнээс илүү тогтвортой ашигтай. - Үнийн цочролоос үүдэлтэй хүнсний барааны үнэ нэлээд унасан нь хүнсний татаасыг багасгаж улмаар хүнсний чанар, аюулгүй байдалд хийгдэх судалгаанд улсын хөрөнгө оруулалтыг дахин зарцуулах боломжтой. - Сири Улстай чөлөөт худалдааны гэрээтэй ба тус улсын хил дагуу нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх барааны урсгал нэмэгдсэн. - Европын Холбоонд зориулсан өндөр үнэ цэнэтэй органик бүтээгдэхүүн (жишээ нь чидун жимсний тос, цуу, саван) - Жимс, хүнсний ногоог шинээр гарч ирж буй эко аялал жуулчлалтай нэгтгэх боломжтой. - Усны нөөц бүхий ялангуяа өмнөд хэсгийн хөгжил буурай хэсгүүд (жишээ нь Гермел ба Аккар)	- Египет, Сири, Турк Улс Ливаны экспортын гол зах зээлд өрсөлдөгч бөгөөд Иордан Улс нь шинээр гарч ирж буй аюул гэж үзэж байна. - Уур амьсгалын өөрчлөлт - Ирээдүйд үр тарианы үнийн цочролд өртөх өндөр эрсдэлтэй. - Урт хугацаанд гол орцууд дахь үнийн өсөлт (жишээ нь газрын тос, бордоо гэх мэт) - Хөдөө аж ахуйн стратегийг цаашид баримтлах улс төрийн сонирхол дутмаг - Хотжилтын улмаас далайн эргийн хамгийн үнэ цэнэ бүхий тариалангийн талбайг алдах эрсдэлтэй. - Уулархаг газар хөрсний элэгдэл ихтэй. - Персийн булангийн улс орнуудын зах зээлд импортын хатуу стандарттай ба Ливан Улсын дүр төрх алдагдсан нь пестицидийн үлдэгдлийн хяналт байсантай холбоотой.

Эх сурвалж: Дэлхийн банк 2010

Е.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хөдөө аж ахуйн ТЗШ нь төсвийн зардлын хамрах хүрээ, үр нөлөөг үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хянаж үзэх ёстой. Гүйцэтгэлийг хэмжихэд ямар үзүүлэлтүүдийг ашигладаг вэ? Төсвийн зарцуулалтын үр дүнг хэн хариуцах вэ? Үүнд хэн хариуцлага хүлээх вэ?

Өгөгдөлд тавигдах шаардлага:

- Хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалт, үйлчилгээний хамрах хүрээ, үр нөлөө, төсөвт өртөг.
- Засгийн газраас хэрэгжиж буй үндэсний түвшний гүйцэтгэлийн хяналтын үзүүлэлтүүд
- Оролцогч талуудад хариуцлага хүлээлгэх албан ёсны сувгууд

ХШҮ-ний тогтолцоонд дүн шинжилгээ хийхдээ авч үзвэл зохих хэд хэдэн асуултууд гарч байна. Үүнд:

- Салбарын зардлын гол орц, гарц, завсрын үр дүнг үнэлдэг. Функциональ, институциональ эсвэл тухайн салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний систем бий юу? Сангийн сайд болон хөдөө аж ахуйн сайд зэрэг дээд шатны удирдлагаас ХШҮ-ний үйл ажиллагааны тогтолцоог шаардаж байна уу? Одоогийн ХШҮ-ний тогтолцоо гүйцэтгэлд суурилсан төсвийн хуваарилалтын тогтолцоог дэмжиж байна уу?
- Төсөв, үр дүн, хариуцлагын хувьд илүү сайн үнэ цэнийг бий болгоход чиглэсэн удирдлагын болон институтын ямар хөшүүрэг байдаг вэ? (Энэ асуудал мөн үр ашгийн шинжилгээнд хамрагдаж байгааг анхаарна уу). Үнэлгээ нь улс орны түвшинд хамарч байна уу, гүйцэтгэлийг хэрхэн үнэлдэг вэ?
- Авлигыг бууруулах ямар механизм, хориг, арга хэмжээ байдаг вэ? Жишээлбэл, худалдан авах ажиллагаа болон санхүүгийн удирдлагын журам, холбогдох хяналт, аудит, худалдан авах үйл ажиллагааны үйл явц, олон нийтэд ил тод байдал зэрэг хамаарна.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч төсвийн захирагч нар (хөтөлбөрүүд, төсвийн удирдлагын нэгжүүд) зөвхөн төсвийн зарцуулалтад бус бодлогын үр дүнд хариуцлага хүлээх үү? Үр дүн, гүйцэтгэлийг урамшуулах систем байдаг уу? Үр дүнг хангаагүй тохиолдолд торгууль, шийтгэл ногдуулдаг уу? Хууль тогтоох байгууллага, хөдөө аж ахуйн салбар, байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн тайланг тогтмол цаг тухайд нь гаргадаг уу? Хөдөө аж ахуйн салбарын яам болон харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайлагнал бусад салбартай харьцуулахад ямар байна вэ?
- Хууль тогтоох байгууллага салбарын стратегийн бодлогын төсөв хуваарилалт, хэрэгжилт болон төсвийн зарцуулалтын хариуцлага, менежментийг сайжруулахад ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
- Төсвийн хуваарилалтын уялдаатай байдлыг хангах, төсвийн зарцуулалтыг сайжруулах, зардлыг давхардуулахгүй байх, улс орны болон салбарын тэргүүлэх чиглэл, стратегийн бодлоготой уялдуулах, төсвийн хөрөнгө оруулалтыг тэргүүлэх чиглэлд чиглүүлэх, оновчтой болгох, бодлого хэрэгжүүлэх байгууллага хоорондын зохицуулалт, тогтолцоо, хөшүүргийг хэрхэн үнэлж байна вэ?
- Чиг үүрэг, функцийн хувьд салбарын болон харьяа байгууллагын зардлыг

хянаж үнэлэх систем, тогтолцоо байдаг уу? Хэрэв байдаг бол үүнээс гарсан дүгнэлт, мэдээллийг шийдвэр гаргахад авч хэлэлцдэг үү? Хөдөө аж ахуйн салбарт ХШҮ-ний үр дүнтэй тогтолцоог бий болгоход ямар хязгаарлагч хүчин зүйл байна вэ?

Төсвийн зарлагын шинжилгээгээр макро түвшинд төрөөс явуулж буй бодлого, эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхээс гадна тухайн салбарын цаашдын чиг хандлагад дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

Төсвийн зардлын үр ашиг, тэгш байдлыг сайжруулахад чиглэсэн нотолгоонд суурилсан зөвлөмжийг тодорхойлох, өнгөрсөн хугацаанд зарцуулсан зардлын нөлөөллийн дүн шинжилгээ хийх, зардлын түвшин, бүтцийг салбарын зорилтууд болон хөдөө аж ахуйн өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлж буй бүс нутагтай уялдуулах, хүнсний аюулгүй байдал, төсвийн үйл явцын гүйцэтгэл зэргийг үнэлэх зэрэг орно. Байгууллагын хамрах хүрээ: Төсвийн зарлагын шинжилгээнд ямар төрлийн төрийн байгууллагуудыг хамруулахыг шийдвэрлэнэ. Хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд ихэвчлэн ТЭЗ, орон нутгийн засаг захиргаа, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хамруулсан байдаг. Хандивлагч болон төрийн бус байгууллагаас санхүүжүүлсэн үйл ажиллагаа, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгж байгууллагуудад татварын хөнгөлөлт үзүүлэх, далд татаас зэргийг салбарын төсвөөс гадуурх зардлыг ямар хэмжээнд төвлөрүүлэхийг мөн шийдвэрлэдэг.

Турк Улс макро түвшний төсвийн зарлагын шинжилгээ, түүний үр дүнд гарсан шинэчлэлийг хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээнд хийсэн жишээг онцолж байна. Үүний үр дүнд “Турк: Хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл” илтгэлд салбарын судалгаа, яриа хэлцэл нь макро түвшний төсвийн зарлагын шинжилгээний нэг хэсэг төдийгүй стратегийн зөвлөмж нь салбар байгууллагуудад шинэчлэлийг авчирсан байна. Дэлхийн банкны 2001 онд хийсэн Төсвийн зарлага, институтийн тойм судалгаагаар Турк Улсын төсвийн зарлага нь дотоодын нийт бүтээгдэхүүний зорилтот үзүүлэлт болох 0.8 хувиас давж 3 хувьтай тэнцэж байгаа нь төсвийн хүнд хямралын үеийг харуулж байна. Туркийн Засгийн газар төсвийн тогтолцоог боловсронгуй болгоход ахиц дэвшил гаргасан хэдий ч судалгааны явцад олон тооны дутагдалтай талууд нь ихэвчлэн хөдөө орон нутгийн байгууллагуудтай хамааралтай байв. Орон нутгийн зардлын талаарх мэдээллийг хэсэгчилсэн байдлаар гаргаж, дүн шинжилгээ хийж нарийн тайлбарлахад хүндрэлтэй байсан. Макро түвшний төсвийн зарлагын шинжилгээ хийсний дараа Засгийн газар (i) төсвийн хамрах хүрээ, ангиллыг сайжруулах (ii) төсөв боловсруулах үйл явцыг сайжруулах, салбарын яамдад итгэх итгэлийг сэргээх, дунд хугацааны хэтийн төлөвт бодлого, төсөв боловсруулах чадавхыг бэхжүүлэх; (iii) төсвийн гүйцэтгэл, санхүүгийн хариуцлагыг сайжруулахад чиглэсэн чухал алхмуудыг хийсэн. Үр дүнд нь 2003 онд Турк Улс Төсөв, санхүүгийн удирдлага, хяналтын тухай хуулийг баталсан. Төсвийн зарлагын удирдлагыг боловсронгуй болгохын тулд бүтцийн болон зохион байгуулалтын шинэчлэл хийхийг тус хуульд онцлон тусгажээ. (Дэлхийн банк 2005)

Нөлөөллийн үнэлгээ: Нөлөөллийн үнэлгээний цар хүрээг шийдвэрлэх нь. Энэ нь ихэвчлэн дата өгөгдөлд суурилан тодорхойлдог бөгөөд ихэвчлэн салбар бүрийн дэд хөтөлбөрүүдийн (жишээлбэл, судалгаа, усалгаа, бордоо гэх зэрэг) нөлөөллийг үнэлэх байдлаар явагддаг. Жишээлбэл, хөдөө аж ахуйн хөтөлбөрийн байгаль орчинд үзүүлэх нөлөө (нүүрс төрөгчийн хийн ялгарал) нь үндэслэлтэй эсэхэд үнэлгээ хийж болно.

Төсвийн зардлын үр ашиг, тэгш байдлыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй санал, санаачилгад тулгуурлаж болно. Үүнд: 1)төсвийн ерөнхий зохицуулалтыг сайжруулахын тулд Сангийн яамнаас гаргасан санал санаачилга, шийдвэрүүд, 2) хөдөө аж ахуйн салбарын хөгжилд чухал ач холбогдолтой бусад салбар дахь хөрөнгө оруулалт (жишээлбэл, хөдөө орон нутгийн зам болон бусад дэд бүтэц) 3)Төсвийн төвлөрлийг сааруулах, 4)орон нутгийн засаг захиргаанд төсөв шилжүүлэх механизм 5)хяналт, хариуцлага зэрэг багтана.

Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээнд дата өгөгдөл, мэдээлэлд тулгуурласан тоон нөлөөллийн үнэлгээ хийх нөөц, боломж бололцоо хомс байдаг. Хязгаарлагдмал өгөгдөл байгаа тохиолдолд үр дүнгийн үнэлгээ нь ихэвчлэн одоо байгаа нөлөөллийн судалгаа эсвэл бусад газар хэрэгжүүлсэн ижил төстэй төслүүдийн төсвийн зардлын гол дүгнэлтүүдийн талаарх судалгаа, тоймд тулгуурладаг.

Мөн Төсвийн зарлагын шинжилгээний явцад тоон болон чанарын судалгаа хийх ба ОУВС-аас төсвийн зарлагын шинжилгээ хийх арга, аргачлалыг Хавсралтын хүснэгт 12-ын дагуу боловсруулсан байна.²⁸

Вьетнамын хөдөө аж ахуйн төсвийн зарлагын шинжилгээ нь засгийн газрын төсөв Вьетнамын эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулахад чухал үүрэг бүхий нөлөөллийн судалгаанд тулгуурласан. Зардлын үр нөлөөг үнэлэхэд Засгийн газрын усжуулалт, зам, хөдөө аж ахуйн судалгаанд зарцуулсан зардал нь хөдөө аж ахуйн өсөлт, ядуурлыг бууруулахад ямар хувь нэмэр оруулсныг олж тогтоосон. 2002 онд хөдөө аж ахуйн өсөлтийг тодорхойлогч хүчин зүйлсийг тооцоолж, хөдөө аж ахуйн өсөлтийн хамгийн чухал эх үүсвэр болох усжуулалтад оруулсан төсвийн хөрөнгө оруулалт (хөдөө аж ахуйн өсөлтийн 28 хувийг эзэлдэг), дараа нь хөдөө аж ахуйн судалгаа (27 хувь) болохыг тогтоожээ. Эдгээр судалгаанаас гарсан дүгнэлтээр усалгаа нь өсөлтийн чухал хүчин зүйл байсан хэдий ч нийт услалтад хөрөнгө оруулах хөтөлбөр нь эдийн засгийн үр ашиггүй болсон байна. Дүгнэлт нь салбарын зардлын хөтөлбөрт зөвхөн хүлээн зөвшөөрөгдөх өгөөжтэй усалгааны хөрөнгө оруулалтыг сонгож, хуримтлалыг өндөр өгөөжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа газар тариалангийн судалгаанд төсвийн хуваарилалт хийх нь зүйтэй гэж үзсэн байна.

²⁸ ОУВС. 2022. Төсвийн зарлагын шинжилгээг хэрхэн хийх вэ?

1.5.3.Түгээх үе шат

Хэнд ямар байдлаар түгээх вэ?

Төсвийн зарлагын шинжилгээний тайлангийн зорилтот бүлгийг тодорхойлох нь

Тайлангийн бэлтгэх үе шатаас эхлэн дүгнэлт, зөвлөмж гарах хүртэлх үе шатуудад Сангийн яам болон салбарын яам (ХХААХҮЯ)-ыг идэвхтэй оролцоог хангаж ажиллах нь чухал.

Түүнчлэн дараах асуултуудад хариулах замаар төсвийн зарлагын шинжилгээний тайлангийн зорилтот бүлгийг тодорхойлж болно. Үүнд: Төсвийн зарлагын шинжилгээний тайланг хэнд хамгийн түрүүнд хүргэхийг зорьж байна вэ? Өөрөөр хэлбэл, төсвийн зарлагын шинжилгээний тайлан хэнд хамгийн их ач холбогдолтой бэ? Гол үүрэг гүйцэтгэгч эсвэл зөвлөмжийг хэрэгжүүлэхэд голлох байр суурь эзлэх оролцогч талууд бий юу?

Төсвийн зарлагын шинжилгээний үр дүнг хэлэлцэх, түгээх хамгийн оновчтой, үр дүнтэй арга юу вэ? Үр дүнг ямар дарааллаар хүргэвэл хамгийн үр нөлөөтэй, тохиромжтой байх вэ?

Орон нутгийн засаг захиргаа, Хувийн хэвшил, Эрдэм шинжилгээний байгууллага, Санхүүжүүлэгч байгууллагууд, Иргэний нийгмийн байгууллагууд гэх зэрэг оролцогч талуудыг (орон нутгийн болон бүс нутгийн түвшинд) хамруулсан хэд хэдэн фокус бүлгийн хэлэлцүүлэг, тэдний оролцоог хангасан сургалт зохион байгуулах нь үр дүнтэй. ХХААХҮЯ нь төсвийн зарлагын шинжилгээний үе шатуудад голлох байр суурийг эзэлж, мөн үндсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх бусад яам, агентлагууд, Сангийн яамтай хамтран ажиллах нь нэн чухал.

Хэвлэлд өгсөн ярилцлага, судалгааны тайлан, бодлогын талаарх товч танилцуулга зэрэг мэдээлэл түгээх арга хэрэгслийг тодорхойлох.²⁹ Жишээлбэл, Хүнсний бодлогын судалгааны хүрээлэн Дэлхийн хүнсний ирээдүйн чиг хандлагыг судалж 2020 онд тайлан гаргахдаа зорилтот бүлгээс хамаарч өөр өөр арга хэрэгслийг ашигласан байна. Тухайлбал, шинжээчдэд зориулан 206 хуудас бүхий нарийвчилсан дүн шинжилгээ хийсэн тайланг нийтэлсэн байна. Уг тайлан нь хязгаарлагдмал буюу зөвхөн шинжлэх ухааны бүлэгт зориулагдсан тайлан болсон. Сонирхогчийн бүлэгт мэдээлэл хүргэх зорилгоор 16 хуудас бүхий “Дэлхийн хүнсний ирээдүйн чиг хандлага 2020”: Чиг хандлага, Хувилбар, Сонголт” тайланг нийтэлжээ. Уг тайланд бодлого боловсруулагчид болон сэтгүүлчдэд зориулан чухал дүгнэлтүүдийг тоймлон багтаасан байна. Мөн хэвлэл мэдээлэл ба олон нийтэд зориулан хамгийн гол мэдээллийг товчоор хүргэсэн 2 хуудас бүхий мэдээг нийтэлсэн байна. Энэ нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон тайлан унших завгүй, өндөр түвшний бодлого боловсруулагчдад зориулсан болно (Зураг 5).

²⁹ von Grebmer, K., K., S. Babu, V. Rhoe, ба M. Rubenstein. 2005. “Хүнсний бодлогын судалгааг түгээх нь.” Зааварчилгаа. Олон улсын хүнсний бодлогын судалгааны институты

Зураг 5: Төсвийн зарлагын шинжилгээний тайланг зорилтот бүлгүүдэд хүргэх нь



Эх сурвалж: вон Грембер.2005.

2. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ, МОНГОЛ УЛСЫН ХУВЬД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

2.1. Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээний онцлог

Карибын орнуудад Төсвийн зарлагын шинжилгээ хийх арга аргачлалд Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын шинжилгээ дараах ерөнхий бүтэцтэй байна гэж үзсэн байдаг.³⁰

Хураангуй

Танилцуулга

Хөдөө аж ахуйн салбар дахь төсвийн зарлагын шинжилгээний хамрах хүрээг тодорхойлох нь

Агуулга

Төрөөс баримталж буй бодлого, хууль зүйн зохицуулалт

Төсвийн зарлагын институтын зохицуулалт

i. Гол оролцогч талууд

ii. Гол оролцогч талуудын хоорондын харилцаа

Сүүлийн үед гарсан шинэчлэл

Улс орны төсвийн зарлага

i. Бүх зарлага

ii. Салбарын төсвийн зарлага

ХХААХҮЯ

Бусад ТЕЗ

• Төсвийн дотоод шинжилгээ, аудитын сургамж

• Хөдөө аж ахуйн салбар дахь төсвийн зарлагын шинжилгээ

Хөдөө аж ахуйн салбар дахь ХХААХҮЯ-наас гаргасан ерөнхий тооцоолол

ii. НҮБ-ын ЗГ-ын чиг үүргийн ангилал, Эдийн засгийн бүх үйл ажиллагааны олон улсын стандарт аж үйлдвэрийн ангиллын дагуу гол дэд салбаруудын зарлагыг шинжлэх

iii. Олон улсын стандарт ангиллын дагуу сонгогдсон гол агентлагуудын зарлагыг шинжлэх

iv. Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох:

• Дотоод эх үүсвэр

• Гадаад эх үүсвэр

• Салбарын хүрээ дэх төсвийн зарлагын шинжилгээ

v. Санхүүжилт бүрийн төлөв, хандлага, хувь, өсөлтийн хувийг тодорхойлох:

Хөдөө аж ахуйн нөөцийг ашиглан улсын орлогод оруулж буй хувь нэмэр

Хөдөө аж ахуйн салбар дахь хуваарилалтын ашиглалт, сайжруулалтаас гарах боломжит хэмнэлт

i. Хэмнэлт

ii. Үр ашиг

iii. Үр дүнтэй байдал

³⁰ НҮБ-ын Латин Америк ба Карибын орнуудын Эдийн засгийн хороо. 2017. Карибын орнуудад Төсвийн зарлагын шинжилгээ хийх арга аргачлал

Дүгнэлт, зөвлөмж

Эх сурвалж

Хавсралт

Стандартын дагуу нарийвчлан дүн шинжилгээ хийсэн хүснэгтүүд

А. Төсөв

Б. Бодит ба төсөвлөсөн зардал

В. Орлого

Г. Тухайн тооцоололтой хамааралтай тэмдэглэл, тодорхойлолт, таамаглал, мэдээллийн эх сурвалж

Байгууллагын судалгааны мэдээллээс авсан стандарт хүснэгтүүд

НҮБ-ын ЗГ-ын чиг үүргийн ангиллын дагуу дэд салбаруудын хураангуй (дэд салбаруудад хамаарах тодорхой асуудлуудыг тусгасан байх)

Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн жагсаалт гэх мэт

2.2. Монгол Улсын төсөв, ХХААХҮ-ийн салбарын чиг хандлага

Монгол Улсын нэгдсэн төсөв нь Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын төсөв, Орон нутгийн төсвөөс бүрддэг. Улсын төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх болон тайлагнах гэсэн үе шатууд нь 3 жил дамнан тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм. Дүн шинжилгээ хийхэд төсвийн үе шат бүрд мэдээлэл цуглуулах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, төсвийн зарлагын өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийх, улмаар салбарын хэмжээнд дүгнэлт, зөвлөмж бэлтгэнэ.

Төсвийн төлөвлөлт нь төрийн санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн нэг бөгөөд улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулсан байна. Монгол Улсын хувьд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Алсын хараа 2050, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулна. Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг тусган хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, харин аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг боловсруулдаг. Хөдөө аж ахуйн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг салбарын түвшинд нарийвчилж тусган хэрэгжүүлэхэд чиглэгдсэн. Тус стратеги төлөвлөгөөнд салбарын эрхэм зорилгыг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэний сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг

эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна. ХХААХҮ-ийн салбар нь 2020 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ий 32.5 хувийг, нийт экспортын 5.6 хувийг, нийт ажиллагсдын 50 гаруй хувийг тус тус бүрдүүлж байна. Сүүлийн 10 жилийн хандлагаас харахад ХХААХҮ-ийн салбарын нийт эдийн засагт болон экспортод эзлэх хувь төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Салбарын төсвийн нийт зарлагын бүтцийг сүүлийн 10 жилээр авч үзвэл салбарыг дэмжих чиглэлээр тухайн үеийн төр, засгийн бодлого, шийдвэрээс хамааран жилээс жилд ихээхэн өөрчлөгдөж ирсэн байна.

ТХЗ-ууд, түүний шалгуур үзүүлэлтүүдээс ХХААХҮЯ-ны бодлогын түвшинд хариуцах нийт 10 зорилт, 17 шалгуур үзүүлэлт байна. Тогтвортой хөгжлийн эдгээр 10 зорилтоос 7 нь салбарын стратеги төлөвлөгөөнд бүрэн уялдаж туссан, 3 нь бүрэн бус боловч тодорхой хэмжээнд туссан гэж үзэж болохоор байна. Огт тусгаагүй зорилт байхгүй болно. Харин тус яамны бодлогын түвшинд хариуцах ТХЗ-ын нийт 17 шалгуур байгаа ба эдгээрээс салбарын стратеги төлөвлөгөө болон ТЭЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдтэй ижил буюу уялдаатай шалгуур үзүүлэлт байхгүй байна. Иймд цаашид салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг тодотгож ТХЗ-ууд болон Монгол Улсын “Алсын хараа -2050”-ын зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдтэй аль болох уялдуулж, улмаар Төсвийн хуулийн 1-р хавсралтад тусгагдах шалгуур үзүүлэлтүүдтэй нийцүүлэх нь зүйтэй.³¹

2.3. Төсвийн зарлагын шинжилгээнд хамаарлын тооцооллыг ашиглах нь

Хамаарлын шинжилгээ нь төсвийн зарлага болон үр дүнгийн уялдаа холбоо, түүний хүчний зэргийг тооцоолох боломжийг олгодог. Жишээ болгож Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлагын хэмжээ болон оны үнээрх хөдөлмөрийн бүтээмжийн хоорондох хамаарлын /корреляцийн/ коэффициент, детерминацийн коэффициентийг тооцоолсныг доорх зурагт харуулав.³²

Зураг 6: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага ба хөдөлмөрийн бүтээмжийн хамаарал



Эх сурвалж. ҮСХ, ХХААХҮЯ

³¹НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ.

³²НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ.

Корреляцийн коэффициент нь хувьсагчдын хоорондох шугаман хамаарлын хүчийг хэмждэг бөгөөд утга нь +1 рүү ойртох тутам хоёр хүчин зүйлийн хооронд эерэг шугаман хамааралтай буюу нэг хувьсагчийн утга өсөхөд нөгөө хувьсагч дунджаараа өсөхийг харуулна. ХАА-н салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага ба хөдөлмөрийн бүтээмжийн корреляцийн коэффициент (R^2) нь 0.629 гэж гарчээ. Энэ нь салбарын төсвийн зарлага болон хөдөлмөрийн бүтээмжийн хооронд тодорхой түвшний эерэг хамаарал байгааг харуулж байна. Мөн шугаман хамаарлыг детерминацийн коэффициентээр (r^2) шинжилж үзэж болно. Энэ коэффициент нь [0,1]-ийн хооронд утгыг авах бөгөөд регрессийн тэгшитгэлийн хамаарах хувьсагчийн хэдэн хувийг үл хамаарах хувьсагч тайлбарлаж байгааг илэрхийлнэ. $r^2=1$ буюу 100% байвал х, у-ийн хооронд төгс шугаман хамаарлыг илтгэнэ. $r^2=0$ буюу 0% бол шугаман хамааралгүй гэж үздэг. Дээрх зургаас харахад детерминацийн коэффициент (r^2) нь 0.396 байгаа нь шугаман хамаарал сул байгааг илтгэж байна.³³

2.4.Үр дүнд суурилсан төсвийн зарлагын шинжилгээний арга зүйг нэвтрүүлэх

Төсвийн сайн удирдлага, үр дүнд суурилсан төлөвлөлт нь улс орны хөгжлийн үндэс суурь мөн. Сүүлийн жилүүдэд улс орнууд, Засгийн газар үр дүнд суурилсан үйл ажиллагаа, төсвийн удирдлагад өндөр ач холбогдол өгч, улс, орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг хэмжих, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй нягт уялдуулах чиглэлээр шинжлэх ухааны судалгаа, ололтод суурилсан гарын авлага, удирдамж боловсруулах, хэрэгжилтийг нь хангуулах, тохирсон арга аргачлалыг ашиглан төсвийн процесст хяналт тавих, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой сахилга хариуцлага, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэхийг эрмэлзэж байна.

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хурлаар Монгол Улсын Үндсэн хуульд Гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангахаар оруулсан өөрчлөлттэй уялдан Улсын Их Хурлын тухай хууль” болон “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдаж, Улсын Их Хурлын хянан шалгах механизмд чанарын ахиц дэвшил гарсан. Эдгээр хуулиудын холбогдох заалтуудын үзэл санаа төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгоход чиглэсэн.

Түүнчлэн 2021 оны 12 сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсан нь төсвийн хяналтаар дамжуулан үр дүнд суурилсан төсвийн сайн төлөвлөлт, удирдлагыг бэхжүүлэхэд томоохон дэмжлэг болохуйц бодит үйл явдал болсон.

Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтөд харгалзаж үзэх зүйл бол тухайн төлөвлөлтөд тусгагдсан үзүүлэлтүүдийн хүрээнд улс, орон нутгийн төсвийн орлого, зардал, тэнцэлд нөлөөлөх хүчин зүйлсийг аль болох өргөн хүрээнд хамруулан судалж, шинжлэх явдал юм.

Төсвийн төлөвлөлт үр дүнд суурилсан байдлаар хийгдсэн тохиолдолд юуны өмнө төсөл, арга хэмжээний үндсэн мэдээлэлтэй танилцах нь ач холбогдолтой байдаг. Үндсэн мэдээллийг хүснэгт 8-ын дагуу бэлдэж авах нь тухайн төсөл, арга хэмжээний талаар тодорхой мэдээлэлтэй болоход тусална.

³³ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ

Хүснэгт 8: Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үндсэн мэдээлэл

Үзүүлэлтүүд	Хөтөлбөр		Төсөл, арга хэмжээ	
	Хөтөлбөр 1	Хөтөлбөр 2	Төсөл, арга хэмжээ 1	Төсөл, арга хэмжээ 2
Төсвийн шатлал				
Хариуцагч байгууллага				
Хөтөлбөр/төсөл, арга хэмжээ/-ийн зорилго, нэр, байршил, онцлог				
Хөрөнгийн зардал /ХЗ/				
ХЗ-1				
ХЗ-2				
Урсгал зардал /УЗ/				
УЗ-1				
УЗ-2				
Үндсэн хөрөнгө				
Эргэлтийн хөрөнгө				
Холбогдох шийдвэрүүд				
Гүйцэтгэгч байгууллага				
Хүний нөөц				
Хэрэглэгч				
Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэл, эрсдлийн удирдлагын төлөвлөгөө				

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Төсөл, арга хэмжээнүүдээс хөтөлбөр, хөтөлбөрүүдээс ТЕЗ-ийн төсөв, ТЕЗ-ийн үр дүнгийн нэгтгэлээс салбарын үр дүн, салбаруудын үр дүнгийн нэгтгэлээс үндэсний үр дүн гардаг гэж үзэж болно. Тэгвэл төсөл, арга хэмжээний болон түүнээс салбарлаж гарсан бусад үр дүнг бодлогын бичиг баримтуудын холбогдох заалтад тусгагдсан үзүүлэлтүүд болон хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдтэй холбож, уялдааг гаргах нь төсвийн зарлагын шинжилгээний чухал бүрэлдэхүүн болох учиртай.

Түүнчлэн төсөл, арга хэмжээнээс гарсан үр дүнгүүдийг Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгасан үр дүнгийн үзүүлэлтүүдтэй уялдуулж үнэлэлт, дүгнэлт өгвөл, энэ нь төсвийн шинжилгээг салбарын болон үндэсний түвшинд нэгдмэл бөгөөд нарийвчлалтай хийгдсэн байх эрх ашигт нийцнэ. Хүснэгт 9-д зарлагын шинжилгээний хүрээнд бэлтгэх мэдээллийг агуулсан загварыг харуулав.

Хүснэгт 9: Төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт, бодлогын бичиг баримт, Төсвийн тухай хуультай уялдах уялдаа

Төсөл, арга хэмжээ	Хөтөлбөрийн үр дүн	ТЕЗ-ийн үр дүн	Салбарын үр дүн	Үндэсний үр дүн	Бодлогын үндэслэл /Холбогдох төсөл, арга хэмжээ, хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдтэй уялдсан байдал/	
					Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Шинэ сэргэлтийн бодлого Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт/

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Төсвийн зарлагын шинжилгээг бодлогын бичиг баримттай холбохоос гадна тухайн төсөл, арга хэмжээг дангаар нь авч үзэж, хэрэгжилтийг гаргах боломжтой. Төсвийн зардлын шинжилгээний хүрээнд төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шинжлэхэд хүснэгт 10 загварыг санал болгов.

Хүснэгт 10: Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Хэрэгжилт	Төсөвт өртөг	Санхүүжилт	
			Суурь түвшин	Зорилтот түвшин			Санхүүжилт	Санхүүжилтийн эх үүсвэр
			/2022 он/	/2024 он/	/2023 он/			
								Улсын төсөв Гадаад зээл Дотоод зээл Гадаад тусламж ТХХТ/концесс/ Орон нутаг/ ОНХС, суурь орлого, гадаад тусламж, бусад/

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

3. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙГ НЭГТГЭХ НЬ

Төсвийн зарлагын шинжилгээ нь зарлагыг хэмнэх боломжийг тодорхойлж, улсын төсвийн зарлагын үр ашиг, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх төрийн санхүүгийн удирдлагын чухал хэрэгсэл болдог. Төсвийн зарлагын шинжилгээний зорилго нь өргөн утгаараа төрийн эдийн засаг, нийгэм дэх оролцоо, үзүүлэх үр нөлөөг үнэлэх, гарч буй ахиц дэвшил, анхаарал татсан асуудлуудыг тодорхойлоход чиглэгддэг гэж хэлж болно. Дэлгэрүүлбэл, тус шинжилгээний хүрээнд өнгөрсөн цаг хугацааны төсвийн зарлагын нөлөөлөл, салбарын зорилттой уялдуулан хамгийн их нөлөө үзүүлж буй төсвийн зарлагын хуваарилалт, зарцуулалтыг шинжилж, төсвийн зарлагын үр нөлөө, үр ашиг, тэгш хүртээмжтэй байдал, мөнгөн хөрөнгийн хуваарилалтын өнөөгийн үнэ цэнийг сайжруулахад чиглэсэн нотолгоонд суурилсан зөвлөмжүүдийг нийтлэг байдлаар боловсруулдаг.

Төсвийн зарлагын шинжилгээ нь урт хугацаанд засгийн газрын зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болж, төрийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэх, төсвийн хуваарилалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашиг, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Төсвийн зарлагын шинжилгээг Засгийн газрын зорилттой уялдуулах, талуудын оролцоог идэвхжүүлэх, төсвийн зарлагын шинжилгээний үр дүнг хянах, шинжилгээний хүрээнд гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд төрийн оролцоо, улс төрийн үүрэг хариуцлага чухал үүрэгтэй бөгөөд улсын төсвийн стратегийн гол зорилго нь зөвхөн төсвийн алдагдал, үр ашгийн тухай асуудалд чиглэх төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтууд, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд оршдог байна.

Төсвийн зарлагын шинжилгээг хийхдээ юуны өмнө тухайн байгууллагын зорилго, зорилтуудыг тодорхойлж, хэмнэлтийн, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчмуудыг хангасан эсэхийг үнэлж, дүгнэх хэрэгтэй байдаг. Шинжилгээний зорилго, зорилтууд нь тодорхой бөгөөд ерөнхий агуулгаараа тухайн байгууллагын урт, дунд, богино хугацаанд хүрэхээр төлөвлөсөн үр дүнгүүд батлагдсан төсвийн зарцуулалтын хүрээнд биеллээ олсон эсэх, хуваарилалтын болон техникийн ямар үр ашигтай ажиллаж байгааг тус тус үнэлэхэд чиглэгддэг.

Төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлийн чанарт нөлөөлөх гол хүчин зүйлийг төсвийн зарлагын удирдлагыг хэрэгжүүлэгч институтийн тогтолцоо гэж үздэг. Төрийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн байгууллагаас 2014 онд төрийн санхүүгийн засаглалын талаар хийсэн судалгааны тайланд төсөвт байгууллагын засаглалд нөлөөлөх хүчин зүйлсийг дэлгэрэнгүй авч үзсэн байдаг. Энэхүү судалгааны үр дүнг хураангуйлан гарын авлагад тусгаж, төсвийн зарлагын шинжилгээний бүрэлдэхүүн хэсэгт оруулж өгсөн.

Иймд төсвийн зардлын шинжилгээг хийхдээ хамгийн түрүүнд зорилго, зорилтыг тодорхойлох нь чухал байдаг бөгөөд дэвшүүлсэн зорилго, зорилтоос хамаарч шинжилгээний ямар арга зүйг ашиглах эсэх талаар шийдвэрийг гаргадаг. Гэхдээ төсвийн ерөнхийлөн захирагч буюу төрийн захиргааны төв байгууллагын хувьд хугацааны тодорхой давтамжтайгаар төсвийн зарлагын ерөнхий шинжилгээг тогтмол хийж, хүрсэн үр дүн, төлөвлөсөн үр дүнгийн зөрүүг тодорхойлох, алдаа, дутагдал, ололт амжилтыг байнга тооцож, дараагийн нэгж хугацааны төлөвлөгөө, арга хэмжээний төлөвлөлтийн суурийг гаргаж байх нь нэн чухал. Энэхүү гарын авлага

ч үндсэндээ Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагуудад зориулсан онцлогтой болохыг дурдахад илүүц бус биз ээ.

Энэхүү гарын авлагад төсвийн зарлагын шинжилгээнд анхаарах гол зүйлүүдийг тусгасан онол, арга зүйгээс гадна олон улсын онцлог туршлагаудыг нэмэлтээр оруулж өгсөн нь төсвийн зарлагын шинжилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг болохуйц үзүүлэлт болсон гэж үзэж байна. Тухайлбал, тус гарын авлагад төсвийн цаглабар буюу төсвийн үйл явцтай төсвийн зарлагын шинжилгээг холбож, үр дүнг тухайн жилийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын бодлого, арга хэмжээнд тусгах, улс төрийн болон төрийн албан хаагчдын чиг үүргийг харилцан ялгаатайгаар авч үзэх, ил тод, нээлттэй байдлын зарчмыг хангасан байх зэрэг нь ямар ач холбогдолтой болохыг тайлбарлаж, төсвийн зарлагын шинжилгээний бэлтгэл үе шатаас эхлээд төсвийн зарлагын шинжилгээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, шинжилгээний үр дүнг түгээх үе шатуудад анхаарвал зохих арга, зарчмууд, ойлголтуудыг оруулж өгсөн болно.

Түүнчлэн төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн зарлагын шинжилгээг эхлүүлэх, гүйцэтгэх явцад дараах зүйлүүдийг анхаарах нь чухал байдаг байна. Үүнд:

- Төсөвлөсөн болон бодит зарлагын хэмжээний зөрүүг бууруулах зорилгоор салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, төрөөс үзүүлж буй үйлчилгээг салбарын онцлог шинж чанар, эрэлт, хэрэгцээнд тулгуурлан төсвийн зарцуулалтын хугацааг тогтоосны дараа төсвийн зарлагад дүн шинжилгээ хийх;
- Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, нөөц ашиглалтын үр ашгийг сайжруулах зорилгоор хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн техникийн төсөл, ажлын зурагтай танилцах;
- Худалдан авалтын үйл ажиллагаа болон санхүүгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, үндэсний болон орон нутгийн түвшинд төрийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг бэхжүүлэхэд зөвлөмж зааварчилгаа өгөх;
- Төсвийн зарлагын төлөвлөгөөнд заасан хөтөлбөрийн үр дүнг бататгахын тулд харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагаа явуулдаг салбарын яамд болон салбар хоорондын зохицуулалтын механизмыг сайжруулах арга замыг тусгах;
- Төсөв бодитой боловсруулагдаж байгаа эсэхийг үнэлэх, төсвийн зарлагын шинжилгээнд үндэслэн холбогдох төрийн бодлогыг боловсруулах талаар зөвлөмж, зааварчилгаа өгөх;
- Төсвийн зарлагын шинжилгээнд бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, үндэслэл, (мөн урт хугацаанд хэмнэлтийн горимд шилжих бол урт хугацааны зарлагын тооцоолол), хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг тусгасан байх;
- Дүн шинжилгээ, нотолгоонд суурилан зөвлөмжүүдийг боловсруулах, ингэхдээ тухайн салбар дахь төсвийн зарлагын шинжилгээнд төсвийн төлөвлөлт ба төрийн санхүүгийн удирдлагатай холбоотой шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц санал, зөвлөмжийг тусгасан байх;

- Зөвлөмжүүд нь дараах шаардлагыг хангасан байх; Үүнд:

- (i) тухайн улс орны нөхцөл байдалд хийгдсэн дүн шинжилгээнд үндэслэсэн байх;
- (ii) одоо хэрэгжиж буй санал, санаачилга дээр суурилах;
- (iii) Богино болон урт хугацаанд хэрэгжих;
- (iv) тухайн институт аль эсвэл олон нийтэд зориулсан зөвлөмжийг тусад нь боловсруулах;
- (v) агуулгын болон цаг хугацааны хувьд зохих дарааллыг хангаж, нэгтгэгдсэн байх.

Эцэст нь, Сангийн яамыг оруулаад бусад төрийн захиргааны төв байгууллагууд гарын авлагад хамруулсан зарлагын шинжилгээний арга зүйг ашиглан төсвийн зарлагыг өөр, өөрийн чиг үүргийн хүрээнд хийж, шийдвэр гаргалтдаа тусгаж байх, энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын чанарыг сайжруулах, бэлтгэл ажлыг хангаж, практикт бодит үйл хэрэг болгох нь чухал ач холбогдолтой.

ХАВСРАЛТ 1. ХҮСНЭГТ 11-14

Хүснэгт 11: Парламентын төсвийн шинжилгээний нэгжийн үүрэг /эх сурвалж/

№	Парламентын төсвийн шинжилгээний алба, улс орнуудаар	№	Парламентын төсвийн шинжилгээний алба, улс орнуудаар
1	Парламентын төсвийн албаны үйл ажиллагааны гарын авлага	11	Хойд Македони улсын төсвийн шинжилгээний нэгжийн гүйцэтгэх үүрэг
2	Төсвийн хариуцлагыг хөхиүлэн дэмжих нь	12	Энэтхэгийн төсвийн шинжилгээний нэгжийн гүйцэтгэх үүрэг
3	Өмнөд Африкийн Парламентын төсвийн алба	13	Төсвийн үйл явцад парламентын гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөх нь
4	Замби улсын төсвийн шинжилгээний нэгжийн гүйцэтгэх үүрэг	14	Итали
5	Ирландын төсвийн шинжилгээний нэгжийн гүйцэтгэх үүрэг	15	Конгрессын төсвийн алба (СВО)
6	Санал болгож буй парламентын төсвийн шинжилгээний нэгжийн гүйцэтгэх үүрэг	16	Хамтын ажиллагаатай орнуудын төсвийн шинжилгээний нэгжийн гүйцэтгэх үүрэг
7	Кени улсын парламентын төсвийн албаны үүрэг	17	Австрали, Их Британи, Канад орнуудын туршлага
8	Төсвийн шинжилгээний нэгжийн гүйцэтгэх үүрэг	18	Төсвийн хяналт болон төсвийн мөчлөг дэх парламентын төсвийн албаны үүрэг (Угандагийн туршлага)
9	Парламентын төсвийн шинжилгээний албан хаагчдын гүйцэтгэх үүрэг	19	Солонгос
10	Сьерра-Леон улсын төсвийн шинжилгээний нэгжийн үйл ажиллагаа	20	Ирланд

дүн шинжилгээ	дүн шинжилгээний асуулт	АРГА АРГАЧЛАЛ
---------------	-------------------------	---------------

Төсвийн зарлагыг тодорхойлох

Хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хийгдэх дүн шинжилгээ	- Хөтөлбөрийн гол зорилго нь юу вэ? - Төсвийн зарлагын үйл ажиллагаатай холбогдох төрийн бодлогын үндэслэл юу вэ? - Төсвийн зарлагын үйл ажиллагааны зорилго, үр дүн юу вэ?	Хөтөлбөр/арга хэмжээг тодорхойлох стратегийн зорилтууд: - Арга хэмжээний жагсаалт гаргах - Зорилтот бүлгийг тодорхойлох - Тухайн цаг үед уг хөтөлбөр/арга хэмжээг хэрэгжүүлж буй үндэслэлийг гаргах, цаашид авч хэрэгжүүлэх шинэчлэлийн үндэслэлийг тодорхойлох - Уг хөтөлбөр/арга хэмжээг стратегийн болон төлөвлөлтийн баримт бичигт тэргүүлэх ач холбогдолтой гэж тодорхойлсон эсэх
--	---	--

Төсвийн зарлагын шинжилгээ

Орц, гарцын шинжилгээ	Уг арга хэмжээ/хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн нь юу вэ? - Төсвийн зарлага нь ямар хэсгүүдээс бүрдэж байна вэ? - Төсвийн дийлэнх хэсэг нь аль салбарт илүү хуваарилагдаж байна вэ? - Олон төрлийн арга хэмжээнд зарлага хэрхэн хуваарилагддаг вэ? - Гарц/ үр дүн нь юу вэ? - Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардал хэд вэ?	Гарц/ үр дүн - Гарц буй гарц/үр дүнг тодорхойлох - Арга хэмжээ, зорилго, нэгж үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ цэнэ, өртөг тооцоолох нь Орц: - Ажилчдын тоо - Ажилчдын бүрэлдэхүүн Нийт зарлагын бүрэлдэхүүн хэсэг: - Эдийн засгийн ангиллаар (жишээ нь, ажилчдын нөхөн олговор, бараа, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт)
-----------------------	---	---

		• Засгийн газрын түвшинд (төв, орон нутгийн, нийгмийн хамгааллын сан) • Арга хэмжээгээр • Зорилгоор • Өртгийн тооцооллоор • Үйлдвэрлэлийн нэгжээр • Нэгж бүтээгдэхүүнд ногдох, нэг ажилтанд ногдох, зорилтот бүлэгт ногдох зардал Төсвийн зарлагын хуваарилалтын нөлөө: • Төсвийн зарлагын дүн шинжилгээ (орлогын түвшингээр зорилтот бүлгээр ангилах, орлогын бүлгээр нь хуваарилсан нөөцийн хүртээмжтэй байдал)
Зарлагын чиг хандлага	• Төсвийн зарлага өсөж байна уу, буурч байна уу? • Төсвийн зарлага түр хугацаагаар зогссон эсвэл гэнэт ихэссэн тохиолдол бий юу? • Төсвийн зарлагыг бүрдүүлж буй бүрэлдэхүүн хэсгүүд ижил хэмжээнд өсөх тохиолдол байсан уу? • Төсөвлөсөн хэмжээнээс тогтмол бага зарлага гардаг уу? • Төсөвлөсөн хэмжээнээс тогтмол их зарлага гардаг уу? • Төсөвлөсөн болон бодит зарлагын хооронд үүсэх нөхцөл байдлыг тайлбарлах (байгалийн гамшиг, хуулийн шийдвэр гэх мэт давагдашгүй хүчин зүйлсээс бусад тохиолдолд)	Төсвийн зарлагын дүн шинжилгээ: • Төсвийн зарлага болон түүнийг бүрдүүлж буй хэсгүүдийн өсөлтийн хувь • Төсөв болон бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн бодит зарлагын харьцуулалт • Төлөвлөгөө болон үр дүнгийн системчилсэн ялгаа (орц болон гарцын хувьд) • Нөхцөл байдлын хүчин зүйлсийн өөрчлөлт (технологийн хөгжил, орцын үнэ, олон улсын зах зээл дээр худалдаалагдаж буй бараа бүтээгдэхүүн, хууль эрх зүйн шийдвэр, олон улсын үүрэг амлалт гэх зэрэг)
Богино ба дунд хугацааны зарлагад нөлөөлөгч хүчин зүйлс	• Аль салбарт зарцуулагдах зарлагын хэмжээ ихээр өссөн байна вэ? • Тодорхой нэг хөгжлийн	Нийлүүлэлт талаас: • Төсвийн зарлагын зүйлийн нийт өсөлтийн оролцоог тооцоолох • Үзүүлсэн үйлчилгээний

	хэсгийн динамикийг харуулж байна уу? • Зарлага өсөж буй шалтгаан нь юу вэ? • Цаашид хэрхэн төлөвлөж байна вэ? Эрэлт хэрхэн өөрчлөгдөх төлөвтэй байна вэ?	хэмжээний тоон үзүүлэлтүүд (өргөдөл гаргагчийн тоо, зорилтот бүлгийн тоо, нэгжийн тоо гэх мэт). • Тоо хэмжээ болон үнийн задаргаа (жишээ нь, цалин хөлс, ажилчдын тоонд гарсан өөрчлөлт, цалингийн хувь хэмжээний өөрчлөлт; бараа, үйлчилгээний худалдан авалт, тоо хэмжээний өөрчлөлт, нэгжийн зардал гэх мэт) Эрэлт талаас: • Урт хугацааны зарлагын төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх (жишээлбэл, Европын холбооны орнуудад ажиллах насны хүн амын бүлэгт хийсэн тооцооллын шинжилгээ гэх мэт) • Хүн ам зүйн өөрчлөлтийн нөлөө • Бусад орчны хүчин зүйлээс шалтгаалсан эрэлтийн өөрчлөлт (технологийн шинэчлэл эсвэл орлогын өсөлт) • Шинэ хэрэгцээ үүсэх (хөдөлмөрийн нийлүүлэлтийн чиг хандлага)
Жишиг харьцуулалт	• Төсвийн зарлага нь олон улсын жишиг үзүүлэлттэй харьцуулахад ямар түвшинд байна вэ? • Дотооддоо тогтоосон жишиг харьцуулалтыг олон улсын түвшинд хэрхэн харьцуулах вэ?	• Олон улсын жишиг үнэлгээ (бусад улстай харьцуулах) (жишээлбэл, төсвийн зарцуулалт нь олон улсын жишиг үзүүлэлтээс 5, 10 эсвэл 15 хувиар их/бага байх). Ингэхдээ харьцуулах улс орнуудыг сонгохдоо орлогын түвшин, бүс нутаг, институт, нийгмийн ижил төстэй байдлыг харгалзан үзэх

		• Тэргүүлэгч орнуудыг тодорхойлж, ялгаатай байдлыг үнэлэх (төсвийн зарлага/үр дүнгийн ашигтай харьцааг тусгасан улс орнууд) • Бусад хот, төсвийн болон үйлдвэрлэлийн нэгжүүдийн хооронд жишиг харьцуулалт (зарлагын түвшин, зарлагын бүрэлдэхүүн хэсэг, орцын бүрэлдэхүүн хэсгийг харьцуулах). Жишээлбэл, нэг ажилтан, зорилтот бүлэгт ногдох үйлдвэрлэлийн дундаж зардал эсвэл ажлын бүтээмж, боловсон хүчний ур чадварыг зэргийг харьцуулах
--	--	--

Хөтөлбөрийн үнэлгээ

Төсвийн зарлагын зохистой байдлыг үнэлэх нь	• Арга хэмжээ нь засгийн газрын тэргүүлэх чиглэл мөн үү? • Уг арга хэмжээг хэрэгжүүлэх болсон хэрэгцээ шаардлага одоо бий юу?	• Бодлогын зорилго эсвэл стратегийн тэргүүлэх чиглэлийн талаарх засгийн газраас хийсэн мэдэгдэл • Бүтээгдэхүүний гарцын талаарх эрэлтэд суурилсан мэдээлэл • Хөтөлбөр хэрэгжихэд нөлөөлөх орчны хүчин зүйлс (технологийн шинэчлэл, үйл явц, нийгмийн давуу байдал, ажлын арга барилд гарсан өөрчлөлт, хэрэгцээ, шаардлага)

Төсвийн зарлагын үр ашгийг үнэлэх нь	• Арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарлага хэмнэж байна уу? • Ижил төрлийн арга хэмжээг бага зардлаар хэрэгжүүлж болох уу? • Хэрэглэгчид илүү төлбөр төлөх боломж бий юу? • Засгийн газраас хэрэгжүүлж буй бусад хөтөлбөртэй давхцаж байна уу?	• Ижил (эсвэл төстэй) хөтөлбөрийг хэрэгжүүлж буй нэгжүүдийн (яам, хотын захиргаа) нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх дундаж өртгийг харьцуулах. • Ижил төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн байгууллагатай дундаж зардлыг харьцуулах • Ижил бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой бусад технологийг судлах • Ажлын цаг ашиглалт, боловсон хүчний ур чадварын бүтцийг хянах гэх мэт • Нийт зарлагын нэг хэсгийг бүрдүүлэгч, хэрэглэгчээс авч буй хураамжийн түвшин, динамикийг судлах • Хэрэглэгчээс авч буй үйлчилгээний хураамж нь орлогын ялгаатай бүлгүүдийн дунд хэрхэн хуваарилагдаж байгааг судлах • Ижил зорилгод хүрэхээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн арга хэмжээ, үр дүнг тодорхойлох (бусад яамнууд, засгийн газрын түвшинд) • Бүрэн ашиглагдахгүй байгаа (капиталын болон материаллаг) нөөцийг тодорхойлох арга хэмжээ авах
Төсвийн зарлагын үр дүнтэй байдлыг үнэлэх нь	Уг арга хэмжээний зорилго нь юу вэ? • Уг арга хэмжээ нь бодлогын зорилттой нийцэж байна уу? • Хөтөлбөрийн зохион байгуулалт зохистой байна уу?	• Зорилтот бүлэгт зарцуулагдаж буй төсвийн зарлагын хэмжээг үнэлэх (нийт зарлагыг зорилтот бүлэгт зарцуулсан зарлагатай харьцуулах) • Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлснээр гарсан амжилт, төлөвлөсөн үр дүнг үнэлэх

Хүснэгт 13: ТЗШ-ний өгөгдөлд тавигдах шаардлага, шинжилгээний төрлүүд, зөвлөмж, эх сурвалж

Төсвийн зарлагын шинжилгээ хийхэд төсвийн мөчлөг бүрээр ТЗШ-ний хамрах хүрээ, өгөгдөлд тавигдах шаардлага өөр байх бөгөөд холбогдох шинжилгээний төрлүүдийг зөвлөмжийн хамт багцлан дор харуулсан болно.

Төсвийн мөчлөг	Төсвийн зарлагын шинжилгээний хамрах хүрээ/ Асуултууд	Өгөгдөлд тавигдах шаардлага	Шинжилгээний төрлүүд	Зөвлөмж	Эх сурвалж
Төсвийн зарлагын зорилт ба стратеги					
Салбарын зорилт ба стратеги	Асуулт: Засгийн газрын үндэсний болон салбарын зорилт, стратеги юу вэ? Бодлогын орчин хөрөнгө оруулалтын өгөөжийг бий болгож чадаж байна уу?	Засгийн газрын зорилт: ХАА-н өсөлт, Хүнсний аюулгүй байдал Ядуурлыг Бууруулах Стратегийн бүрэлдэхүүн хэсгүүд Бодлогууд- Цэвэр татвар	Тойм шинжилгээ Гүйцэтгэлийн харьцуулалт	Стратегийн зохицуулалтууд Бодлогын сайжруулалтаас гарах боломжит ашиг, Төсвийн зарцуулалт	Салбарын тойм Стратегийн шинэчлэлтүүд
Төсвийн зарлагын хуваарилалтын үр ашиг					
Төсвийн хуваарилалт	Хамрах хүрээ: Хамрах хүрээ өргөн байх тусам хуваарилалтын үр ашгийн шинжилгээний хамрах хүрээ илүү өргөн байна. Төсвийн зардлын хуваарилалтын үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх вэ? (Зөв зүйлд мөнгөө хуваарилж чадаж байна уу?) Төсвийн үйл явцэд холбогдох талууд одоогийн үр ашгийн түвшинд хэрхэн хүрсэн бэ?	Төсвийн хуваарилалтын түвшин: Функциональ бүрэлдэхүүнийг хөгжүүлэх, Урсгал хөрөнгийн, цалингийн түвшин г.м, Төр болон хувийн хэвшил, Үндэсний ба аймаг, дүүргүүдийг хамрах г.м	Энгийн индуктив шинжилгээ Энгийн нийцлийн шинжилгээ Ахиу өгөөжийг тооцоолох шинжилгээ	Зардлын өөрчлөлт Зардлын ангилал дахь хуваарилалт	Яам/ Орон нутгийн удирдлагын Төсвийн удирдамж Хуваарилалтын шийдвэрүүд гаргахад ашиглагдсан томъёо Салбарын тоймын холбоос линк
Төсвийн зарлагын техникийн үр ашиг					
Төсвийн гүйцэтгэл	Хамрах хүрээ: Олон сэдвийг хамарсан тохиолдолд техникийн үр ашгийн шинжилгээ мөн өргөн хүрээг хамарна. Асуулт: Төсвийн зардлын техникийн үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх вэ? (Хэрэгжүүлэлт нь үр дүнтэй юу?) Төсвийн үйл явцын ямар талууд одоогийн үр ашгийн түвшинд хүргэсэн бэ?	Төсвийн гүйцэтгэл: Төсөвлөсөн, хуваарилсан ба бодит Зарцуулах хугацаа Үзүүлэлтүүд: Төрийн үйлчилгээний чанар	Төсвийн зарлагыг хянах Зардлын үр ашиг	Төсвийн мэдээ Техникийн зураг төсөл Худалдан авалт (итгэлцлийн чадаах)	Сангийн яамны төсөв Дэд хөтөлбөрүүдийн удирдлагын тойм Хөдөө аж ахуйн яам/ Төслийн орон нутгийн удирдлагын удирдамж Үнэлгээний сургалт ба Хүний нөөцийн төлөвлөгөө
Төсвийн зарлагын хариуцлагатай байдал					
Хяналт- шинжилгээ, үнэлгээ	Асуулт: Гүйцэтгэлийг хэмжихэд ямар үзүүлэлтийг ашигладаг вэ? Төсвийн зарцуулалтын үр дүнг хэн хариуцах вэ? Хариуцлагыг хэнд оногдуулах вэ?	Төрийн үйлчилгээний нөлөөлөл, хамрах хүрээ Оролцогч талуудад хариуцлага хүлээлгэх албан ёсны сувгууд	Тохиолдлын шинжилгээ Нөлөөллийн үнэлгээ	Зорилтот хөтөлбөр Хэрэгжүүлэлт Хариуцлагын механизмуд	Яам/ Орон нутгийн удирдлагын Төсвийн удирдамж Яамны Хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоо

ХАВСРАЛТ 2.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙН ӨРТГИЙГ ТООЦООЛОХ НЬ

Төсвийн зарлагын шинжилгээнд бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, (мөн урт хугацаанд хэмнэлтийн горимд шилжих бол урт хугацааны зарлагын тооцоолол), хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг тусгасан байх ёстой. Зарим тохиолдолд төсвийн зарлагын шинжилгээ хийж буй ажлын хэсэг хөтөлбөрөөс хамааран нэг буюу түүнээс дээш бодлогын хувилбарыг санал болгож болно.³⁴

Жишээлбэл, төсвийн зарлагын шинжилгээний төсөл нь нийгэм эдийн засгийн үр нөлөө бүхий салбарт хийгдэж байгаа бол орлогын түвшин, мөнгөний бодлогын хүү зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Доорх загвар нь шийдвэр гаргагчдад зориулсан төсвийн зарлагын шинжилгээний жишээ юм.

Төсвийн үр нөлөө (саяар)	t	T+1	T+2	T+2	Нийт	Санал болгож буй хувилбар болон үндэслэл
Бодлогын өөрчлөлтийн үр дүнд гарч буй зарлага (-) хэмнэлт (+)						
Бодлогын баримт бичгийн төсөл А – Бодлогын өөрчлөлтөөс гарсан үр дүн						
Бодлогын баримт бичгийн төсөл В – Бодлогын өөрчлөлтөөс гарсан үр дүн						
Бодлогын баримт бичгийн төсөл С – Бодлогын өөрчлөлтөөс гарсан үр дүн						
Хөтөлбөрийн нийт төсөв (одоогийн баримталж буй бодлогод үндэслэн)						

³⁴ ОУВС. 2022. Төсвийн зарлагын шинжилгээг хэрхэн хийх вэ?

Бодлогын тухай тайлбар

Бодлогын үндэслэл: Бодлогын баримт бичгийн төслийн саналын үндэслэлийг тайлбарлана. (ажлын хэсгийн гүйцэтгэсэн төсвийн зарлагын шинжилгээний үр дүнд гарсан байх)

Оролцогч талууд: Бодлогын өөрчлөлт нь оролцогч талуудад хэрхэн нөлөөлөхийг тодорхойлохдоо дараах асуултуудад хариулна.

- Бодлогын өөрчлөлт нь хэнд, хэрхэн нөлөөлөх вэ?
- Оролцогч талуудад үзүүлэх санхүүгийн нөлөөлөл/боломжит зардал юу байх вэ?
- Бодлогын хэрэгжилтийн үр дүнд гарах нийгэм/эдийн засгийн үр дагавар?

Бусад үр дагаврууд: Бусад үр дагаврыг тооцохдоо доорх асуултуудад хариулна.

- Урт хугацаанд гарах боломжит хэмнэлтийн нөлөө юу вэ?
- Бүс нутгийн болон салбарын онцлогийг харгалзан үзсэн үү?
- Бусад төсөл хөтөлбөрүүдэд үзүүлэх нөлөөлөл, түүний үр дагавар нь юу вэ?
- Тухайн бодлого нь бусад гэрээ хэлэлцээртэй нийцэж байна уу?

Бодлогын хэрэгжилт: Бодлогын хэрэгжилттэй холбоотой асуудлыг харгалзан үзэхдээ дараах асуултуудад хариулна.

- Хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай юу?
Батлагдах эцсийн хугацаа хэзээ вэ?
- Институтийн өөрчлөлт хийх шаардлагатай юу?
- Хэрэгжүүлэхийн өмнө гуравдагч талтай зөвлөлдөх,
хэлэлцээр хийх шаардлагатай юу?
- Тухайн хэлтсийн нөөц бүрдүүлэлтэд нөлөөлөл үзүүлэх үү?
- Хэрэгжүүлэхэд хэр их хугацаа шаардлагатай вэ?

Монгол хэл дээр

Бямбажавын Энх-Амгалан, Гэнэнгийн Элдэв-Очир, Элдэв-Очирын Эрдэнэчимэг. 2013. Эконометрик

Монгол Улсын Төсвийн тухайн хууль 2011

Монгол Улсын Шилэн дансны тухай хууль 2011

Монгол Улсын Сангийн яам, 2022. “Иргэдийн төсөв-2023”

Монгол Улсын Сангийн яам, Дэлхийн банк, 2006. Монгол Улсын 2005 оны Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн мэргэжлийн шинжилгээ

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр “Төсвийн хяналт, шинжилгээ” Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан гарын авлага

Төсөв, төсвийн бодлого гэж юу вэ? 2017

Англи хэл дээр

Anson, R., and E. Zegarra. 2008. Honduras: Public Expenditure Assessment and Strategy for an Enhanced Agricultural and Forestry Sector. Prepared for the Joint DFID/World

Bank Partnership on Agriculture Public Expenditure Review in collaboration with RUTA.

Correa, P. 2014. Public Expenditure Reviews in Science, Technology, and Innovation.

Devarajan, S., V. Swaroop, and H. Zou. 1996. “The Composition of Public Expenditure and Economic Growth.” *Journal of Monetary Economics*, vol. 37, 313–44.

European commission, Directorate-General for Economic and Financial Affairs. 2014.

Public spending reviews design, conduct, implementation

Ghana. 2013. Final report basic agricultural public expenditure diagnostic review.

IMF. 2022. How to design and institutionalize spending reviews INTOSAI. ISSAI 300

Kolavalli, S., R. Birner, S. Benin, L. Horowitz, S. Babu, K. Asenso-Okyere, N. M. Thompson, and J. Poku. 2009. “Public Expenditure and Institutional Review.” Ghana’s Ministry of Food and Agriculture. Ghana Strategy Support Program (GSSP) Background Paper 17.

Washington, DC: International Food Policy Research Institute.

Mandl, U., Dierx, A., & Ilzkovitz, F. 2008. the effectiveness and efficiency of public spending.

OECD. 2021. Applying Evaluation Criteria Thoughtfully, OECD Publishing, Paris Organisation for Economic Co-operation and Development (OECD). 2019a. “Budgeting and Public Expenditures in OECD Countries 2019.” Paris.

Pradhan, S. 1996. "Evaluating Public Spending: A Framework for Public Expenditure Reviews."

World Bank Discussion Papers 323. Washington, DC: The World Bank.

Shah, A. 2005. Public expenditure analysis.

UN ECLAC. 2017. A manual on the design and conduct of public expenditure reviews in Caribbean countries.

World Bank. 2001. "Turkey Public Expenditure and Institutional Review." Reforming Budgetary Institutions for Effective Government, Report No. 22530-TU. Washington, DC: The World Bank.

World Bank. 2003. "India Revitalizing Punjab's Agriculture." Report No. 37069. Washington, DC: The World Bank.

World Bank. 2005a. "Turkey Policy and Investment Priorities for Agriculture and Rural Development." ECSSD/ECA. Washington, DC: The World Bank

World Bank. 2010b. "Uganda: Agriculture Public Expenditure Review." Report No. 53702-UG. Washington, DC: The World Bank.

World Bank. 2010c. "Lebanon Agriculture Sector Note: Aligning Public Expenditures with Comparative Advantage." Washington, DC: The World Bank.

World bank. 2011. How do we improve public expenditure in agriculture?

World bank. 2011. Practitioners' toolkit for agriculture public expenditure analysis

World bank. 2014. 'Climate Change Public Expenditure and Institutional Review Sourcebook', Climate Change Public Expenditure and Institutional Review Sourcebook.

World bank. 2017. Education public review guidelines.

<https://view.officeapps.live.com/op/view.aspx?src>

<https://www.oecd.org/gov/budgeting/Parliament-role-in-budgeting.pdf>

<https://www.parliament.gov.za/parliamentary-budget-office>

<https://www.parliament.gov.zm/node/8325>

<https://www.oireachtas.ie/en/how-parliament-is-run/houses-of-the-oireachtas-service/>

[parliamentary-budget-office/](#)

<https://www.aph.gov.au>

<https://afrocave.com/parliamentary-budget-office-kenya/>

<https://parlzim.gov.zw/download/parliament-budget-office/>

https://en.wikipedia.org/wiki/Parliamentary_Budget_Officer

<https://www.parliament.gov.sl/parliamentary-budget-office.html>

<https://www.wfd.org/2020/09/21/parliamentary-budget-office-in-north-macedoniapresents-their-work-and-their-first-analysis-to-new-mps/>

<https://www.iasparliament.com/current-affairs/parliamentary-budget-office>

The Changing Role of Parliament in the Budget Process

<https://en.upbilancio.it/about-the-pbo/>

<https://www.house.gov/the-house-explained/legislative-branch-partners/congressional-budget-office>

Role of the proposed Parliamentary Budget Office

Functions and Objectives of PBO

БНСУ-ын үндэсний ассамблейн төсвийн албаны талаарх мэдээлэл

The Parliamentary Budget Office (PBO) has been established on a statutory basis by the Houses of the Oireachtas Commission (Amendment) Act 2018.

<https://documents1.worldbank.org/curated/en/940921532366222268/pdf/128662-REVISED-WP-P161180-PUBLIC-NSPENDINGREVIEWMANUALJun.pdf>

<https://www.oecd.org/gov/budgeting/spending-reviews-towards-best-practices.pdf>

<https://www.jrf.org.uk/sites/default/files/jrf/migrated/files/1898531862.pdf>

The Evolving Functions and Organization of Finance Ministries; by Richard Allen, Yasemin Hurcan, Peter Murphy, Maximilien Queyranne, and Sami Yläoutinen; IMF Working Paper WP/15/232; November 2015

<https://www.devex.com/organizations/ministry-of-development-planning-bolivia-123144>

https://www.mofnp.gov.zm/?page_id=2981

<https://www.mofa.gov.mn/structure>

<https://www.slideshare.net/OECD-GOV/finance-function-in-line-ministries-jn-blndaloecd>

<https://documents1.worldbank.org/curated/en/940921532366222268/pdf/128662-REVISED-WP-P161180-PUBLIC-NSPENDINGREVIEWMANUALJun.pdf>

<https://www.ifac.org/knowledge-gateway/supporting-international-standards/publications/>

international-framework-good-governance-public-sector

<https://www.oecd.org/gov/budgeting/spending-reviews-towards-best-practices.pdf>

